



МАНДАЛ  
даатгал

# Жилийн тайлан 2019




05

МАНДАЛЫН  
ТОЙМ

33

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ҮНДСЭН ФУНКЦҮУД



23

МАНДАЛЫН  
БИЗНЕС

65

МАНДАЛЫН  
ЗАСАГЛАЛ

- ◆ 2019 оны онцлох үзүүлэлтүүд
- ◆ Зах зээлийн нөхцөл байдал
- ◆ Удирдлагын мэндчилгээ
- ◆ Санхүүгийн голлох үзүүлэлтүүд

# 01 МАНДАЛЫН ТОЙМ

# 2019 ОНЫ ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мандал даатгал нь мөнгөн хөрөнгө, цэвэр ашгийн хэмжээгээр салбартаа тэргүүлээ.



\* Нийлмэл харьцаа: Үйл ажиллагааны зардал болон цэвэр нөхөн төлбөрийг орлогод тооцсон хураамжид харьцуулан тооцдог үзүүлэлт.

Мандал даатгал нь 2019 онд компанийн суурь чадамжуудыг дээшлүүлж, үйл ажиллагааг сайжруулснаар нөхөн төлбөр шийдвэрлэх хурдыг **2 дахин сайжруулж**, харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүллээ.

## 2019 оны онцлох үйл явдал:

- 5.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, өмнөх оноос 52 хувийн өсөлт үзүүллээ. Тайлант хугацаанд мөнгөн хөрөнгийн хэмжээ 23 хувь, нийт хөрөнгийн хэмжээ 21 хувь өссөн үзүүлэлттэй байна.
- Хөрөнгийн зах зээл дэх арилжааны идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдөр компанийн нэгж хувьцааг 100 хуваалаа.
- Insurance Asia сэтгүүлээс даатгалын салбарын оны шилдэг компаниудыг шалгаруулж олон нийтэд хүргэдэг “Insurance Asia Award 2019” арга хэмжээнээс Мандал даатгал “Дотоодын шилдэг даатгагч” төрөлд шалгарсан нь Монгол улсаас анхдагч боллоо.
- 2019 оны 10 дугаар сард олон улсын даатгалын зэрэглэл тогтоогч байгууллага болох А.М Best-ийн А+ үнэлгээтэй Францын давхар даатгагч SCOR компанитай Трийти багцын давхар даатгалын гэрээ байгуулав.
- Компанийн хэмжээнд үйл ажиллагааны процессыг сайжруулахаар “Бизнес процесс реинженеринг” төслийг амжилттай хэрэгжүүлж, бүртгэлийн процессуудыг оновчилж, борлуулалт, нөхөн төлбөр, үйлчилгээний хурдыг нэмэгдүүллээ.
- Харилцагч нартаа зориулан даатгалын үйлчилгээг гар утсаараа авч болох олон үйлдэлт, ухаалаг МАНДАЛ АПП мобайл аппликэйшнийг үйл ажиллагаандаа нэвтрүүлээ.
- 2019 онд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн (ТУЗ) шийдвэрээр компанидаа олон жил идэвх зүтгэлтэй ажилласан, онцгой хувь нэмэр оруулсан 8 ажилтанд 125 сая төгрөгийн хувьцааг эзэмшүүлэв.
- 2019 онд ТУЗ-ийн шийдвэрээр компанийн 2018 оны цэвэр ашгаас нийт 624.3 сая төгрөг буюу компанийн нэгж хувьцаанд 100 төгрөгийн ногдол ашгийг хуваариллаа.




# ЗАХ ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

## ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Эдийн засгийн ерөнхий төлөв өнгөрсөн онд харьцангуй тогтвортой байлаа. Эдийн засгийн өсөлт оны эцсийн байдлаар 5.1 хувьтай гарсан ба үүнд боловсруулах үйлдвэрлэл болон санхүүгийн салбар голлох нөлөөг үзүүлсэн юм. Ийнхүү, гурав дах жилдээ дараалан Монгол Улсын эдийн засаг 5 хувиас өндөр өсөлттэй гарлаа.

### ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРУУДЫН ӨСӨЛТ, 2019 он



Эх сурвалж: ҮСХ

Эдийн засгийн өсөлт тогтвортой өндөр байхад нөлөөлсөн гол хүчин зүйл нь голлох экспортын бараанууд болох зэс, нүүрсний экспорт өндөр байсан явдал юм. Үүнээс улбаалан гадаад худалдааны тэнцэл өнгөрсөн онд 1.5 тэрбум ам.долларын ашигтай гарч, гадаад шууд хөрөнгө оруулалт 2.1 тэрбум ам.долларт, гадаад валютын нөөц 4.3 тэрбум ам.долларт хүрсэн. Цаашлаад төгрөгийн бусад валюттай харьцах ханш харьцангуй тогтвортой байлаа. Эдийн засгийн идэвхжил нэмэгдэх үед инфляц өсөх сөрөг нөлөө гардаг. Гэхдээ Төв банкнаас нөхцөл байдлыг урьдчилан харж, 2018 онд мөнгөний бодлогыг чангаруулах чиглэлд арга хэмжээ авснаар 2019 онд инфляцыг 8.1 хувиас бууруулан 5.5 хувьд тогтоож чадлаа.

Өнгөрсөн он бизнесийн байгууллага болон өрхийн амьдралд таатай жил болон өнгөрлөө.

Эдгээр үзүүлэлтүүд нь өрхийн аж амьдралд эерэгээр нөлөөлж, өрхийн бодит орлогыг 9.9 хувиар өсгөсөн байна.

Хэдий эдийн засгийн хувьд эерэг он жилүүд өнгөрсөн ч цаашдын төлөв сайнгүй харагдаж байна. Коронавирустай (COVID-19) холбоотойгоор дэлхийн эдийн засагт томоохон аюул нүүрлээд буй. Үүнтэй холбоотойгоор дэлхийн эдийн засгийн таамаглалууд мөн буурсан. Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын гаргасан судалгааны дагуу 2020 оны эцэст дэлхийн эдийн засгийн өсөлт 2.4 байхаар хүлээгдэж байна.

Энэ нь өмнөх таамаглалаас даруй 0.5 хувиар буурсан үзүүлэлт юм. Харин манай улсын хувьд эдийн засгийн өсөлтийг 0.5 – 1.5 хувиар бууруулах талаар Азийн хөгжлийн банкны судалгаа харуулсан. Улмаар олон улсын байгууллагуудын таамаглалын дундаж болон шинэ нөхцөл байдлаас үүдэн Монгол Улсын эдийн засгийн өсөлт 3 – 4 хувь байхаар харагдаж байна.

Ирэх онуудад эдийн засгийн өсөлт 3 – 4 хувьд хэлбэлзэх төлөвтэй байна.

## ДААТГАЛЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2019 оны эдийн засгийн нөхцөл байдал таатай байсантай уялдан даатгалын салбарт ч өндөр өсөлтүүд гарлаа.

**366** тэрбум

### ДААТГАЛЫН САЛБАРЫН АКТИВ, тэрбум төгрөгөөр




**199** тэрбум

### ДААТГАЛЫН САЛБАРЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: ҮСХ


Тухайлбал, 2019 оны байдлаар даатгалын компаниудын нийт актив жилийн 10.2 хувиар, хураамжийн орлого 11.2 хувиар тус тус өслөө.



Түүнчлэн, эдийн засгийн нөхцөл байдлаас гадна жил бүр иргэдийн эрсдэлийн талаарх мэдлэг нэмэгдэж, даатгалын бүтээгдэхүүнийг сонгох хандлага өссөөр байна.

Мөн салбарын өсөлт явагдаж буйтай холбоотойгоор даатгалын компаниудын эрсдэл даах чадвар улам бүр нэмэгдсэн бөгөөд үүнийг нөөц сангийн өсөлтөөс харах боломжтой юм. Тус үзүүлэлт нь сүүлийн 5 жилийн хугацаанд 2.5 дахин нэмэгдсэн буюу жилд дунджаар 30 хувиар өслөө.

**НӨӨЦ САНГИЙН ХЭМЖЭЭ БА ӨСӨЛТ**



Эх сурвалж: ҮСХ


Нэг талаас эдийн засгийн өсөлт, нөгөө талаас зах зээлийн эрсдэлийн тухай ойлголт нэмэгдэж буй нь даатгалын салбарт том дэмжлэг болж байна.

**Даатгалын салбарын өсөлтийн боломж**

Сүүлийн гурван жилийн хугацаанд даатгалын салбарын өсөлт өндөр байгаа хэдий ч энэ нь хөгжлийнхөө дөнгөж эхэн үедээ явж байгааг дурдах нь зүйтэй. Статистик үзүүлэлтүүдийг харвал даатгалын салбар нь Монгол Улсын санхүүгийн секторын 0.9 хувийг эзэлдэг. Даатгалын нийт хураамжийн орлогын ДНБ-д эзлэх хувь буюу даатгалын нэвтрэлтийн түвшин ердөө 0.5 хувь байна. Эдгээр үзүүлэлтийг бусад улсуудтай харьцуулбал Монголын даатгалын салбар 10 дахин өсөх боломж харагдаж байгаа юм.

Бусад салбаруудаас илүүтэйгээр даатгалын салбар нь эдийн засгийн нөхцөл байдалтай хамаарал өндөр. Сүүлийн 10 жилийн хугацааны тоон үзүүлэлтээс харвал эдийн засгийн өсөлт 1 нэгж хувиар нэмэгдэхэд даатгалын хураамжийн орлого 7 нэгж хувиар нэмэгддэг байна. Олон улсын судалгааны байгууллагуудын гаргасан Монголын эдийн засгийн төсөөлөлд үндэслэн даатгалын салбарын өсөлтийг таамаглавал ирэх онуудад 10 – 20 хувийн өсөлт үзүүлэх дүр зураг ажиглагдаж байна.

**ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ БА ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГЫН ӨСӨЛТИЙН ХАМААРАЛ**



Эх сурвалж: ҮСХ

Нэг талаасаа эдийн засгийн өсөлт нь даатгалын салбарыг дэмжиж, нөгөө талаасаа даатгалын салбар нь нийгэм, эдийн засагт эерэг нөлөөллүүдийг бий болгодог. Тухайлбал:

1. Эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлдэг
2. Санхүүгийн зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагч болж санхүүжилтын хэрэгцээг хангадаг
3. Иргэдийг хуримтлалтай байлгах боломж олгодог
4. Томоохон эрсдэлүүдээс хамгаалдаг
5. Эдийн засгийн өсөлтийг дэмждэг зэрэг нөлөөллүүд байна.

Тийм ч болохоор даатгалын салбарыг улсын хөгжилд чухал ач холбогдолтойг онцолж удирдах байгууллагуудын зүгээс тодорхой бодлогуудаар дэмжин ажиллаж байна. Улмаар даатгалын салбар нь санхүүгийн салбарын хүчтэй багана болох цаг өдөр ирэх тусам ойртсоор байна.

# МАНДАЛЫН АЛСЫН ХАРАА ЭРХЭМ ЗОРИЛГО

## АЛСЫН ХАРАА

Азийн тавцанд өрсөлдөх даатгал,  
санхүүгийн олон улсын брэндийг  
бий болгох

Мандал даатгал үүсгэн байгуулагдсанаасаа хойш харьцангуй богино хугацаанд салбартаа тэргүүлэгч даатгалын компани болсон төдийгүй Мандал даатгалын алсын хараа нь зөвхөн Монголын шилдэг даатгалын компани болсноор хязгаарлагдахгүй, Азийн орнуудын зах зээлд гарч өрсөлдөх Монгол брэндийг бий болгох явдал юм.

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Өнөөдрөө баталгаажуулсан  
маргаашийг иргэн бүрд

Даатгалын компанийн нийгэмд оруулж буй хамгийн том хувь нэмэр нь иргэдийг гэнэтийн эрсдэлээс үүдэн бий болох санхүүгийн хохиролд өртөхөөс хамгаалж, амьдралын хэмнэлийг нь баталгаажуулах явдал юм.

Мандал даатгал нь хувь хүн, өрх гэр, албан байгууллага тус бүр өнөөдрийг хүртэл бий болгосон өөрийн баялгийг тулгарч болох эрсдэлээс хамгаалан, маргаашийнхаа зорилгын төлөө ажиллаж, амьдардаг сайхан нийгмийг даатгалаараа дамжуулан бүтээхийг зорьдог.

Мандал даатгалын алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс нь бидний хийж буй ажил, гаргаж буй шийдвэр бүрийн суурь нь болдог.

## ҮНЭТ ЗҮЙЛС БА ЗАРЧИМ



### Нэг баг, нэг Мандал

- Хүндэтгэл олж ав
- Багтайгаа зөвлөж ярилц
- Дандаа манлайл
- No sugar coating
- Ёс зүйтэй бай
- Талархаж сур



### Үргэлж түүчээл

- Өөрийгөө хөгжүүл
- Шинийг санаачил
- Хайрцагнаас гарч сэтгэ
- Битгий бууж өг
- Өөрийгөө сорь
- Бүтээмжийг нэмэгдүүл



### Үйл хэрэгтээ тууштай бай

- Цагийн юмыг цагт нь
- Амлалтандаа хүр
- Хариуцлагаа хүлээ
- Зорилготой, утга учиртай бай
- Дуустал нь хий
- Мэргэжлийн бай



### Харилцагч нэн түрүүнд

- Харилцагч бол хаана ч, хэзээ ч бидний харилцагч хэвээр байна гэдгийг ухамсарла
- Компанийн ажил бүр харилцагчийн төлөө байна гэдгийг санаж яв
- Харилцагчийн оронд өөрийгөө тавь
- Харилцагчаа сонс
- Харилцагчийн хүлээлтээс давахыг зорь
- Харилцагчийн төгс төгөлдөр зөвлөгч нь бай



# Өлзийбаярын ГАНЗОРИГ

Төлөөлөн удирдлах зөвлөлийн дарга,  
Үүсгэн байгуулагч

## ЭРХЭМ ХҮНДЭТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ЭЭ

**Н**ийт Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийнхээ нэрийн өмнөөс та бүгдэд мэндчилгээ дэвшүүлж байна.

Мандал даатгал хувьцаат компани маань 2019 онд өмнөх онуудад гаргасан амжилтаа бататгаж нийт хөрөнгө, мөнгөн хөрөнгө, цэвэр ашиг, борлуулалтын орлогын хэмжээгээ нэмэгдүүллээ. Бид 2019 онд 28.9 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлж, үүнээс 6.5 тэрбум төгрөгийн татварын өмнөх цэвэр ашигтай ажилласан байна. Энэ онд бид улсад 665 сая төгрөгийн татвар төлжээ.

Мөн энэ онд харилцагчдын тоо 81,204 хүрч, нийтдээ 10,564 нөхөн төлбөрийн тохиолдлыг шийдвэрлэжээ. Өөрөөр хэлбэл энэ тооны харилцагч иргэд, компаниудын эрсдэлийн асуудлыг нь шийдвэрлэж өгөв. Та бүгдийн хувьцааг нь эзэмшиж байгаа компани даатгалын салбарыг ашиг болон чанарын олон үзүүлэлтээр тэргүүлж байгааг дуулгахад таатай байна. Энэ онд бид Insurance Asia сэтгүүлээс Монголын шилдэг даатгалын компаниар шалгарч, цом авсан нь даатгуулагч иргэд, харилцагч компаниудын маань бидэнд өгсөн үнэлгээ гэж ойлгож байгаа билээ.

Бид эрсдэлийн зохистой бодлого хэрэгжүүлж, эрсдэлийг тархаан байршуулах зорилгоор олон улсын нэр хүнд бүхий давхар даатгалын компаниудаар даатгуулдаг билээ. 2019 онд

бид шинээр А+ үнэлгээтэй, Франц Улсын давхар даатгалын SCOR корпорацтай гэрээ байгуулан ажиллаж эхлэв.

Бид 2018 оны 9-р сард хувьцаагаа олон нийтэд

Компани	P/E	P/B
Мандал Даатгал ХК	5.4	1.5
АПУ ХК	8.9	1.4
Ард Даатгал ХК	11.6	1.7
Лэндмн ХК	7.0	2.0

гаргаж, Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд, нээлттэй арилжаалснаас хойш нэг жил гаруйн хугацаа өнгөрчээ. Энэ хугацаанд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл хуваарийн дагуу тогтмол хуралдаж компанийн стратеги, төсөв, төлөвлөгөө, зохион байгуулалттай холбоотой чухал шийдвэрүүдийг гаргаж ажиллалаа.

Одоогийн байдлаар Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудаас зөвхөн Мандал даатгалын нийт хувьцааны 51-ээс дээш хувийг ямарваа нэг нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшихгүй байгаа билээ. Миний бодлоор энэ нь корпорацын зөв засаглал бүрэлдэн хөгжих хамгийн зөв хөрс юм.

2019 оны хувьд Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын олонхынх нь хувьцааны үнэ уналаа. Энэ нь зах зээлд урт хугацаат хөрөнгө оруулагч байхгүй байгаатай холбоотой гэж үзэж байна. Мандал

даатгалын хувьцааны ханш тогтвортой хэлбэлзэж байгаа боловч компанийн санхүүгийн үзүүлэлт, хөрөнгө, цэвэр ашиг, мөнгөн хөрөнгөтэй харьцуулахад хэтэрхий багаар үнэлэгдсэн байгаа нь доорх хүснэгтээс харагдаж байна.

Эцэст нь хэлэхэд 2020 онд дэлхийг нөмөрч буй COVID-19 вирусийн халдвар нь олон улсын эдийн засагт ноцтой аюул заналхийлэл бий болгож байгааг та бид мэднэ. Энэ эрсдэл Монгол Улсын эдийн засгийг ч мөн дайрна гэж бид таамаглаж байгаа. Өмнөх 2009 онд тохиосон Дэлхийн эдийн засгийн хямрал нь санхүүгийн хямрал байсан бол энэ удаагийн хямрал нь газар сайгүй хүний хөдөлгөөн зогсож, нийгэм царцанги байдалд орсонтой холбогдон үүсч байгаа учраас урд хожид тохиолдож байгаагүй аюултай зүйл болж хувираад байна.

Мандал даатгалын хувьд банк, санхүүгийн байгууллагаас авсан ямарваа нэг өр, зээлгүй учраас бусад төрлийн бизнестэй харьцуулахад ирж буй эдийн засгийн хямралыг харьцангуй хөнгөхөн давна гэж бид итгэж байна. Цаашид компанийн удирдлага маань эдийн засгийн нөхцөл байдлыг анхааралтай ажиглан, зохих арга хэмжээг цаг тухай бүрд нь авч ажиллах болно. ■





# Батсайханы ЖАВХЛАН

Гүйцэтгэх захирал

Б. Жавхлан

## Мандал даатгалын хувьд 2019 он хэр амжилттай жил болж өнгөрсөн бэ?

Аливаа байгууллагын амжилтыг тоон болон чанарын гэсэн хоёр төрлийн үзүүлэлтээр хэмждэг. Тоон үзүүлэлтээрээ компанийн орлогоо 1 тэрбум төгрөгөөр өсч, ашиг 5,9 тэрбумд хүрч, хөрөнгө 21 хувийн өсөлттэй гарлаа. Нөгөөтгээгүүр, 2019 онд бид компанийн суурь чадамжуудыг дээшлүүлэх тал дээр төвлөрч ажилласны үр дүнд харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, зардал хэмнэх, бүтээмжийг сайжруулах чиглэлд томоохон ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Мэдээж зарим тоон үзүүлэлтүүдийн хувьд салбарын үзүүлэлтүүдээс харьцангуй бага байгаа нь үнэн. Гэхдээ чанартай, зөв бизнес эрхэлж байгаа нөхцөлд тэдгээрийг гүйцэх нь цаг хугацааны асуудал гэж бодож байна.

## 2019 онд хийсэн эдгээр ажлуудын цаад мотиваци нь юу байсан бэ?

Бизнесийн үйл ажиллагааны үр дүнг зөвхөн ашиг орлогоор бус, харилцагчид очиж байгаа сэтгэл ханамж, тухайн бүтээгдэхүүн үйлчилгээний нийгэмдээ үзүүлж буй үр нөлөөгөөр хэмждэг. Даатгалын компанийн хувьд хүмүүсийн эрсдэлийг өөр дээрээ шилжүүлж авч байгаа гэдэг утгаараа, үйлчилгээгээ амьдралд ойр, хэрэгцээтэй, харилцагчийг яг тэвдсэн үед нь тусалдаг болгохыг зорьж, илүү харилцагч суурьтайгаар үйл ажиллагааны процесс болон үйлдлүүдийг харсан. Ингэснээрээ үйлчилгээгээ илүү түргэн шуурхай, ил тод болгох бололцоотой болсон юм болов уу.

## Даатгалын компанийн талаар ярихдаа бид

## ихэвчлэн цэвэр санхүүгийн өнцгөөр хараад байдаг. Яг бизнесийнхээ хувьд Мандал нийгэмдээ ямар нөлөөллийг бий болгож байна вэ?

Бидний өнөөдрийг хүртэл бий болгосон баялаг бол нэг талаараа бидний амжилтын илэрхийлэл болж байдаг. Тиймээс, тэр зүйлсийг хайрлаж хамгаалж байж ирээдүйн сайн сайхан гэдэг зүйл рүү тэмүүлэх боломжтой болно. Даатгалын салбар хөгжиж, нийгмийн эрсдэлүүдийг өөртөө шилжүүлж авснаараа

## Даатгалын салбарын нэвчилт бага байгаа нь иргэдийн даатгалд хандах хандлагатай тодорхой хэмжээгээр холбоотой байх. Энэ талаар.

Анх Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалыг гарч ирж байхад хүн болгон л эсрэг байр суурьтай байсан. Гэтэл 2012 оноос хойш албан журмын даатгалаар нийт 200,000 хүнд 110-аад тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Гэтэл эдгээр хүмүүс даатгалгүй байсан бол хэчнээн хүн хохирлоо

Бид харилцагчийн үйлчилгээ, бүтээгдэхүүнээрээ тэргүүлээд зогсохгүй, хөрөнгө оруулагчийн үнэ цэнийг хамгийн өндөр байлгахыг зорьдог.

энэхүү бололцоог нь хангах суурь системийг бий болгож байгаа юм. Энэ нь даатгалын компанийн нийгэмдээ оруулж буй хамгийн том хувь нэмэр юм болов уу гэж боддог. Нөгөөтгээгүүр, иргэд даатгалыг баян, мөнгөтэй хүмүүс л авдаг зүйл гэж хардаг нь маш ерөөсгөл ойлголт. Нийгмийн дундаж болон дундаас доош давхаргыг болзошгүй эрсдэлээс хамгаалж, цуглуулж хуримтлуулсан бүхнээ эрсдэлээс болж үрэн таран хийхээс сэргийлэх, туслах механизмыг хүн төрөлхтөн бодож олсон нь даатгал. Тэгэхээр, аль болох олон хүнийг даатгалд хамруулах нь даатгалын салбарын нэгдсэн үүрэг хариуцлага байх ёстой. Ер нь эрсдэл учрахад баячууд нь бол яаж ийж байгаад даваад гарчихдаг, харин дундаж давхаргынхан хамгаалалтгүй үлддэг. Тиймээс улс орон үүнийг бодлогоор дэмжиж ажиллах хэрэгтэй.

барагдуулж чадахгүй байсан бол? Харилцагчид өгч байгаа даатгалын хураамжаа бодоод байгаа болохоос биш, өөрөө хохироод хохирлоо барагдуулж чадахгүй бол яах вэ гэдэг тэр өнцгийг харахгүй байгаад байна. Дээрээс нь даатгалын талаарх ойлголт, санхүүгийн боловсролын хувьд харилцан адилгүй байна. Наанадаж л даатгалынхаа гэрээтэй бүрэн уншиж танилцдаг болох хэрэгтэй.

## Зөвхөн харилцагч гэхгүй, Мандал даатгалын хөрөнгө оруулагч нартаа бий болгож буй үнэ цэнийн талаар ярилцъя.

Бид харилцагчийн үйлчилгээ, бүтээгдэхүүнээрээ тэргүүлээд зогсохгүй, хөрөнгө оруулагчийн үнэ цэнийг хамгийн өндөр байлгахыг зорьдог. Өнгөрсөн жил манай эздийн өмчийн өгөөж 32 хувьтай байсан бөгөөд компани сүүлийн 2 жил

дараалж 30-аас дээш хувийн өгөөжтэй байгаа. Өөрөөр хэлбэл, бид өөрсдийгөө зөвхөн даатгалын салбартаа гэлтгүй, Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй компаниуд дундаас хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн ашиглалтыг хамгийн амжилттай хэрэгжүүлж байгаа компанийн нэг гэж дүгнэдэг. Үүний суурь нь бид даатгалын бизнесийг яг сонгодог утгаар нь хөгжүүлж, хэрэгжүүлж байгаагийн үр дүн юм. Банкны хадгаламжийн хүү 14 хувьтай байгаа өнөөгийн

хөрөнгө оруулалт болон андеррайтинг гэсэн орлогын хоёр эх сурвалжтай байдаг. 2019 онд бид хөрөнгө оруулалтаасаа 3.7 тэрбум төгрөгийн орлого олсон бөгөөд энэ салбарын хэмжээнд тэргүүлэх үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл, ашгийн дийлэнх хэсгийг даатгалын үйл ажиллагаанаас илүүтэй хөрөнгө оруулалтын орлого эзэлж байгаа юм.

**2020 оны тэргүүлэх зорилтууд тань юу байх вэ?**  
Өнгөрсөн жил суурь

дуусах үед нь өндөр өсөлтийг бий болгох дотоод нөөцүүдээ сайжруулах, чанаржуулах ажлуудыг хийхээр төлөвлөөд байна. Нөхцөл байдал өдөр хоног тутам өөрчлөгдөж байгаа болохоор яг бүтэн зургаар нь харж төлөвлөхөд хүндрэлтэй байгаа хэдий ч, цаг үе болгон дээр тохирсон шийдлүүдийг авч хэрэгжүүлж байгаа.

**Цаг үетэй холбоотой бусад байгууллагад өгөх таны зөвлөмж**

Хямралыг дагаад олон компаниуд зардлаа танаж, бүсээ чангалах бодлого баримталж эхлээд байна. Гэхдээ энэ хямрал хэзээ нэгэн цагт дуусах нь тодорхой. Тэр үед өнөөдрийг хүртэл бий болгосон чадамжаа алдчихсан байхгүйн тулд голлох хүн хүч, тоног төхөөрөмжүүдээ хайрлаж, хамгаалж байх хэрэгтэй. Эрсдэл гэдэг зүйл цаг хугацаанаас үл хамааран байнга оршин байдаг учраас эрсдэлийн шийдлүүдийг авч хэрэгжүүлэх, гол ажилтнуудаа даатгуулах, гол хөрөнгүүдээ хамгаалах хэрэгтэй гэдгийг онцолъё. ■

Бид өөрсдийгөө зөвхөн салбартаа гэлтгүй, Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй компаниуд дундаас хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн ашиглалтыг хамгийн амжилттай хэрэгжүүлж байгаа компанийн нэг гэж дүгнэдэг.

нөхцөлд, түүнээс давсан хэмжээний өгөөж өгч чадахгүй бол хөрөнгө оруулагчдын мөнгийг үр ашиггүй зарцуулж байгаагийн хэлбэр гэж би хувьдаа хардаг.

**Өнгөрсөн онд 5.9 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан гэлээ. Даатгалын компани ингэж өндөр ашигтай ажиллаж болдог уу?**  
Даатгалын компани нь

чадамжуудаа нэмэгдүүлсэнтэй холбоотой 2020 онд томоохон хэмжээний тэлэлт хийх зорилготой байсан. Хүн хүчээ ч тэр хэмжээгээр нэмэгдүүлсэн. Гэвч коронавирусын цар тахалтай холбоотойгоор нөхцөл байдал ихээхэн өөр болж байна. Үүнтэй холбоотойгоор үйл ажиллагааны үр ашгаа 2019 оны түвшинд барьж үлдэх тактик руу шилжиж, хямрал

# САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

*Компанийн хөрөнгө нэмэгдэхийн хэрээр хөрөнгө оруулалтын орлого нэмэгдэж, тогтвортой үйл ажиллагааны суурь бэхэжлээ.*

Санхүүгийн голлох үзүүлэлтүүд, сая төгрөгөөр	2017	2018	2019
Нийт актив	21,472	33,784	40,746
Нөөц сан	2,911	3,383	4,594
Нийт хураамжийн орлого	22,533	27,786	28,927
Цэвэр хураамжийн орлого	10,081	16,449	15,873
Орлогод тооцсон хураамж	7,043	11,932	16,422
Нийт нөхөн төлбөр	4,706	4,324	5,423
Цэвэр нөхөн төлбөр	2,074	3,286	4,364
Үйл ажиллагааны зардал	5,549	6,320	7,714
Хөрөнгө оруулалтын орлого	1,227	2,248	3,734
Цэвэр ашиг/алдагдал	1,103	3,868	5,871

## НИЙТ АКТИВ

2019 онд нийт актив өмнөх оноос 7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд салбартаа 2-р байранд, мөнгөн хөрөнгийн хэмжээгээр 1-р байранд бичигдэж байна.

## ХУРААМЖИЙН ОРЛОГО

Мандал даатгалын нийт хураамжийн орлогын хэмжээ 2019 онд 28.9 тэрбум төгрөгт хүрч зах зээлийн нийт хураамжийн орлогын 15 хувийг бүрдүүлснээр салбартаа 2-р байранд бичигдэж байна. Нийт хураамжийн орлогын бүтцийг авч үзвэл 28 хувийг Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал, 22 хувийг Барилга угсралтын даатгал, 21 хувийг Авто тээврийн хэрэгслийн даатгал тус тус эзэллээ.

Мөн нийт хураамжийн орлогоор Гэнэтийн осол, эмчилгээний зардлын болон Авто тээврийн хэрэгслийн даатгалын хэлбэрээр салбартаа тэргүүлж байна.



## НӨХӨН ТӨЛБӨР

2019 онд нийт 5.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг 10,564 даатгалын тохиолдолд олгож, эрсдэлийг нь хамтдаа даван тууллаа. Нийт олгосон нөхөн төлбөрийн 42 хувийг Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгалын нөхөн төлбөр, 41 хувийг Авто тээврийн хэрэгслийн болон Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, 10 хувийг Хариуцлагын даатгал эзэлж байна.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

2019 онд үйл ажиллагааны зардалд 7.7 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оноос 1.4 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм. Үйл ажиллагааны зардлын ихэнх хувийг борлуулалтын өсөлттэй холбоотой урамшуулалт цалингийн зардал, ажилтнуудыг мэргэшүүлэх, чадавхжуулахад чиглэсэн сургалтын зардал эзэлж байна.

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЛОГО

Хөрөнгө оруулалтын орлогын суурь нь мөнгөн хөрөнгө бөгөөд 2019 онд Мандал даатгалын мөнгөн хөрөнгө 5.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Хөрөнгө оруулалтын орлого өмнөх оноос 68 хувиар өсч 3.7 тэрбум төгрөгт хүрлээ.

## ЦЭВЭР АШИГ

2019 онд хөрөнгө оруулалтын ашиг нэмэгдсэн, мөн үндсэн бүтээгдэхүүний чанарт анхаарч ажилласны үр дүнд 5.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа. Цэвэр ашгийн бүрдлийг авч үзвэл 64 хувийг хөрөнгө оруулалтын орлого эзэлж байгаа бөгөөд үлдсэн 36 хувийг үйл ажиллагааны ашиг эзэлж байна.



## ХУВИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН №1 ДААТГАЛ



**1,000 дахин өндөр хамгаалалт**  
(Та сард 50,000 төгрөг төлөөд 50,000,000 төгрөг хүртэлх эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжтой.)



**Өндөр үнэтэй эмчилгээний зардлуудыг багтаасан**  
(Эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал зэрэг өндөр үнэтэй эмчилгээний зардлуудыг багтаасан.)



**Чанартай, хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээ**  
(Монгол улсын тэргүүлэх хувийн болон улсын эмнэлэгүүдээс эмчилгээ үйлчилгээ авах боломжтой.)



# 02

## МАНДАЛЫН БИЗНЕС

- ◆ Андеррайтингийн үйл ажиллагаа
- ◆ Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа

# АНДЕРРАЙТИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

*Мандал даатгал нь 2019 онд андеррайтингийн үйл ажиллагааны хүрээнд компанийн эрсдэлийн багцын хэмжээг томруулах буюу харилцагчийн тоог нэмэгдүүлэх зорилтыг тавьж амжилттай ажилласнаар харилцагчийн тоог 71 мянгаас 81 мянга болгож 14 хувиар өсгөж чадлаа.*

Компани нь андеррайтингийн үйл ажиллагааны хүрээнд харилцагчийн эрсдэлийн түвшинг өөрийн үнэлгээний аргачлалын дагуу үнэлж улмаар даатгах эсэх шийдвэрийг гаргадаг ба хэрэв даатгах шийдвэр гарсан бол уг харилцагчийн эрсдэлийн түвшинд тохирсон даатгалын хураамж болон хамгаалалтын хэмжээг санал болгодог. Өөрөөр хэлбэл, харилцагчийн эрсдэлийн түвшин өндөр бол өндөр хураамжийн хувь, эрсдэлийн түвшин бага бол бага хураамжийн хувь санал болгодог гэсэн үг юм.

Харилцагч нэг бүр дээр хийгдэх энэхүү үйл ажиллагааны эцсийн зорилго нь тооцоололд суурилсан эрүүл, зөв эрсдэлийн багцыг бүрдүүлэх бөгөөд энэ нь нэг харилцагчийн эрсдэлийг олон харилцагчийн багцад тархаах байдлаар эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлж, компанийг урт хугацаанд тогтвортой, өсөлттэй ажиллах нөхцөлөөр хангах юм.

Мандал даатгал 2019 онд андеррайтингийн үйл ажиллагааны хүрээнд компанийн эрсдэлийн багцын хэмжээг томруулах буюу харилцагчийн тоог нэмэгдүүлэх зорилтыг тавьж амжилттай ажилласнаар харилцагчдын тоог 71 мянгаас 81 мянга болгож 14 хувиар өсгөж чадлаа. Улмаар компани 2019 онд 115 мянган даатгалын гэрээ байгуулж, үйлчилгээ үзүүлсэн байна.

Компанийн багц томрох тусам даатгагч, харилцагч аль аль талд харилцан ашигтай дараах давуу талууд улам бүр баталгаажиж байна. Үүнд:

- Компанийн эрсдэл даах чадвар нэмэгдэж томоохон даатгалын тохиолдлын үед харилцагчийн хохирлыг нөхөн төлөх чадавх улам бүр сайжирч байна.
- Компани харилцагчид хамгийн сайн даатгалын хамгаалалтыг, актуар тооцоололд суурилсан хамгийн таатай үнээр санал болгох боломж улам бүр нэмэгдэж байна.
- Компанийн хөрөнгө оруулалтын ашиг өсч улмаар хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээ өсч байна.
- Компанийн даатгалын үйлчилгээний дэд бүтэц болон хүний нөөцөд зарцуулах хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж, улмаар харилцагчид үзүүлэх үйлчилгээний чанар стандарт сайжирч, даатгалын үйлчилгээ илүү хялбар, шуурхай болж байна.

Мандал даатгал даатгалын салбарт тэргүүлэгчийн хувьд даатгалын үйлчилгээний стандартыг шинэ түвшинд гаргаж хөгжүүлэх үүргийг хүлээн авч ажиллаж байгаа ба компанийн андеррайтингийн бодлогыг харилцагчид хамгийн хямд үнэтэй бүтээгдэхүүн үйлчилгээ санал болгох гэхээс

илүүтэйгээр, иж бүрэн эрсдэлийн хамгаалалт болон үнэ цэнэтэй нэмэлт эрсдэлийн удирдлагын үйлчилгээ бүхий цогц даатгалын үйлчилгээ рүү чиглүүлж ажиллаж байна.

## 2019 ОНД АНДЕРРАЙТИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАРСАН ОЛОЛТУУД

Мандал даатгал 2019 онд компанийн андеррайтингийн үйл ажиллагааг дараагийн шатанд гаргахад чиглэсэн олон ажлууд хэрэгжүүлснээс голлох ололтуудыг дурдвал:

- Мандал даатгал нь Монголын даатгалын салбарт анх удаа эрсдэлээр мэргэшсэн инженерүүдийн багийг бий болгож улмаар харилцагч нарынхаа эрсдэлийн түвшинг мэргэжлийн түвшинд үнэлж, зөвлөгөө өгөх цаашлаад өөрийн багцын эрсдэлийн удирдлагыг сайжруулахад чиглэсэн ажлыг 2019 онд амжилттай эхлүүлээ.
- Мандал даатгал нь 2019 оны 10 дугаар сард А.М Best-ийн А+ үнэлгээтэй Францын давхар даатгагч SCOR болон Германы давхар даатгагч Hannover Re зэрэг дэлхийн тэргүүлэгч компаниудтай багцын давхар даатгалын гэрээ байгуулсан ба улмаар Мандал даатгалын нийт харилцагчид эдгээр нэр хүндтэй даатгагчдаар давхар даатгагдаж байгаа юм.
- Компани харилцагчтай байгуулж буй даатгалын гэрээ нэг бүрийг олон улсын стандартад нийцүүлж стандартчилах ажлыг амжилттай хийж дуусгалаа. Ингэснээр, даатгалын гэрээний заалтууд илүү тодорхой, ойлгомжтой болж байна.
- Харилцагчид мэргэжлийн түвшинд даатгалын үйлчилгээ үзүүлэхийн тулд борлуулалт, нөхөн төлбөрийн ажилтнуудад зориулсан олон улсын хэмжээнд дагаж мөрддөг андеррайтингийн болон даатгалын зарчмуудын тухай сургалт, аттестатчиллын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлж эхэллээ.

## БАГЦЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Мандал даатгал нь багцын эрсдэлийн удирдлагын чиглэлээр 2019 онд тодорхой алхмуудыг амжилттай хийсний үр дүнд андеррайтингийн үзүүлэлтүүд эрс сайжирлаа.

Компанийн 2019 оны андеррайтингийн гол үзүүлэлтүүдийг багцын бүтэц, орлогын төвлөрөл, давхар даатгал, хохирлын харьцаа болон нөхөн төлбөр гэсэн хэсгээр нэгтгэн, дараах байдлаар дүгнэв.

### Багцын бүтэц ба орлогын төвлөрөл

Мандал даатгал 2019 оны 28.9 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлогыг бүтээгдэхүүний төрлөөр ангилж харвал дараах бүтэцтэй байна.

Хураамжийн орлого, даатгалын хэлбэрээр	2018		2019	
	Сая төгрөгөөр	Хувь	Сая төгрөгөөр	Хувь
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	8,594	31%	<b>8,165</b>	<b>28%</b>
Барилга угсралтын даатгал	5,842	21%	<b>6,377</b>	<b>22%</b>
Авто тээврийн хэрэгслийн даатгал	4,670	17%	<b>6,095</b>	<b>21%</b>
Хөрөнгийн даатгал	4,125	15%	<b>3,711</b>	<b>13%</b>
Хариуцлагын даатгал	2,231	8%	<b>1,234</b>	<b>4%</b>
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	545	2%	<b>491</b>	<b>2%</b>
Бусад	1,779	6%	<b>2,854</b>	<b>10%</b>
Нийт	27,786	100%	<b>28,927</b>	<b>100%</b>

Хүснэгтээс харахад, компанийн орлогын бүтэц төвлөрөл багатай буюу багцын хувьд эрүүл харагдаж байна. Мөн 2019 оныг өмнөх онтой харьцуулахад багцын бүтцийн хувьд томоохон өөрчлөлт гараагүй нь зах зээл дэх байр суурь тогтвортой байгааг илтгэнэ. Харин бүтээгдэхүүн нэг бүрийн хувьд харвал Барилга угсралт, Авто тээврийн хэрэгслийн даатгалын багцад эзлэх хувь бага зэрэг нэмэгдсэн бол Гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгал, Хөрөнгийн даатгал, Хариуцлагын даатгалын багцад эзлэх хувь бага зэрэг буурсан байна.

### Багцын давхар даатгалын хамгаалалт

Мандал даатгал нь өөрийн эрсдэлийн багцыг Трийти давхар даатгалын гэрээ буюу компанийн үндсэн эрсдэлийн багцуудыг бүгдийг нь хамгаалах нөхцөлтэй гэрээгээр давхар даатгагч нарт даатгуулсан байдаг. Өөрөөр хэлбэл, Мандал даатгал харилцагч нараас гэрээгээр шилжүүлж авсан эрсдэлээ олон улсын тэргүүлэх давхар даатгагчдаар даатгуулдаг гэсэн үг. Давхар даатгалын уг хэлбэрт “Хөрөнгийн даатгал”, “Хариуцлагын даатгал”, “Барилга угсралтын даатгал”, “Ачаа тээврийн даатгал” болон “Тусгай зориулалтын хүнд даацын тээврийн хэрэгслийн даатгал”-ын багцууд хамаарагддаг. Үүнээс гадна, шаардлагатай тохиолдлуудад мега төсөл болон томоохон групп компанийн эрсдэлүүдийг Мандал даатгал тухайлсан давхар даатгалын гэрээ буюу Факультатив, Фронтинг давхар даатгалын гэрээгээр давхар даатгагчид руу тухай бүр шилжүүлэх бодлого баримталдаг. Энэ нь Мандал даатгалын дааж чадах хэмжээнээс давсан томоохон хэмжээний хохирлын үед харилцагчдад нөхөн төлбөрийг найдвартай олгох, компани өөр дээрээ шилжүүлж авсан эрсдэлийн багцыг зөв удирдаж, тогтвортой үйл ажиллагаа явуулахад ашигладаг эрсдэлийн удирдлагын гол арга хэрэгсэл юм.

2019 онд хураамжийн орлогын 37 хувийг давхар даатгалд шилжүүлсэн нь 2018 оныхтой харьцуулахад 2 хувиар өссөн үзүүлэлт юм. Үүний шалтгаан нь Авто тээврийн хэрэгслийн даатгал дээр 2019 онд өндөр үнийн дүн бүхий уул уурхайн машин механизмууд даатгасантай холбоотой ба улмаар компани давхар даатгал руу Авто тээврийн хэрэгслийн даатгалын хураамжийн орлогын 20%-ийг шилжүүлж ажилласан байна.

Даатгалын хэлбэр бүрийн хувьд давхар даатгалд шилжүүлсэн хураамжийн хувийг 2018 оныхтой харьцуулж харвал дараах байдалтай байна. Үүнд:

Давхар даатгалд шилжүүлсэн хувь, даатгалын хэлбэрээр	2018	2019
Барилга угсралтын даатгал	100%	99%
Хөрөнгийн даатгал	47%	36%
Хариуцлагын даатгал	33%	14%
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	6%	1%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	1%	20%
Бусад	57%	53%
	35%	37%

### Багцын хохирлын харьцаа

Компанийн 2019 оны хохирлын харьцаа өмнөх оныхоос 1 хувиар буурч 27 хувь болсон үзүүлэлттэй байна. Энэхүү үр дүн нь компани андеррайтингийн үйл ажиллагаандаа онцгой анхаарч, өнгөрсөн хугацаанд үе шаттай арга хэмжээнүүдийг авч ажилласантай холбоотой. Хамгийн өндөр хураамжийн орлоготой даатгалын 6 хэлбэрийн хохирлын харьцааг өмнөх оныхтой харьцуулахад дараах байдалтай байна.

### Хохирлын харьцаа, даатгалын хэлбэрээр

	2018	2019
Барилга угсралтын даатгал	0%	3%
Хөрөнгийн даатгал	5%	7%
Хариуцлагын даатгал	3%	21%
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	11%	26%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	52%	38%
Бусад	54%	53%
	28%	27%

### Нөхөн төлбөр

Мандал даатгал нь 2019 онд 10,564 даатгалын тохиолдолд нийт 5.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон бөгөөд даатгалын тохиолдлын тоог даатгалын хэлбэрээр өмнөх оныхтой харьцуулан харвал дараах байдалтай байна.

Нөхөн төлбөрийн тоо, даатгалын хэлбэрээр	2018		2019	
	Тохиолдлын тоо	Хувь	Тохиолдлын тоо	Хувь
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	3,531	48%	7,770	74%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	2,609	36%	2,059	19%
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	931	13%	548	5%
Хөрөнгийн даатгал	195	3%	159	2%
Хариуцлагын даатгал	16	0%	26	0%
Бусад	12	0%	2	0%
Нийт	7,294	100%	10,564	100%

Олгосон нөхөн төлбөрийн дүнгийн хувьд, 2018 оныхтой харьцуулахад 25 хувиар өссөн бөгөөд энэ нь зарим даатгалын хэлбэр дэх нөхөн төлбөрийн хэмжээ өссөнтэй холбоотой байна. Тухайлбал, Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал болон Хариуцлагын даатгалд олгосон нөхөн төлбөрийн хэмжээ голлон нөлөөлсөн байна.

Харин олгосон нөхөн төлбөрийг өнгөрсөн оныхтой харьцуулан, бүтээгдэхүүний хэлбэрээр задлан харуулбал:

Нийт нөхөн төлбөр, даатгалын хэлбэрээр	2018		2019	
	Сая төгрөг	Хувь	Сая төгрөг	Хувь
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	1,388	32%	2,275	42%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	1,961	45%	1,930	36%
Хариуцлагын даатгал	161	4%	561	10%

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	505	12%	275	5%
Хөрөнгийн даатгал	175	4%	273	5%
Бусад	134	3%	109	2%
Нийт	4,324	100%	5,423	100%

Компани өнгөрсөн онд төлсөн 5.4 тэрбум нөхөн төлбөрийн 20 хувийг давхар даатгагчаар төлүүлсэн бол үлдсэн 4.4 тэрбум төгрөг буюу 80 хувийг өөрөө хариуцан төлсөн байна. Компанийн төлсөн цэвэр нөхөн төлбөрийг хүснэгтээр харуулбал:

Цэвэр нөхөн төлбөр, даатгалын хэлбэрээр	2018		2019	
	Сая төгрөгөөр	Хувь	Сая төгрөгөөр	Хувь
Авто тээврийн хэрэгслийн даатгал	1,815	51%	1,633	37%
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	1,058	30%	2,070	47%
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	420	12%	274	6%
Хөрөнгийн даатгал	112	3%	180	4%
Хариуцлагын даатгал	32	1%	195	4%
Бусад	98	3%	12	0%
Нийт	3,534	100%	4,364	100%

#### Нөөц сангийн тооцоолол

Мандал даатгал нь даатгалын тухай хуулийн дагуу гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор нөөц сан байгуулдаг бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны (СЗХ) 2019 оны 1-р сарын 9-ний өдрийн №2 тогтоолоор “Даатгалын багц дүрэм”-ийн Хавсралт №3, “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын дагуу нөөц сангийн тооцооллыг хийдэг.

2019 оны эцэст 4.6 тэрбум төгрөгийн нөөц байгуулснаас давхар даатгалд ногдох хэсэг нь 133 сая төгрөг байна.

# ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

*Даатгалын компанийн мөнгөн хөрөнгийн өсөлт нь эрсдэл даах чадварыг нэмэгдүүлдэг. Нөгөө талаас энэ нь даатгалын компанийг институционал хөрөнгө оруулагч болох боломжийг бүрдүүлдэг.*

Мандал даатгалын хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь актив-пассивын удирдлагад суурилан, СЗХ-оос тогтоосон даатгалын компанийн харьцаа үзүүлэлт болон даатгалын компанийн мөнгөн хөрөнгө байршуулах хязгаартай нийцүүлэн хөрөнгө оруулалтын багцыг эрсдэлийн зохих түвшинд компанийн хөрөнгө оруулалтын өгөөжийг хамгийн дээд хэмжээнд байлгах бодлого баримтлан ажилладаг.

Үзүүлэлт, тэрбум төгрөгөөр	2018	2019	Өсөлт
Мөнгөн хөрөнгө	22.9	28.5	23%
Хөрөнгө оруулалтын орлого	2.2	3.7	68%
Цэвэр ашиг	3.9	5.9	51%

Компани нь Удирдлагын хорооны дэргэдэх Хөрөнгө оруулалтын дэд хороотой. Тус дэд хороо нь хараат бусаар эрсдэл болон өгөөжийг харгалзан шийдвэр гаргадаг бөгөөд компанитай холбоо хамааралтай этгээдэд хөрөнгө оруулалт хийдэггүй.

Хөрөнгө оруулалтын багц бүрдүүлэлтийн төлөвлөгөөг макро эдийн засаг, санхүүгийн зах зээлийн төлөв байдал болон хөрөнгө оруулалтын боломжууд дээр үндэслэн хийдэг.

#### ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАГЦЫН ӨГӨӨЖИЙН ХАРЬЦУУЛАЛТ




Эх сурвалж: Монголын даатгагчдын холбоо

2019 оны жилийн эцсийн байдлаар Ердийн даатгалын компаниудын хөрөнгө оруулалтын орлогын дүнгээр ТОП-5 компанийг харвал:

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЛОГО**, тэрбум төгрөгөөр

**3.7** тэрбум



Эх сурвалж: Монголын даатгагчдын холбоо

Мандал даатгал нь 2019 оны жилийн гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын орлогын хэмжээгээр салбартаа тэргүүлж байна. Энэ нь удаах компаниас 55 хувиар илүү үзүүлэлт юм.

Компанийн мөнгөн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын үлдэгдлийг 2019 оны 12 сарын 31 өдрөөр харвал:

**Үзүүлэлт**, тэрбум төгрөгөөр

	2019	Хувь
Бэлэн мөнгө	0.9	3%
Банкан дах мөнгөн хөрөнгө	15.0	52%
Компанийн өрийн хэрэгсэл	8.2	29%
ББСБ-ын итгэлцэл	2.5	9%
Хувьцаа / Монголын хөрөнгийн бирж/	1.9	7%
Нийт	28.5	100%


Мөнгөн хөрөнгө, хөрөнгө оруулалт нь компанийн нийт хөрөнгийн дийлэнх хэсгийг буюу 70 хувийг бүрдүүлж байна. Нийт активын ихэнх хэсгийг бүрдүүлж буй мөнгөн хөрөнгийн оновчтой удирдлага, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь компанийн ашгийг бий болгогч томоохон хүчин зүйл болдог.

**ИНСТИТУЦИОНАЛ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ**

2019 оны жилийн эцсийн байдлаар Ердийн даатгалын компаниудын мөнгөн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын нийт дүнгээр ТОП-5 компани:

**МӨНГӨН ХӨРӨНГӨ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**, тэрбум төгрөгөөр

**28.5** тэрбум




Эх сурвалж: Монголын даатгагчдын холбоо

2019 онд Мандал даатгал нь мөнгөн хөрөнгө, хөрөнгө оруулалтын хэмжээгээр салбартаа тэргүүлж Монголын хөрөнгийн зах зээл дээр мэргэжлийн хөрөнгө оруулагчийн үүргээ амжилттайгаар гүйцэтгэж байна.



- ◆ Бизнес хөгжил, борлуулалт
- ◆ Үйлчилгээ, нөхөн төлбөр
- ◆ Мэдээллийн технологи
- ◆ Хүний нөөц
- ◆ Нийгмийн хариуцлага
- ◆ MNDL хувьцаа

# ОЗ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ФУНКЦИ



# БИЗНЕС ХӨГЖИЛ БОРЛУУЛАЛТ

*Харилцагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн, амьдралд ойрхон, шинэлэг даатгалын бүтээгдэхүүнийг хөгжүүлж, хамгийн үр ашигтай сувгаар хүргэх нь бизнес хөгжил болон борлуулалтын функцүүдийн гол үүрэг юм.*

## БОРЛУУЛАЛТ

Мандал даатгал нь 2019 онд хураамжийн орлогоо 1.2 тэрбум төгрөгөөр өсгөж нийт 28.9 тэрбум төгрөгийн хураамжийг татан төвлөрүүлээ. Өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 4 хувиар өссөн бөгөөд доорх хүснэгтэд бүтээгдэхүүний хэлбэрээр орлогын бүтцийг задалж харуулав.

Хураамжийн орлого, даатгалын хэлбэрээр, сая төгрөгөөр	2017	2018	2019	Өөрчлөлт
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	4,944	8,594	8,165	-5%
Барилга угсралтын даатгал	6,282	5,842	6,377	9%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	3,673	4,670	6,095	31%
Хөрөнгийн даатгал	3,533	4,124	3,711	-10%
Хариуцлагын даатгал	2,565	2,231	1,234	-45%
Бусад	1,537	2,325	3,344	44%
Нийт	22,533	27,786	28,927	4%

Монгол банкнаас арилжааны банкуудын “Хэрэглээний зээлийн журам”-д өөрчлөлт оруулж шинээр олгогдох хэрэглээний зээлийн хугацааг 30 сараар хязгаарлаж, зээлдэгчийн нийт өр орлогын харьцааг 70 хувиар тогтоох шийдвэр гаргасан билээ. 2018 оны 4-р улиралд банкуудын шинээр олгосон зээл 7 их наяд төгрөгт хүрсэн нь Монгол банкнаас хэрэгжүүлсэн зээлийн хязгаарлалтаас урьтах гэсэн иргэдийн хөдөлгөөн байсан бол 2019 оны эхний хагас гэхэд банкуудын нийт зээл 4 хувиар буурсан үзүүлэлттэй байв. Энэхүү журмын хэрэгжилтийн хүрээнд иргэдийн хэрэглээний зээлийн бүтээгдэхүүний эрэлт банкнаас Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) руу шилжсэн тул тус салбар хагас жилээр 42 хувийн өсөлт үзүүлсэн байна. Банкуудын хэрэглээний зээл олголт багассантай холбоотой зээлийн бүтээгдэхүүнийг дагасан даатгалын борлуулалтын орлого салбарын хэмжээнд буурсан байна.

Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгалын нийт хураамжийн орлого өмнөх оноос 5 хувиар буурсан. Уг даатгалын хэлбэрт гэнэтийн ослын даатгал болон эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнүүд хамаардаг бөгөөд багцын томоохон хэсгийг бүрдүүлдэг банкны зээл дагасан гэнэтийн ослын бүтээгдэхүүнүүдийн орлого буурч, төлөвлөгөө тасрах эрсдэл үүссэн хэдий ч сайн дурын эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүний орлого 22 хувиар өссөн амжилттай ажиллалаа.

Түүнчлэн, авто тээврийн хэрэгслийн даатгалын нийт хураамжийн орлого өмнөх оноос 31 хувиар өссөн бөгөөд сайн дурын даатгалын борлуулалтыг дэмжих ажлуудыг зохион байгуулж, хамтран ажилладаг борлуулалтын сувгуудыг өргөжүүлснээр энэхүү эерэг үр дүнд хүрч чадлаа.

### Борлуулалт ба чанар

Ажилтнуудын бүтээмжид онцгой анхаарч, байгууллагын харилцагч бүрд хүрч ажиллах боломж нөхцөл, ажилтны тоо, хүртээмжийг хоёр дахин нэмэгдүүлээ.

Борлуулалтын ажилтны өдөр тутамд хийгддэг даатгалын гэрээний бүртгэл, тооцооны ажлыг борлуулалтын нэгжийн чиг үүргээс тусад нь зохион байгуулж, ажлын чиг үүргийг шинэчлэн зохион байгууллаа.

Ингэснээр, борлуулалтын ажилтан нь оффист зарцуулах цагаа багасгаж, түүний оронд борлуулалтын уулзалт хийх, даатгуулагчид эрсдэлийн удирдлага болон даатгалын бүтээгдэхүүний талаарх мэдлэг, ойлголтыг түгээн дэлгэрүүлэх чиглэлд сургалт, зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд илүү цаг зарцуулах боломжтой боллоо.

## БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

Мандал даатгал нь бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, ялгаралд ихээхэн анхаарал хандуулан ажилладаг. Тиймээс ч стратегийн бүтээгдэхүүнүүд болох Авто тээврийн хэрэгслийн даатгал, Гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгалд тасралтгүй сайжруулалт хийж харилцагчдын хэрэгцээнд нийцсэн, амьдралд ойр бүтээгдэхүүн санал болгохоор зорин ажиллаж байна.

### Авто тээврийн хэрэгслийн даатгал

Мандал даатгал нь 2019 онд Авто тээврийн хэрэгслийн даатгалын нийт хураамжийн орлогоор 31 хувийн өсөлт үзүүлж, тээврийн хэрэгслийн даатгалын зах зээлд тэргүүлэгч байр сууриа хадгалж чадлаа.

2019 онд Сонголт, Классик сайн дурын тээврийн хэрэгслийн даатгалын андеррайтингийн нөхцлийг сайжруулж, нэмэлт өөрчлөлтүүдийг оруулснаар бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар, хэрэглээг нэмэгдүүлээ. Мөн тээврийн хэрэгслээ сайн дураар даатгуулж буй иргэдийг урамшуулах, борлуулалтыг дэмжих зорилгоор хоёр удаагийн “Даатгалын синдром” аяныг нийт 6 сарын хугацаанд амжилттай зохион байгуулав. Тус аяны онцлог нь даатгуулах болон даатгал зуучлах бүрд оноо тооцогдож олон төрлийн урамшууллаас сонгох боломжийг олгох юм. Үүнээс гадна 6 удаагийн сугалаа явуулж нийт 24 азтан тодруулж, эрсдэлээс сэргийлэх, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэхэд дэмжлэг болох гарын бэлгүүдийг гардууллаа.



Монгол улсад нийт 900,000 автомашин бүртгэлтэй байгаагаас 650,000 нь Улаанбаатар хотын хөдөлгөөнд тогтмол оролцдог гэсэн судалгаа бий. Өөрөөр хэлбэл, зах зээл хангалттай байгаа учраас өөрсдийн бүтээгдэхүүний брэндиг, үйлчилгээний чанараар ялгарахад анхаарч сайн дурын даатгалын нэвчлийг нэмэгдүүлэх, тэргүүлэгчийн байр сууриа баталгаажуулахыг зорин ажиллаж байна.

### Эрүүл мэндийн даатгал

Мандал даатгал нь сайн дурын эрүүл мэндийн даатгалын зах зээлд тэргүүлэгч гэдгээ дахин баталж 2019 оны гүйцэтгэлээр 22 хувийн өсөлт үзүүллээ.

2019 онд 7,000 гаруй иргэн, байгууллагын ажилтнуудыг сайн дурын эрүүл мэндийн даатгалд хамруулж эрүүл мэндийн хэрэгцээ шаардлага гарсан үед нь санхүүгийн асуудлыг нь шийдвэрлэж ажиллалаа.

Монгол Улс 2019 онд ДНБ-ийн 3 орчим хувийг эрүүл мэндийн салбарт зарцуулж байгаа нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хөгжиж буй орнуудад зөвлөдөг 5 хувьтай харьцуулахад бага үзүүлэлт юм. Энэхүү зардал нь эрүүл мэндийн үйлчилгээний нийт зардлын 40 орчим хувийг бүрдүүлдэг бөгөөд үлдсэн хэсгийг иргэд өөрийн халааснаас төлж байна. Энэ нь олон улсын дундажтай харьцуулахад харьцангуй өндөр дүн юм. Иймд, иргэдийн халааснаас гарах зардлыг бууруулахад сайн дурын эрүүл мэндийн даатгалын хэрэгцээ шаардлага, ач холбогдол өндөр байна.



Мандал даатгалаас гаргасан тооцооллоор сайн дурын эрүүл мэндийн даатгалын зах зээлийн нэвчил 2 хувьтай байгаа бөгөөд цааш өргөжин тэлэх орон зай хангалттай байгаа юм. Иймд, компанийн зүгээс бүтээгдэхүүнээ илүү амьдралд ойр болгон хөгжүүлж, үйлчилгээний чанарыг сайжруулж, зах зээлийг нэвчлийг нэмэгдүүлэхээр даатгалын салбарыг түүчээлэн ажиллаж байна.

### Шинэ бүтээгдэхүүн



Мандал даатгал нь байгуулагдсан цагаас хойш салбартаа инновацилаг бүтээгдэхүүн хөгжүүлж иргэдэд санал болгохыг эрмэлзэж ирсэн. Амжилттай шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх суурь нь чанартай судалгаа шинжилгээ бөгөөд бид зах зээлийн эрэлт, харилцагчдын хүсэл шаардлагыг нэн тэргүүнд тавьж салбартаа шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Үүний үр дүнд зах зээлд нэвтрүүлэх боломжтой 4 шинэ бүтээгдэхүүний судалгаа шинжилгээний ажил хийгдэж байгаа бөгөөд хөгжүүлж буй бүтээгдэхүүнүүдийн дээж эхнээсээ мэндэлж эхэллээ.

### Гар утасны дэлгэцийн даатгал

Монгол Улсын 15-60 насны хүн амын 99.6 хувь буюу 2.1 сая иргэн гар утас ашиглаж байгаа бөгөөд үүний 80 хувь нь ухаалаг утас ашигладаг. Тэдгээр ухаалаг гар утас хэрэглэгчдийн 74 хувь нь утсаа ямар нэгэн байдлаар унагааж дэлгэцийг нь гэмтээдэг байна. Ухаалаг гар утасны дэлгэцийг засуулах, солиулах зардал нь өндөр байдаг учраас санхүүгийн хүндрэлийг бий болгодог. Тиймээс 1.7 сая хэрэглэгчийн асуудлыг шийдэж өгөх зорилгоор Гар утасны дэлгэцийн даатгалын судалгаа хөгжүүлэлтийг эхлүүлж 2020 оны эхнээс зах зээлд нэвтрүүлээд байна.

### СУВАГ

#### Суурин борлуулалтын цэг

Борлуулалтыг дэмжих, харилцагчдад бүтээгдэхүүн үйлчилгээг ойртуулах зорилгоор Таван богд ХХК-ийн байранд өөрийн ажилтнуудаа байршуулж суурин борлуулалт хийж эхэллээ.

Таван богд ХХК нь 2013 оноос эхлэн дэлхийд автомашин үйлдвэрлэлийн салбарт борлуулалтаараа тэргүүлэгч Японы "Toyota" брэндийн автомашиныг албан ёсны эрхтэйгээр борлуулж байгаа бөгөөд үйлчилгээний чанар, стандартаар салбартаа манлайлж жил бүр 1,000 автомашин борлуулдаг компани билээ. Иймд, Мандал даатгалын байгуулсан суурин борлуулалтын суваг нь шинэ тээврийн хэрэгслийг газар дээр нь түргэн шуурхай даатгуулах, даатгалын мэргэжлийн зөвлөгөө авах боломжийг харилцагчиддаа олгож буй ач холбогдолтой.

#### Цахим борлуулалт

Social pay аппликэйшнээр Гадаадад зорчигчийн даатгал, Замд гаръя дотоодын гэнэтийн ослын даатгал, Авто тээврийн хэрэгслийн даатгалыг борлуулж байна.

Технологийн хөгжлийг дагаад санхүүгийн салбар дижитал шилжилтэнд өртөж мобайл аппликэйшнээр бүхий л асуудлаа шийддэг цаг үе ирсэн. Иймээс, зах зээлийн чиг хандлагатай хөл нийлүүлэх зорилгоор гар утсаараа даатгуулах боломжийг харилцагч нарт олгож Social pay аппликэйшнд өөрийн бүтээгдэхүүнүүдээ байршууллаа.

Тус аппликэйшн нь "Bloomberg awards 2018"-ын "Шилдэг инноваци" шагналыг хүртсэн бөгөөд нийт 100,000 харилцагчийг өөртөө нэгтгэсэн кино үзэх, төлбөр төлөхөөс эхлээд бүхий л төрлийн үйлчилгээг гар утаснаасаа авах боломж олгодог технологийн шинэ шийдэл юм.

2020 онд дижитал шилжилтэнд бэлтгэн цахим борлуулалтын бусад шийдлийг нэвтрүүлэхээр ажиллаж байна.



# ҮЙЛЧИЛГЭЭ НӨХӨН ТӨЛБӨР

*Харилцагчийн мэдрэмжийн менежмент төслийг амжилттай хэрэгжүүлэн харилцагчийн үйлчилгээний стандартыг сайжрууллаа.*


Мандал даатгал нь 2019 онд харилцагчийн үйлчилгээ болон нөхөн төлбөрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад ихээхэн анхаарч томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллалаа. Төслийн үр дүнд салбартаа харилцагчийн үйлчилгээний стандартын жишгийг тогтоож, нөхөн төлбөр шийдвэрлэлтийн үйл ажиллагаанд мэдээлэл технологийн болоод дотоод процессийн шинэчлэл нэвтрүүлж, тогтмол хөгжүүлэлтийг хийлээ.

## ХАРИЛЦАГЧИЙН МЭДРЭМЖИЙН МЕНЕЖМЕНТ

Мандал даатгал нь харилцагчдад сэтгэл ханамжтай үйлчлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор шинэ үйлчилгээний байранд нүүж орсонтой зэрэгцэн 2019 онд харилцагчид үйлчлэх үйлчилгээний стандартыг нэвтрүүлж мэргэжлийн байгууллагатай хамтран “Харилцагчийн мэдрэмжийн менежмент” төслийг амжилттай хэрэгжүүлж дуусгалаа. Энэхүү төслийн зорилго нь харилцагч бүрд хурдан шуурхай, мэргэжлийн, хүндэтгэлтэй үйлчилгээг үзүүлэхээс гадна Мандал даатгалын талаар эерэг сэтгэгдэлийг бий болгох, цаашлаад үнэнч хэрэглэгчийг бий болгох явдал юм.

Төсөлд харилцагчидтай нэн түрүүнд харилцдаг 30 гаруй ажилтан хамрагдаж хувь хүний хандлага, төлөвшил болоод ажлын ур чадвараа дээшлүүлэн ажиллаж байна. Мөн төслийн үр дүнд ажлын байр бүрд харилцагчийн үйлчилгээний стандартыг сайжруулан хөгжүүлэх зорилт тавин ажиллаж, зорилтоо 9,8 хувиар давуулан биелүүлж чадлаа.

ЯВЦЫН ҮНЭЛГЭЭНИЙ ӨСӨЛТ, Мэдрэмжийн менежментийн төсөл




## ХАРИЛЦАГЧИЙН ДУУ ХООЛОЙГ ХҮЛЭЭН АВЧ ШИЙДВЭРЛЭХ

Үйлчилгээний хэлтэс нь харилцагчийн дуу хоолойг бүх сувгаар цаг алдалгүй хүлээн авч баримтжуулан, түргэн шуурхай шийдвэрлэх зорилгоор “Харилцагчийн дуу хоолойг хүлээн авч шийдвэрлэх журам”-ыг батлуулан хэрэгжүүлж эхэлсэн. Ингэснээр, бид харилцагчаас ирэх аливаа гомдол санал болон талархлыг боломжит бүх сувгаар хүлээн авч шалгах, шалтгааныг судлах, шийдвэрлэх, хариу өгөх, урьдчилан сэргийлэх ажлуудыг хэрэгжүүлж байна.

2019 онд нийт 162 гомдлыг хүлээн авч 100 хувь шийдвэрлэсэн. Мөн хүлээн авсан гомдлын шалтгаанаас хамаарч дотоод процессын алдаа, ажилтны алдаа зэргийг бүртгэлжүүлж, процессын сайжруулалт, өөрчлөлтийг цаг тухай бүрд нь хийн ажиллаж байна.

ЛАВЛАХ ТӨВИЙН ДУУДЛАГА



ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ХАРИЛЦАГЧ



Лавлах төвийн хувьд 2019 оны харилцагчийн хандалт өмнөх оноос 16 хувиар өсөж, үйлчилгээ авсан харилцагчийн тоо 30 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь харилцагч Үйлчилгээний төвд ирэхгүйгээр даатгалын бүхий л үйлчилгээг авах боломжтой болсонтой холбоотой.

## ДУУДЛАГЫН ТӨВ

Харилцагчийн дуу хоолойг хүлээн авах сувгийн нэг болох Лавлах төвийн ажилтнуудын хувьд харилцагчаас ирж байгаа дуудлагыг ямар нэгэн хүлээлэггүй хүлээн авч, бүртгэхийг зорин ажиллаж байна.

Лавлах төв болон шуурхай дуудлага, эрүүл мэндийн лавлагаа гэсэн 3 шугамаар лавлагаа хүлээн авч заавар зөвлөгөө өгдөг ба 1-р шугамаар ослын дуудлага хүлээн авч, 2-р шугамаар эрүүл мэндийн нөхөн төлбөрийн мэргэжилтнүүд лавлагаа мэдээлэлд хариулж байна.

Лавлах төвийн голлох үзүүлэлтүүдийн нэг болох дуудлага авах нэгж дуудлагын дундаж хүлээлгийн хугацаа 4 секунд, байдаг ба нийт дуудлагын 97 хувийг анхны хандалтаар амжилттай авч хаасан нь салбартаа төдийгүй Монгол улсын үйлчилгээний салбарт үлгэр жишээ болохуйц үзүүлэлт юм.

Салбартаа төдийгүй үйлчилгээний салбарт үлгэр жишээ чанарын стандарт бүхий дуудлагын төв болон ажиллаж байна.

## НӨХӨН ТӨЛБӨРИЙН ХУРДЫГ НЭМЭХ ЗОРИЛГОТОЙ ТОМООХОН ТӨСЛҮҮД

Сэтгэгдэл


Мандал даатгал нь 2019 онд байгууллагын хэмжээнд хэд хэдэн зорилт тавьж ажилласны нэг нь нөхөн төлбөр шийдвэрлэх хурдыг хоёр дахин нэмэгдүүлэхийг зорин дараах ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэлээ.

### Мобайл аппликейшн

Мобайл аппликейшн төслийг 2019 онд нэвтрүүлснээр харилцагч үйлчилгээний төвд ирэхгүйгээр даатгалын бүхий л үйлчилгээг авч, цаг заваа хэмнэдэг боллоо.


Аппликейшнээр дамжуулан харилцагч тохиолдлын газарт ослын дуудлага өгөх, даатгалын тохиолдлын баримтжуулалтыг өөрөө хийх, нөхөн төлбөрийн материал бүрдүүлэх, нөхөн төлбөрийн шийдвэрлэлтийн явцыг харах, лавлагаа мэдээлэл авах зэрэг үйлчилгээг авах боломжтой.

Энэхүү төслийн хөгжүүлэлт нь тодорхой үе шаттай хийгдэх бөгөөд цаашид даатгалын нөхөн төлбөрийн бүртгэл мэдээлэл, тооцоолол, санхүүгийн гүйлгээний цогц системийг бий болгохоор зорин ажиллаж байна.



### Shared back office

2019 онд нөхөн төлбөр шийдвэрлэх дотоод процессод өөрчлөлт оруулан Shared back office буюу Бизнес процессын хэлтсийг шинээр байгуулан ажиллуулж эхэллээ. Энэ хэлтэс байгуулагдсанаар ажилтны ачаалал тэнцвэржиж, бүтээмж нэмэгдсэн төдийгүй байгууллагын хэмжээнд дата мэдээллийн бүртгэл нэг урсгалд орж бүртгэлийн алдаагүй байдал, түүнд тавих хяналт сайжирч, цахим мэдээллийн сан бүрдүүлсэн. Мөн нөхөн төлбөрийн материал хүлээн авах сувгийн тоог нэмэгдүүлж нөхөн төлбөрийн материал бүрдүүлэх, шийдвэр гаргах хугацааг амжилттай буурууллаа.



### Эрүүл мэндийн нөхөн төлбөр

Үйлчилгээний төв салбар болон эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ авдаг сүлжээ 13 эмнэлэгт тусгай нөхөн төлбөрийн материал хүлээн авах хайрцаг байршуулан, эрүүл мэндийн даатгалын нөхөн төлбөрийн материалыг 7 хоногийн 24 цагаар хүлээн авч байна.

Сүлжээ эмнэлгүүдээс Интермэд эмнэлгийг сонгож үйлчилгээний мэргэжилтэн ажиллуулан харилцагчдад эрүүл мэндийн даатгалын үйлчилгээтэй холбоотой заавар, зөвлөмж, чиглүүлэг хүргэж байгаа нь харилцагчдын талархлыг хүлээж байна.

2018 оны 4 дүгээр улиралд нөхөн төлбөр шийдвэрлэх хурд дунджаар 10 хоног байсан бол, дээрх ажлын үр дүнд 2019 оны 4 дүгээр улирлын байдлаар 5,2 хоногт хүрч 47 хувиар буурсан амжилттай байна.

Сэтгэгдэл



Монгол Улсын даатгалын салбарын хөгжил хөгжингүй орнуудын жишигт ойртож байгааг харахад таатай байна.

Миний бие АНУ-д гэр бүлийн хамтаар 3 жил томилолтоор ажиллаж, амьдарч байгаад ирсэн. Энэ хугацаандаа эрүүл мэндийн болон авто тээврийн хэрэгслийн даатгалаар олон удаа үйлчлүүлж, үр шимийг нь хүртэж байлаа. Тиймээс Монголд очмогцоо заавал даатгуулна гэсэн бодолтой байсан. Эх орондоо ирээд Оюу толгой ХХК-д эргээд ажилд орсон юм. Манай компани бүх ажилчдаа Эрүүл мэндийн даатгалд хамруулсан байсан. Нэгэнт даатгалын үр ашгийг мэдэх болохоор гэр бүлийн гишүүдээ сайн дураар нэмж даатгуулсан юм.

Манай гэр бүлийн хувьд Монголд авсан эрүүл мэндийн даатгалын үйлчилгээндээ сэтгэл хангалуун байгаа. Даатгуулагч хэвтэн эмчлүүлэх тохиолдолд эмнэлэг рүү даатгалын компаниас шууд төлөлт хийх үйлчилгээ нь хөгжингүй орнуудын даатгалын үйлчилгээтэй ижил түвшинд очсон ойлгомжтой, чирэгдэлгүй, шинэлэг үйлчилгээ болохыг онцолмоор байна. Мөн нөхөн төлбөрийн шийдвэрийг гаргахдаа нэмэлт мэдээллийг лавлаж, даатгалын тохиолдлын талаар судалгааг сайтар хийж, даатгуулагчаа сэтгэл хангалуун байлгах талаас нь хамтран ажиллаж, богино хугацаанд нөхөн төлбөрийг олгож байсан.

Монгол улсын даатгалын салбарын хөгжил хөгжингүй орнуудын жишигт ойртож байгааг харахад таатай байна. Цаашид иргэдэд даатгалын боловсрол олгож, үр ашгийг сайтар таниулан, даатгалын бүтээгдэхүүний нэр төрөл олширч, салбарын доторх өрсөлдөөн нэмэгдэж, даатгалын зах зээл хөгжөөсэй гэж хүсч байна. Мандал Даатгал ХК-ийн хамт олонд амжилт хүсье

**Б.Баттулга**

Аюулгүй ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн, Оюу Толгой ХХК

Сэтгэгдэл



Эргэн тойрны хүмүүс миний асуудлыг сонсоод “Монголд даатгалын компаниуд нөхөн төлбөрийн тал дээр маш хэцүү” гэх мэтээр хэлж байсан. Тийм ч учраас миний хувьд даатгалын компаниас хүлээлт өндөр байгаагүй.

Би 2016 онд Голомт банкны зээлээр автомашин худалдан авч, Мандал даатгалд машинаа даатгуулж байсан юм. Тухайн үед санал болгосон даатгалын компаниуд дотроос Мандал даатгалын тээврийн хэрэгслийн даатгалын багц, хамгаалалтын төрлүүд нь илүү байсан болохоор сонгон үйлчлүүлсэн. 2019 он хүртэл огт нөхөн төлбөрийн тохиолдол үүсч байгаагүй хэдий ч даатгалын сунгалтаа жил бүр марталгүй хийлгэдэг байсныг хэлэх хэрэгтэй байх. Ер нь хүний амьдралд гэнэт учирч болох олон төрлийн эрсдэл гардгийн адилаар миний хувьд мөн тийм гэнэтийн зүйл учирсан. Тухайн осол болох үед гэр бүлээрээ машиндаа зорчин явсан бөгөөд азаар зөвхөн эд хөрөнгийн хохирол гарсан. Тэр даруй даатгалын ажилтанд дуудлага өгч, тухайн ажилтан маш түргэн шуурхай ослын газар ирж танилцан, холбогдох хүмүүсээс мэдээллээ бүрэн авч ажилласан юм.

Даатгалын компаниас надад нөхөн төлбөрийн гурван төрлийн хувилбар санал болгосон бөгөөд миний хувьд өөрт хамгийн тохиромжтой хувилбарыг сонгож, автомашинаа солиулсан байгаа. Хувилбаруудаас харахад мэргэжилтнүүд нь үнэ ханш, зах зээлийн үнэлгээ гэх мэт хүчин зүйлсүүдээ маш сайн судлан харьцуулалт хийсэн нь илт мэдрэгдэж байсан. Миний бодлоор Мандал даатгалын ажилтнууд зөвхөн нэг өнцгөөс асуудлыг харалгүй, хэрэглэгчийн байр сууринаас асуудлыг ойлгон, олон талын судалгаа шинжилгээ хийдэг нь Монголд үйл ажиллагаа явуулж байгаа даатгалын компаниуд дундаас хамаагүй илүү ахисан түвшинд юм байна гэж бодогдуулсан. Одоогийн унаж байгаа машинаа мөн л Мандалд даатгуулсан байгаа. Эндээ ч сэтгэл амар байна.

Ш.Батболд  
Даатгуулагч

## ХАРИЛЦАГЧИЙН ЗАМНАЛЫН СУДАЛГАА

Үйлчилгээний хэлтсээс харилцагчийн үйлчилгээний чанар ямар түвшинд байгааг салбарын хэмжээнд харьцуулан судалж, тодорхойлох, цаашид сайжруулах ажлын төлөвлөгөө, шийдлийг боловсруулах зорилготой “Харилцагчийн замналын судалгаа”-г амжилттай хийж гүйцэтгэлээ. Энэ судалгаагаар даатгалын байгууллагуудын бүтээгдэхүүн, нөхөн төлбөр болон онлайн даатгалын үйлчилгээ, үйлчилгээний орчин, ажилтны стандарт, харилцагчаас гаргаж буй хүчин чармайлт, хурд зэрэг олон үзүүлэлтийг судлан дүгнэлт гаргасан билээ. Судалгааны үр дүнгээс цаашид анхаарч сайжруулах ажлын төлөвлөгөө гарган, 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байна.

## БАЙГУУЛЛАГЫН ХАРИЛЦАГЧИЙН ХАЛАМЖ

Байгууллагын даатгалын зах зээл дэх нөвчлийг нэмэгдүүлэх, зах зээлийг тэлэх зорилгоор компаниудын эрсдэлийн удирдлага, даатгалын талаарх мэдлэг, боловсролыг нэмэгдүүлэх, түгээх чиглэлд олон улс болон дотооддоо авч хэрэгжүүлж буй шилдэг туршлагуудыг харилцагч

нартайгаа хуваалцсан лекц, форум, арга хэмжээ болон тухайлсан харилцагчид зориулсан сургалт, өдөрлөгүүдийг тогтмол зохион байгуулж, харилцагчиддаа даатгалын шийдлийг цогцоор нь санал болгон, олон хэлбэрийн даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээнээс сонголтоо хийж даатгуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллалаа.

Тухайлбал, Жи Си АР Монголиа, Оюу Толгой, Престиж Суплайз Инк байгууллагуудтай хамтран 620 ажилтан болон гэр бүлийнхэнд нь зориулан “Жаргалан” эрүүл мэндийн даатгалын хүрээнд нээлттэй өдөрлөг зохион байгуулж, энэхүү өдөрлөгөөр мэдрэл, зүрх судас, нүд, шүд, чих хамар хоолойн эмчийн үзлэг, хэвлийн эхо үзлэг, оношилгоо, сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл өгч, элэгний Б вирусийн шинжилгээ, вакцинд тус тус хамрагдууллаа.

Мөн Премиум Бюлдинг Материалс ХХК, Сэнтрэл Экспресс Си Ви Эс ХХК-ийн барилга байгууламж, үйлдвэрүүдэд эрсдэлийн үнэлгээ хийж, заавар зөвлөгөө өгч, эрсдэлийн удирдлагын чиглэлээр сургалт зохион байгуулан ажиллалаа.



# ГАНСҮХИЙН БАТ-ЭРДЭНЭ

## Премиум Групп ХХК, Санхүү хариуцсан дэд ерөнхийлөгч, ТУЗ-ийн гишүүн

*Премиум Группын үйл ажиллагааны талаарх танилцуулгаар ярилцлагаа эхэлье гэж бодлоо.*

Манай групп анх тавилгын үйлдвэрлэл болон импортын худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Ганброс компаниар бизнесээ эхлүүлж байсан бөгөөд 2011 онд өргөжин Премиум Групп болон Премиум Конкрит компаниуд байгуулагдсан байдаг. Тухайн үеийн үндсэн бизнес бол бетон зуурмагийн үйлдвэрлэл, худалдаа байсан бөгөөд салбартаа шинэлэг технологи, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэхийг зорьж ажилласан.

Үүнээс хойш UMS ХХК, Премиум Билдинг Материалс ХХК, Сентрал Экспресс Си Ви Эс ХХК (CU) зэрэг дараа дараагийн компаниуд байгуулагдсан. Одоогийн байдлаар манай групп үндсэн хоёр чиглэлээр бизнесийн үйл ажиллагаа явуулж байна. Эхнийх нь барилгын материалын үйлдвэрлэл, худалдаа, барилга угсралт, инженерингийн чиглэл ба хоёр дахь бизнесийн чиглэл нь жижиглэнгийн



Бизнесийн хамгийн чухал нөөц бол цаг хугацаа. Иймд, эрсдэл учрахад нөхөн төлбөр авч болох ч зах зээл дээрх нэр хүнд болон цаг хугацаа нөхөгдөхгүй төдийгүй дахин бий болгох гэж цаг хугацаа алдана. Тэр утгаараа даатгал хийлгэчихсэн юм чинь гээд хайхрамжгүй орхих бус, эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ гэдэг талаас нь харж ажиллах нь чухал.

худалдааны бизнес бөгөөд 2018 онд БНСУ-ын BGF Retail компанитай мастер франчайзингийн гэрээ байгуулан CU дэлгүүрийн сүлжээг Монголд нэвтрүүлсэн.

**Премиум Групп бизнесийн хэд хэдэн салбарт амжилттай үйл ажиллагаа явуулж байгаа. Эдгээр компаниуд дээрээ**

**бизнесийн эрсдэлийг хэрхэн удирддаг вэ?**

Бидний хувьд хамгийн үнэт нөөц бол манай хамт олон буюу ажилтан ажиллагсад байдаг ба тийм болохоор бид хөдөлмөрийн аюулгүй байдалд маш ач холбогдол өгч ажилладаг.

Барилгын материал үйлдвэрлэл, барилга угсралт

гэдэг бол өндөр эрсдэлтэй салбаруудын нэг юм. Бид байгуулагдсан цагаасаа хойш "Safety First" гэдэг зарчмыг алхам бүрдээ мөрдөж ажилласаар ирсэн. Тийм ч болохоор Монгол Улсад хэрэгжсэн томоохон олон улсын төслүүд буюу Салхитын салхин сэнсний төсөл, Цогтцэций салхин сэнсний төсөл, Сайншандын салхин сэнсний төсөл, Шангри-Ла цогцолбор, Шинэ нисэх буудал, Оюу Толгой төсөлд манай компани туслан гүйцэтгэгчээр шалгарч амжилттай хэрэгжүүлсэн гэж боддог.

Оюу Толгой төсөл дээр бид сүүлийн 3 жил ажиллаж байгаа ба 2019 онд хамгийн шилдэг аюулгүй ажиллагаатай компаниар шалгарсан. Олон улсын төслүүд дээр сурч мэдсэн туршлага бид бусад бизнесийн салбартаа хэрэгжүүлдэг. Тухайлбал CU дээр гэхэд Оюу Толгой төсөл дээр ажиллаж байсан аюулгүй ажиллагааны менежер маань ажиллаж байх жишээний. Нөгөө талаасаа бизнесийн хувьд хамгийн үнэт зүйл бол цаг хугацаа. Компаниуд ихэвчлэн даатгалтай юм чинь эрсдэл гарвал даатгуулсан хөрөнгөө нөхөөд авчихна гэж боддог. Бидний хувьд арай өөр. Нөхөн төлбөр авч болох



ч зах зээл дээрх нэр хүнд болон цаг хугацаа нөхөгдөхгүй төдийгүй дахин бий болгох гэж цаг хугацаа алдана. Тэр утгаараа даатгал хийлгэчихсэн гээд хайхрамжгүй орхих бус, эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ гэдэг талаас нь харж ажиллах нь чухал. Тийм учраас бид Мандал даатгалаар эрсдэлийн аудит хийлгэж, хаана ямар эрсдэл өндөр байна гэдгээ тодорхойлуулж, төлөвлөгөө гарган ажиллаж байна.

**Даатгалыг эрсдэлийн удирдлагадаа хэрхэн ашигладаг вэ?**

Эрсдэлийн удирдлагын дагуу мэдээж тодорхойлогдсон эрсдэлийг хянах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авдаг бөгөөд даатгуулах боломжит эрсдэлүүдийг

бүрэн даатгуулах бодлогыг баримталж ажилладаг.

**Монголд даатгалын салбар хөгжиж байгаа хэдий ч бизнесийн байгууллагуудын хувьд даатгалыг тансаг хэрэглээ байдлаар харж, санхүүгийн хямралтай үед хамгийн түрүүнд төсвөөсөө танадаг. Энэ тал дээр таны бодол.**

Эргээд энэ шийдвэр нь компаниудын эрсдэлийн удирдлагын бодлого, журамтай нь уялдана л даа. Мэдээж хямралтай үед компаниуд бүсээ чангалж, хасах боломжит зардлуудаа ач холбогдлоор нь жагсааж үздэг. Бидний хувьд даатгал бол хамгийн түрүүнд хасах зардлын тоонд ордоггүй. Бид юу хардаг вэ гэхээр, ямар ч үед байлгах ёстой даатгал,



сургалт хөгжил, аюулгүй байдлын гэх мэт зардлуудаа заавал байлгадаг. Энэ үед хөрөнгө оруулалт, бизнесийн тэлэлттэй холбоотой зардлуудаа байлгах эсэх дээр илүү анхаардаг байгаа.

Миний харж байгаагаар даатгалыг хэрэгтэй үедээ аваад, хэрэггүй үедээ болиод байдаг зүйл гэж үздэггүй. Компаниудын дунд тендерт орох гэж эсвэл ямар нэг шаардлага гарвал даатгуулдаг түгээмэл хандлага бий. Гэхдээ эрсдэл үргэлж оршин байдгийг санах хэрэгтэй.

#### Даатгалын компанийг сонгохдоо юуг анхаардаг вэ?

Бид даатгалын компанийг сонгохдоо тухайн компанийн эрсдэл даах чадвар, удирдлагын багийн туршлага, урт хугацаанд харилцан ашигтай хамтран

Миний харж байгаагаар даатгалыг хэрэгтэй үедээ аваад, хэрэггүй үедээ болиод байдаг зүйл гэж үздэггүй. Компаниудын дунд тендерт орох гэж эсвэл ямар нэг шаардлага гарвал даатгуулдаг түгээмэл хандлага бий. Гэхдээ эрсдэл үргэлж оршин байдгийг санах хэрэгтэй.

ажиллах талаас нь хардаг. Одоогоор бид зах зээл дээрх хамгийн шилдэг даатгалын компаниудтай хамтран ажиллаж байгаа гэж боддог.

Ер нь зардлаа бага байлгахын тулд даатгал хийлгэхгүй байх гэдэг бол илүү том эрсдэлийг авчирч байна гэж харах хэрэгтэй. ■



#### Ярилцлага

## БОЛОР-ЭРДЭНЭ БААСАНСҮРЭН

### Жи Си Ар Монголиа ХХК, Хүний Нөөцийн менежер

*Жи Си Ар Монголиа ХХК ажилтнуудаа хувийн эрүүл мэндийн даатгалд хамруулаад 2 жил хамтран ажиллаж байна. Анх ажилтнуудаа эрүүл мэндийн даатгалд хамруулъя гэсэн шийдвэрээ хэрхэн гаргаж байсан бэ?*

Ерөнхийдөө компани маань joint venture, гаднын хөрөнгө оруулалттай гэдэг утгаараа ажилтнуудынхаа хөнгөлөлт хангамжийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх, ажилтандаа үр өгөөжтэй байхаар шийдвэрлэх зорилготой. Том дүр зургаараа ажилтанд юу хэрэгтэй, гэр бүлд нь юу хэрэгтэй гэдгийг судалж үзээд эрүүл мэндийн даатгалыг сонгосон. Монголчууд эрүүл мэндийн даатгал гэлтгүй ер нь даатгалын талаар ойлголт багатай. Энэ ч утгаараа “Жаргалан” эрүүл мэндийн даатгал нь манай ажилтнуудад шинэлэг зүйл байсан гэхэд болно.

Манай ажилтнууд 28 хоног гэрээсээ хол байрлаж, ажлын өдрүүдэд өдөрт 12 цаг ажилладаг ба бие мах бодийн ачаалал их авч ажилладаг тул тэр бүр гэр бүлдээ цаг гаргаад байж чаддаггүй. Ажилтны хувьд гэр бүл нь эрүүл мэндийн хамгаалалттай байгаа

нөхцөлд гэрээсээ хол байсан ч эхнэр, хүүхдүүдийнхээ эрүүл мэндэд санаа зовних нь илүү бага байдаг.

2019 оны 12 сард бүх ажилтны хурлаар Мандал даатгалын ЭМД-г сунгасан тухай мэдээллийг хүргэхэд ажилтнууд маань маш баяртай хүлээж авсан. Энэ нь ажилтнууд болон тэдний гэр бүлийнхэн даатгалын ач холбогдлыг таньж мэдсэнтэй холбоотой гэж харж байна.

#### Ажилтнууд болон тэдний гэр бүлийн хувьд уг даатгалын үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай байгаа вэ?

Манай ажилтнуудын сэтгэл ханамж өндөр байдаг.

Эрүүл мэндийн даатгал нь манай ажилтнуудад эерэг, зөв соёлыг бий болгоход хамгийн чухал нөлөөл үзүүлсэн гэж харж байгаа.

Жишээ нь уурхайн сайт дээр ажиллаж, байнга нийтийн хоол идээд байхаар ходоод дотор эрхтэндээ хүртэл анхаарах хандуулах шаардлагатай болж байгаа юм. 28 хоног ажиллаж 14 хоног амардаг учраас амралтынхаа хугацаанд Монголын шилдэг эмнэлгүүдээр үйлчлүүлж, эмчилгээ үйлчилгээ авах нь ажилтны эрүүл мэндийн талаарх зовнилыг бууруулж байгаа учраас үүнд их сэтгэл хангалуун байдаг. Эрүүл мэнддээ илүү анхаарах боломж нэмэгдсэн гэсэн үг.

Нөгөө талаас даатгуулсан компанийн хувьд ямар үр өгөөжтэй байгаа вэ? Компанийн хэмжээнд



байгууллагын соёл гэдэг маш чухал. Ялангуяа богино хугацаанд мянгаас дээш хүний нөөцийг бүрдүүлсэн манайх шиг байгууллагын хувьд нийт ажилтнуудаа нэгтгэх, ажил болон компанидаа өөриймсөг хандах сэтгэлгээг бий болгохын тулд ажилтнаа халамжилж, ажилтанд чиглэсэн үйл ажиллагаа явуулахад буцаагаад бүтээмжээ ахиулж, байгууллагын зөв соёлыг бий болгож байна. Тэр ч утгаараа ЭМД нь манай ажилтнуудад эерэг, зөв соёлыг бий болгоход хамгийн чухал нөлөөл үзүүлсэн гэж харж байгаа.

илүү хямд хураамжтай, илүү сайн хамгаалалтыг санал болгодог ч даатгал гэдэг нь эцсийн дүндээ хэлсэн амлалтдаа хүрэх л юм билээ. Мандал даатгал бол эрсдэл даах чадвар, эрүүл мэндийн даатгалын зах зээл дэх байр суурь, туршлага, дэд бүтэц зэргээрээ хамгийн найдвартай нь учраас бид итгэж сонгосон.

**Танай байгууллагын хувьд даатгуулсан туршлагаа дээрээ үндэслээд бусад байгууллагуудад хандаж ямар зөвлөмж өгөх вэ?**  
Манай компани нь нийгмийн хариуцлагаа ухамсарлан аж

Компанийн бодлогын хүрээнд хүмүүсээ жижиг хангамжид хамруулах бус, эрүүл мэндэд хөрөнгө оруулах нь хамгийн том хөрөнгө оруулалт, хангамж болж чадна.

**Даатгагч байгууллагадаа ямар шаардлага тавьдаг вэ?**  
Бид даатгуулахдаа олон компаниас санал авч багагүй. Судалгаа хийсний эцэст Мандал даатгалыг сонгосон. Үүний голлох шалтгаан бол ерөөсөө л үйлчилгээ. Мэдээж зарим компаниуд

ахуйн нэгж байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах журмынхаа дагуу хөгжлийн бэрхшээлтэй 42 иргэнийг ажилд авсан. Бид тэдгээр иргэдийг үндсэн ажилтнуудтай адилхан ЭМД-д хамруулдаг. Энэ хүсэл саналыг ч



Ярилцлага

даатгалын компани маань хүлээж авч хамтарч ажиллаж байгаад талархдаг. Цаашлаад, Оюу толгой дээр ажиллаж байгаа бусад туслан гүйцэтгэгч нараас туршлага хуваалцах хүсэлт их ирсэн.

Компанийн бодлогын хүрээнд хүмүүсээ жижиг хангамжид хамруулах бус, эрүүл мэндэд хөрөнгө оруулах нь хамгийн том хөрөнгө оруулалт, хангамж болж чадна. Зөвхөн нэг ажилтанд биш, түүний ард талд буй гэр бүлийн гишүүдэд урт хугацааны томоохон хөрөнгө оруулалт хийж байна гэсэн үг юм. Утсанд нь нэгж хийх, машинд нь шатахуун хийх, мөнгө өгөх зэрэг нь үрэгдээд дуусах богино хугацааны хөрөнгө оруулалт юм. ЭМД гэдэг том зургаараа гэр бүл, хувь хүн, цаашлаад улс, эх оронд маш том хөрөнгө оруулалт. ■



## МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

**Д.Бавуугарьд**  
Мэдээллийн технологийн хариуцсан менежер

Мандал даатгалын Мэдээллийн технологийн функцын үйл ажиллагааны талаар Мэдээлэл технологийн хариуцсан менежер Д.Бавуугарьдтай ярилцлаа.

**Танд энэ өдрийн мэндийг хүргэе. Та мэдээлэл технологийн салбарт хэр удаан ажиллаж байгаа?**  
Намайг Бавуугарьд гэдэг. Мандал даатгалд Мэдээллийн технологи хариуцсан менежерээр ажилладаг. Мэдээллийн технологийн салбарт нийт 20 орчим жил ажиллаж байна. Үүнээс арав гаруй жилд нь банк, санхүүгийн салбарт ажилласан. Харин одоо ажиллаж буй даатгалын салбартаа 7 жил ажилласан байна.

**Мэдээллийн технологи хариуцсан менежерийн хувьд салбарынхаа техник технологийн хөгжлийг хэрхэн харж байгаа вэ?**

Бид технологийн хөгжил дэвшилтэй хөл нийлүүлэн алхаж, орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан дата төв, программ хангамж дэд бүтцийг стандартын дагуу байгуулан, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Техник, технологийн хөгжил өдөр тутмын амьдралтай шууд холбоотой болсон цаг үед бид амьдарч байна. Хүмүүст банкны салбарын жишээгээр тайлбарлавал илүү ойр байх болов уу. 10 гаруй жилийн өмнө банкны ПОС машин уншдаг худалдаа, үйлчилгээний байгууллага цөөхөн байсан санагдаж байна. Харин өнөөдөр гар утсаараа хорьм төдийд л банкны гүйлгээ хийдэг болсон байна.

Даатгалын салбарын хувьд Монгол Улсад саяхнаас л техник технологийн хөгжлийг

ашиглаж эхэлж байна гэж хэлж болох байх. Даатгалын компаниуд онлайнаар даатгал хийх шийдлүүдийг нэвтрүүлж эхэлж байна.

Олон улсад бол даатгалын салбарт техник технологийн ашиглалт, хэрэглээ маш өндөр түвшинд хүрсэн. Жишээ нь, АНУ, Европ, Хятадын томоохон даатгалын компаниуд хиймэл оюун ухаан дээр суурилсан дижитал андеррайтингийн системүүдийг бий болгосон байна. Үүнийг энгийнээр тайлбарлавал даатгалын компани хүн бүрийн эрсдэлийн түвшин, зан төлөвийг GPS



байршлын схем гэх мэт технологийн тусламжтайгаар алсын зайнаас тодорхойлж, хүн бүрийн эрсдэлд тохирсон даатгалын хураамжийн санал болгоно гэсэн үг. Хүмүүс өөрт хэрэгтэй даатгалыг дэлхийн хаанаас ч гар утсаараа худалдан авах бололцоотой болж байна. Мөн даатгал дагасан үйлчилгээ ч бүрэн автоматжиж байна. Тухайлбал, машинтай мөргөлдөж өөрийн болон бусдын машинд гэмтэл учруулахад, даатгалын компанийн ажилтныг дуудаж үзлэг хийлгэх, хохирлоо үнэлүүлэхэд цаг зарцуулах шаардлагагүй болсон. Осолд орсон тохиолдолд гар утасны аппликейшнээр зургийг нь дараад явуулахад л хиймэл оюун ухааны тусламжтайгаар хохирлыг нь үнэлээд, тэр даруй дансанд нь нөхөн төлбөр орох шийдлийг дэлхийн тэргүүлэгч даатгалын компаниуд үйл ажиллагаандаа нэвтрүүлж байна. Тэгэхээр салбарын хөгжлийн чиг хандлага бол нэлээд тодорхой гэж харж байна. Харин бид олон улсын хөгжилтэй хөл нийлүүлэн байгууллагын үйлчилгээнд Digital transformation буюу цахим шилжилтийг хийж ажиллахаар зорьж байна.

**2019 онд цахим шилжилтийн хүрээнд танай байгууллага ямар ажлуудыг хийсэн бэ?** Бид 2019 онд харилцагч төвтэй мобайл аппликэйшг нэвтрүүлэн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээ авах, ослын үед харилцагчаас хамаарсан баримтжуулалтуудыг цахимжуулж чадсан төдийгүй сүүлийн үед Монголд хүчээ авч байгаа финтекийн технологиудыг ашиглан даатгалын бүтээгдэхүүнийг харилцагчийн өөрийн цахим түрүүвчээ ашиглан авах

бүрэн боломжуудыг бүрдүүлж чадлаа.

Энэ мэтээр компанийн өдөр тутмын үйл ажиллагаа технологи дээр суурилан явуулахын хэрээр маш их хэмжээний Big data бий болж байгаа. Үүний хүрээнд ажилтнуудынхаа хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн Data warehouse үүсгэн Business intelligence хэрэгслүүдийн тусламжтайгаар удирдлагын нэгдсэн системийг бий болгохын зэрэгцээ технологийн хөгжил ажилтны ур чадварыг хослуулсан шийдлүүдийг хийсээр байна.

**Цахим засаглал бүрдүүлж байгаа компаниуд тавигддаг томоохон асуудал аюулгүй байдал байдаг. Энэ тал дээр танай байгууллага юунд анхаарал хандуулан ажиллаж байна?**

Санхүүгийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын хувьд цахим халдлагад өртөж мөнгөн хохирол амсахаас гадна харилцагчийнхаа мэдээллийг алдах эрсдэл байдаг. Дэлхий дээр цахим

халдлагаас болж зөвхөн нэг жилд 600 орчим тэрбум долларын хохирол учирдаг гэсэн судалгаа байна. Монгол улсын хувьд 2017 оны байдлаар 7,5 тэрбум төгрөг хохирол учирч байсан.

Манай байгууллагын дата төв дээр цугларсан Big data-ны мэдээллийн аюулгүй байдлын асуудлыг хиймэл оюун ухаан дээр суурилсан Next generation firewall-ыг ашиглан, байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэхээс гадна ажилчдын мэдээллийн аюулгүй байдлын талаар ойлголтуудыг сургалтын хөтөлбөр болгон орох зэрэг ажлуудыг тогтмол хийж байна. Мөн дата төвийн нөөцийг Cloud data төвийн шийдлүүдтэй хослуулан ажиллуулж байна. Мэдээллийн технологийн аюулгүй байдлын тогтолцоогоо мэргэжлийн багаар шалгуулж баталгаажуулж чадсан. Cloud office шийдлийг бүрэн хэрэгжүүлэн дэлхийн аль ч өнгөц булан бүрээс ажилтнууд ажлаа хийх технологийн аюулгүй шийдлийг нэвтрүүлж чадлаа. ■

# ХҮНИЙ НӨӨЦ

*Эерэг хандлага, хичээл зүтгэл, хүсэл эрмэлзэл бүхий бүтээмжтэй ажилтан нь манай компанийн өрсөлдөх чадварын үнэ цэнэтэй хүчин зүйл юм.*

Мандал даатгал нь даатгалын салбарт мэргэшсэн туршлагатай 126 үндсэн ажилтантай бөгөөд эерэг хандлага, хичээл зүтгэл, хүсэл эрмэлзэл бүхий бүтээмжтэй ажилтан нь манай компанийн өрсөлдөх чадварын үнэ цэнэтэй хүчин зүйлийн нэг юм. Мөн 2019 онд мэдлэг, туршлагатай, чадварлаг удирдлагууд компанийн удирдлагын багт нэмэгдэж, компанийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлсийг хэрэгжүүлэн ажиллаж байна.


2019 онд ажилтнуудынхаа сэтгэл ханамжийг өндөр байлгах, тэднийг ая тухтай сурч хөгжих боломж бүхий ажлын байраар хангах, эрүүл мэндийг нь хамгаалах, ур чадварыг сайжруулж, мэргэшүүлэх, байнга шинийг эрэлхийлэн санаачлагч, ёс зүйтэй манлайлагч байх хүсэл зорилгыг нь дэмжсэн хүний нөөцийн оновчтой системийг бүрдүүлж ажиллахыг зорилоо.

Ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгаагаар Мандал даатгалын ажилтнууд нь компанийн Эрхэм зорилго, Алсын хараа, Үнэт зүйлсийг маш сайн мэддэг, ойлгодог, ажилдаа баримталж ажилладгаас гадна, компанийнхаа цаашдын тогтвортой үйл ажиллагаанд итгэж үнэмшилтэй, бахархдаг, удирдлагуудтайгаа нээлттэй харилцаатай, нэгжүүдийн хоорондын уялдаа холбоо, багийн ажиллагаа сайн гэсэн үр дүн гарсан.



## ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОО БАРИМТУУД

Ажилтны хүйсийн харьцаа



## АЖИЛТНУУДАД ХУВЬЦАА ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Мандал даатгал нь 2019 оноос компанийн хөгжилд хувь нэмрээ оруулсан, гүйцэтгэл өндөртэй, үнэ цэнэтэй ажилтнуудаа хадгалж үлдэх бодлогыг баримтлан Хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэн, олон жил үр бүтээлтэй ажилласан 8 ажилтанд тухайн үеийн ханшаар 125 сая төгрөгийн үнэ бүхий хувьцааг эзэмшүүллээ. Цаашид уг хөтөлбөр жил бүр үргэлжлэн явах бөгөөд 2020 онд Мандал даатгалын хувьд залуучуудын ажиллахыг хүсдэг шилдэг компани болох зорилтыг тавин ажиллаж байна.



## СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН БОДЛОГО

Мандал даатгалын хүний нөөцийн бодлого нь чадамжинд суурилсан уян хатан, нээлттэй системийг хөгжүүлж, мэргэжлийн чадварлаг, сэтгэл ханамжтай, тогтвортой багийг бүрдүүлэх юм. Энэхүү бодлогын хүрээнд зан төлөвт суурилсан сонгон шалгаруулалтын шинэлэг аргуудыг ашиглан, зөв хүнийг зөв ажлын байранд зарчмаар шударга, нээлттэй сонгон шалгаруулалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мандал даатгалыг сонирхон ажил горилж буй хүн бүхэнд сонгон шалгаруулалтад оролцох эрх нээлттэй ба төгссөн сургууль, ажилласан туршлагаас илүүтэй хандлага, хичээл зүтгэл, хүсэл эрмэлзэлд тулгуурлан, сонгон шалгаруулж, ажлын санал тавьдгаараа ялгаатай юм.

Хүмүүсийг эхэлж сонгон шалгаруулахаас илүүтэй, байгууллага танилцуулах, дадлагажуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэн, цаашид ажиллах эсэх сонголт хийх боломжийг ажил горилгогч нарт олгодог.



2019 оны 9 сард ажлын байрны “Нээлттэй сонгон шалгаруулалт”-ыг зохион байгуулж, нийт 601 ажил горилгогч бүртгүүлснээс 3 шатны сонгон шалгаруулалтаар 28 ажилтныг шалгаруулж ажилд авсан.

## КАРЬЕР, СУРГАЛТ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Мандал даатгал нь 2019 онд ажилтнуудаа ур чадваржуулах, сургаж хөгжүүлэх явцад түлхүү анхаарч, ажлын байранд тавигдах мэдлэг, ур чадварын матрицыг боловсруулан нэвтрүүлж, чадамжид суурилсан сургалт хөгжлийн системийг бий болгон ажиллалаа. Үүний үр дүнд шалгуур хангасан ажилтнуудыг гадаад, дотоодын мэргэшүүлэх сургалтанд хамруулан, сургалтын дараах үнэлгээг хийн, сургалт хөгжлийн үйл явцад сайжруулалтыг тогтмол хийж байна.

Ажилтнуудын хувийн ур чадварыг нэмэгдүүлэх, хөгжүүлэх, сургалтаас олж авсан мэдлэгээ баталгаажуулах зорилгоор бусдадаа мэдлэгээ хуваалцах, дотооддоо сургалт зохион байгуулах, үр дүнтэй хөтөлбөр хэрэгжүүлэх боломжоор ханган, дэмжлэг үзүүлдэг. Мандал даатгал нь ажлын байр бүрд эзэмшсэн байх шаардлагатай мэдлэг, ур чадварыг тодорхойлсноороо ажилтан өөрийн хувийн ур чадварыг хөгжүүлж, нээлттэй ажлын байранд дотооддоо шударга өрсөлдөх боломжийг хангаж, карьер өсөх, сэлгэн ажиллах системийг бий болгосон нь хувь хүний



Ажлын байрны “Нээлттэй сонгон шалгаруулалт”-ын сургалтанд хамрагдаж байхдаа, намайг зөв яваасай гээд бүх юманд зааж чиглүүлж байдаг эцэг эх, ах эгч нар болон багш нараасаа ч сонсож байгаагүй хувь хүний хөгжил, ажил хийх арга барил, борлуулалтын ур чадвар эзэмшүүлэх талаар сургалтанд үнэ төлбөргүй хамрагдаж, сургалтын дараа ажилд тэнцэхгүй байсан ч харамсахгүй гэх бодол зурсхийхийн зэрэгцээ Мандал даатгалд ажилд орох хүсэл улам л оргилж байсныг тодхон санаж байна.

**Ц.ОРГИЛБАЯР**  
Сувгийн борлуулалт хариуцсан менежер

хөгжил, карьер хөгжлийг дэмжсэн бодлогын хэрэгжилт билээ.

## ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, УРАМШУУЛЛЫН БОДЛОГО

Мандал даатгал нь ажлын байруудыг харьцуулан үнэ цэнэ, ач холбогдлыг системчлэн тодорхойлж, ажлын байрны үнэлгээ, зэрэглэлийг тогтоох замаар ажлын байрны үнэлгээг хийсэн. Ингэснээр, ажилтны чадамжид суурилсан цалин урамшууллын системийг боловсронгуй болгон, мөнгөн болон мөнгөн бус урамшууллын системийг хэрэгжүүлж эхлээд байна. Мандал даатгалын ажилтан бүрийн хийх ажил үүрэг нь тодорхой, хүрэх үр дүн нь тодорхой байснаар ажлынхаа зорилгыг ухамсарлах, хамтын хүчээр бүтээмжтэй ажиллах суурь нөхцлийг бүрдүүлдэг.

Мөн ажилтнууддаа гүйцэтгэл, борлуулалтанд суурилсан урамшуулал олгохоос гадна хувь хүний ур чадварыг хөгжүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамруулах, хагас жилийн болон жилийн гүйцэтгэл хангасан ажилтнуудад шалгаруулан гадаад, дотоодод аялах эрхээр урамшуулдаг.



Ажлын хамт олон, хийж буй ажлаасаа суралцаж, хөгжих боломж надад үргэлж байсны үрээр өнгөрсөн 6 жилийн хугацаанд 3 удаа албан тушаал ахиж хувь хүнийхээ хувьд дуртай зүйлээ хийж, түүнээсээ суралцаж, хичээл зүтгэл, уйгагүй зан чанар, хөдөлмөрч зүрх сэтгэлийн хүчийг үлгэрлэсэн багийн гишүүн болсон. Харилцагч, үйлчлүүлэгчид учирсан аливаа санхүүгийн бэрхшээлийг хүндрэлгүй даван туулахад өөрийн зүгээс хувь нэмэр оруулан ажиллаж байгаадаа сэтгэл хангалуун байж, хийж буй ажлаараа үргэлж бахархаж явдаг.

**Г.МӨНХТҮВШИН**  
Нөхөн төлбөр хариуцсан менежер

Мандал даатгал нь ажилтнуудынхаа цалин урамшууллын системийг боловсронгуй болгож, ур чадварт суурилсан цалингийн сүлжээг бий болгон, цалингаа 15 хувиар нэмсэн ба энэ нь даатгалын салбартаа тэргүүлэх эгнээнд хүрсэн үйл ажиллагаа болсон. Компанийн хувьд цаашид салбартаа өрсөлдөхүйц цалинтай болох зорилт тавин ажиллаж байна.

## АЖИЛТНУУДАД ЧИГЛЭСЭН БОДЛОГО, ХӨТӨЛБӨР

Мандал даатгал нь ажилтан, харилцагчийн хоорондын эерэг харилцааг бий болгох, харилцагчийг халамжлах, үйлчилгээг өндөр түвшинд хүргэхийг зорихын зэрэгцээ бүхий л түвшиний ажилтнуудыг ажилдаа сэтгэл ханамжтай, хамт олонтойгоо эерэг харилцаатай хамтран ажиллах таатай орчныг бий болгох, компанийн амжилтыг бүтээлцэхэд анхаарч ажилладаг. 2019 онд ажилтнуудынхаа сэтгэл ханамж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, компанидаа итгэх итгэл үнэмшлийг батжуулах зорилгоор Үнэт зүйлст суурилсан хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүллээ.

Бид компанидаа Зөв хүчтэй соёлыг хөгжүүлэх бодлогыг баримтлан, эрүүл мэндэд чиглэсэн хөтөлбөр, ажилтны оролцоог дэмжсэн олон талт төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, ажилтнуудын шинэ санал, санаачлагыг дэмжих, мэргэжлийн болон сайн дурын клубыг байгуулах, хөгжүүлэх системийг бий болгон ажиллаж байна. Мөн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, эрүүл мэндийн даатгалд үнэ төлбөргүй хамруулахын зэрэгцээ гэр бүлийн гишүүдээ хөнгөлттэй нөхцлөөр даатгуулах, ажлын цагийн уян хатан боломж, хөнгөлөлт, урамшуулал, хангамжийн багцыг шинэчилсэн зэрэг ажилтан төвтэй байгууллагын соёлыг бүрдүүлэн ажиллаж байна.



Даатгалын үндсэн үйл ажиллагаа нь нийгэмдээ эерэг нөлөөллийг авчирдаг. Тиймээс ажлаараа дамжуулан олон хүмүүст санхүүгийн, сэтгэл санааны туслалцааг үзүүлж чаддаг гэдэгтэй итгэдэг. Миний ажлын нэг үүрэг нь харилцагчаас ирсэн санал, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх. Энэ үүрэг заримдаа хэцүү санагддаг боловч бусдад туслах бас нэгэн боломжийг олгодог нь миний хувьд үнэ цэнэтэй байдаг. Харилцагчийн санал гомдлоор дамжуулан байгууллагынхаа үйл ажиллагаанд өөрчлөлт, шинэчлэлтийг хийдгээрээ миний ажил сонирхолтой.

**Ч.ДАРХАНЦЭЦЭГ**  
Үйлчилгээний ахлах мэргэжилтэн

# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

*Даатгалын компани фундаментал мөн чанарынхаа хувьд яаж ажиллах ёстой түүгээрээ ажиллахад л нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлдэг онцлог бизнес хэдий ч бид 2019 онд нийгмийн эрсдэлийн боловсролыг нэмэгдүүлэх, олон нийтийн эдийн засгийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх чиглэлд хэд хэдэн томоохон ажлуудыг зохион байгууллаа.*

Байгууллага бүр эрсдэлтэй нүүр тулж байдаг. Энгийнээр хэлбэл эрсдэлийг удирдах олон аргуудаас тохиромжтойг нь сонгож, хамгийн бага зардлаар байгууллагын эрсдэлийг бууруулах арга хэмжээ бол эрсдэлийн удирдлага юм. Эрсдэлийн удирдлагыг амжилттай зохион байгуулахын тулд байгууллага доторх бүх ажилтан эрсдэлийн талаар ойлголттой байх ёстой. Өөрөөр хэлбэл, ямар ч чадварлаг эрсдэлийн мэргэжилтэнтэй байсан тухайн нэг ажилтан нь ганцаараа тэр байгууллага эрсдэлийг амжилттай удирдаж чадахгүй билээ. Иймээс, эрсдэлийн мэргэжилтнүүдийн хамгийн их анхаарах ёстой зүйл бол байгууллагынхаа бусад ажилтнууд болон харилцагч нартаа эрсдэлийн удирдлагын цогц ойлголт өгөх явдал юм. Ийм ч учраас, Мандал даатгал нь анх байгуулагдсан цагаасаа эхлэн эрсдэлийн боловсролыг тасралтгүй түгээх, ард иргэд, албан байгууллагуудад эрсдэлээс урьдчилан сэргийлэх зан төлвийг хэвшүүлэх, эрсдэлгүй нийгмийг бүтээхэд өөрийн хувь нэмрээ оруулах чиглэлд тасралтгүй хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Даатгалын компани фундаментал мөн чанарынхаа хувьд яаж ажиллах ёстой түүгээрээ ажиллахад л нийгмийн агуу хариуцлагыг хэрэгжүүлдэг онцлог бизнес хэдий ч бид 2018 онд нийгмийн эрсдэлийн боловсролыг нэмэгдүүлэх, олон нийтийн эдийн засгийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх чиглэлд хэд хэдэн томоохон ажлуудыг зохион байгууллаа.

## ЭРСДЭЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ЧИГЛЭЛД

### Монголын эрсдэлийн удирдлагын форум

Мандал даатгал компаниас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Монголын эрсдэлийн удирдлагын форум” арга хэмжээний 10 жилийн ой 2019 онд тохиосон байна. Уг форум нь Монгол Улсын нийгэм, эдийн засаг, бизнесийн салбарт тулгардаг эрсдэлүүдийг судлан шинжилж, тэдгээрийг удирдах арга замуудыг мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор хэлэлцэн боловсруулж, эрсдэлээс сэргийлэх, түүнийг бууруулахад тодорхой хувь нэмэр оруулдаг өндөр ач холбогдолтой арга хэмжээ юм.

“Монголын эрсдэлийн удирдлагын форум” арга хэмжээ зохион байгуулагдсанаас хойш нийт 3,000 орчим бизнес эрхлэгчид, компанийн удирдлагууд хамрагдаж, 10 жилийн хугацаанд нийт 70 орчим эрсдэлийн талаар илтгэл хэлэлцүүлгүүд хийгдэж, 10 эрсдэлийн тайланг эмхтгэн гаргасан байна. Мөн уг арга хэмжээнээс “Үндэсний суурь эрсдэлийн индекс” тайлан бий болсноор Монгол Улс анх удаа эрсдэлээ дэлхийн стандартын дагуу хэмжиж, сэргийлэх арга хэмжээ авах эхлэл тавигдсан юм.

Энэ удаагийн эрсдэлийн форумтаар “2020 оны макро эдийн засгийн эрсдэл ба бизнесийн төлөвлөгөө” болон “Байгууллагын эрсдэлийн удирдлага ба бодит алхмууд” гэсэн сэдвийн хүрээнд хэлэлцүүлгүүд өрнөсөн билээ.

Арга хэмжээний эхний хэсэгт хувийн хэвшлийнхэнд 2020 оны бизнес төлөвлөгөө гаргахдаа анхаарах макро эдийн засгийн дүр төрх, Монгол улс саарал жагсаалтад орсноос валютын ханшийн эрсдэл нэмэгдэж байгаа, мөн ирэх жил сонгууль болохтой холбоотойгоор бизнесийн орчин, зах зээлд тодорхой өөрчлөлт орсноор үүсч болзошгүй эрсдэлүүд болон боломжуудыг мэргэжлийн шинжээчид хэрхэн таамаглаж байгааг танилцууллаа. Энэхүү хэлэлцүүлэгт хувийн хэвшлийнхнээс гадна Монголбанк болон МХБ төлөөллүүдийг оролцуулсан. Түүнчлэн, Мандал даатгалаас “Үндэсний суурь эрсдэлийн индекс”-ийг тооцоолсон үр дүнгээ танилцууллаа.

Форумын хоёрдугаар хэсэгт бизнесийн орчинд шинээр түрэн гарч ирж буй зарим эрсдэлүүд болох эрүүл мэндийн эрсдэл, ажилтны бүтээмжийн асуудал болон нийгмийн халуун сэдэв болсон Оюу толгой төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн билээ.



### Үндэсний суурь эрсдэлийн индекс

2019 онд Мандал даатгалын хамт олны зүгээс уламжлал ёсоор “Үндэсний суурь эрсдэлийн индекс”-ээ шинэчлэн тооцоолж, Монгол Улсын эрсдэлийн тоймыг 7 дах удаагаа бэлтгэн гаргалаа.

“Үндэсний суурь эрсдэлийн индекс”-ээр иргэдийн эрүүл мэнд, эд хөрөнгө болон албан байгууллагын үйл ажиллагаанд хэмжигдэхүйц, бодит хохирол учруулдаг байгалийн гамшигт үзэгдэл, нийгмийн эрсдэлүүдийг нэгтгэн тоон утгаар хэмжиж, эрсдэлийн түвшинг тодорхойлохыг зорьдог билээ.

Олон улсад эрсдэлийн түвшинд гарч буй өөрчлөлтийг тодорхойлж, үнэлэх зорилго бүхий төрөл бүрийн судалгаа байдаг ба хэд хэдэн индексийг тооцож ашигладаг. Эдгээр индекс нь улс орон бүрийн газарзүйн байршил болон нийгмийн хөгжлөөс хамааран голлох эрсдэлүүд нь харилцан адилгүй байдаг учраас манай улсад ашиглахад тохиромжтой бус юм. Тиймээс манай улсад голлон тохиолддог эрсдэлийг судалж, тэдгээр эрсдэлийг үнэлэх, бууруулах арга замыг хайх, улмаар эрсдэлийн түвшинг бууруулж, тодорхой түвшинд хүргэх нь бидний индекс тооцооллын гол зорилго юм.




“Үндэсний суурь эрсдэлийн индекс” нь 1-9 оноогоор үнэлэгдэх бөгөөд индексийн тоон утга их байх нь эрсдэлийн түвшин өндөр байгааг илэрхийлнэ. Индексийг нэг жилийн туршид тохиолдсон эрсдэлийн статистик мэдээлэлд тулгуурлан жилд нэг удаа тооцоолдог.

2018 онд индексийн утга 4.8 гарчээ. Мөн дээрх эрсдэлүүдийн улмаас эрүүл мэнд, эд хөрөнгөнд 1 их наяд 160 гаруй тэрбум төгрөгийн санхүүгийн “шууд” хохирол учирсан байна. Үүний 75 орчим хувийг эрүүл мэндийн зардал эзэлж байна. Энэ нь ижил аргачлалаар тооцсон өмнөх оны хохирлын хэмжээнээс 99 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Үүнд, үерийн улмаас учирсан хохирол 21 тэрбум төгрөгөөр, хувийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 55 тэрбум төгрөгөөр, улсын эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн зардал 50 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.



**ҮНДЭСНИЙ ЭРСДЭЛИЙН ИНДЕКС**



Индекс тооцож, эрсдэлийг хэмжсэнээр иргэн бүр эрсдэлийн улмаас учирч болох хор хохирлыг ойлгодог, түүнээс урьдчилан сэргийлэх, хохирлын хэмжээг бууруулах арга замын талаар мэдлэгтэй байж, өөрийн өдөр тутмын ахуй амьдралдаа дадал зуршил болгон хэвшүүлэхэд тус дэм болох юм.

**ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ТӨСЛҮҮД**

**Дэлхийн санхүүгийн түүхийн музей**

Мандал даатгал компани 2019 онд олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор Дэлхийн санхүүгийн түүхийн музейг байгуулах үйл ажиллагааг дэмжин ажиллалаа. Монгол төдийгүй дэлхийд ховорт тооцогдох тус музей нь 2019 оны 10 сарын 23-ны өдөр албан ёсоор нээлтээ хийж, олон нийтэд үйлчилж эхэлсэн билээ. Нээлтээ хийсэн өдрөөс хойш 1,500 гаруй хүн музейг үзсэн бөгөөд хувь хүмүүс, албан байгууллага, олон нийтийн зочлох дуртай музей болоод байна.

Тус музей нь 2019 оны 11 сард Монгол улсаа төлөөлөн Олон улсын санхүүгийн музейнүүдийн холбооны (IFFM) 13 гишүүн улсын нэг болсон билээ.

Музейд нийт 1,000 гаруй эх хувилбар бүхий түүхийн хосгүй үзмэрүүд толилуулагдаж байгаа бөгөөд дэлхийн санхүүгийн түүх, санхүүгийн системийг бүхэлд нь мөнгө, банк, даатгал, төлбөрийн хэрэгсэл, хөрөнгийн зах ба эдийн засаг гэсэн хоорондоо уялдаа холбоо бүхий 6 хэсэгт хуваан харуулдаг. Мөн музейд эртний Ромын шилэн эдлэл, Грекийн ваар зэрэг соёл урлагийн түүхийг илтгэх үзмэрүүд байрлаж байна.

Одоогоор Дэлхийн санхүүгийн түүхийг бүхэлд нь ийнхүү харуулсан музей дэлхийд өөр байхгүй бөгөөд зөвхөн Улаанбаатар хотод оршин байгаа нь бидний бахархал юм. Музейн үзмэрүүдийг олон улсын дуудлага худалдаанд оролцох, нэр хүндтэй цуглуулагч нараас худалдан авах замаар ертөнцийн өнцөг булан бүрээс 10 гаруй жилийн турш цуглуулан бүрдүүлсэн байна.

**Mandal Lectures арга хэмжээ**

Улс орны эдийн засгийг нуруун дээрээ үүрч явдаг мянга мянган аж ахуй нэгжүүд, тэдгээрийг удирдаж буй захирлууд, менежерүүд, шилдэг мэргэжилтнүүдэд зориулсан менежментийн чанартай контент хомс, бизнесийн арга туршлага солилцож, бие биенийхээ алдаа дутагдлаас суралцах боломжийг олгох платформ нь хангалтгүй байна. Иймд, Мандал даатгал компанийн зүгээс менежментийн туршлагаа хуваалцах, менежерүүдийг илүү чадавхжуулах зорилгоор “Mandal Lectures” цуврал арга хэмжээг өөрийн харилцагчид, хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд зориулан зохион байгууллаа.

Уг арга хэмжээгээр “Менежментийн психологи”, “Зан төлвийн эдийн засаг”, “Value Investing in Stocks”, “Монгол менежерийн бүтээмж” зэрэг эдийн засаг, менежментийн халуун сэдвүүдээр илтгэлүүд тавигдсан байна. Нийт гурван удаагийн арга хэмжээнд 300 орчим удирдах албан тушаалтнууд, менежерүүд хамрагдсан бөгөөд Мандал даатгалын зүгээс цаашид энэхүү арга хэмжээний цар хүрээг нь улам нэмэгдүүлэн уламжлал болгон зохион байгуулна.



**Хөрөнгийн зах зээлийн мэдлэг олгох хичээл**

Монгол Улсын санхүүгийн зах зээлийн 90 орчим хувийг банкны салбар дангаар эзэлдэг. Харин хөрөнгийн болон даатгалын салбарын хөгжил ийнхүү багахан хувийг эзэлж байгаа нь манай улсын эдийн засаг тогтворгүй байгаагийн нэг шалтгаан. Орхигдоод буй тэр салбаруудыг хөгжүүлэхийн тулд энэ талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, бодит мэдээллээр хангах нь хамгийн чухал.

Иймд, Мандал даатгалын зүгээс Монголын хөрөнгийн зах зээлийн судалгаа хөгжлийн нийгэмлэгээс санаачлан хэрэгжүүлсэн олон нийтэд хөрөнгийн зах зээлийн талаар боловсрол олгох “Заавал үзэх зургаан цуврал” онлайн сургалтын платформ бий болгоход дэмжин ажиллалаа.

# MNDL ХУВЬЦАА

## ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

2018 оны 9-р сард МХБ-ээр дамжуулан IPO (Initial Public Offering) хийж, олон нийтэд компанийн нийт хувьцааны 25 хувийг эзэмшүүлэн, 7.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг амжилттай татан нээлттэй хувьцаат компани болсон билээ.

## ХУВЬЦААНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

<b>Зах зээлийн үнэлгээ</b>	<b>31.5 тэрбум ₮</b>
Нийт хувьцааны тоо	<b>624,301,600 ширхэг</b>
Хаалтын ханш 12/31/2019	<b>50.39 ₮</b>

Эх сурвалж: МХБ

EPS 2019	P/E харьцаа	P/B харьцаа	ROA /нийт хөрөнгийн өгөөж/	ROE /өөрийн хөрөнгийн өгөөж/
<b>9.3</b>	<b>5.4</b>	<b>1.5</b>	<b>16%</b>	<b>32%</b>

Эх сурвалж: Компанийн тайлан, МХБ

Мандал даатгал компани 2019 онд олон нийтэд хувьцаа гаргаж байх үеийн санхүүгийн байдлын төсөөллөөс мөнгөн хөрөнгө 31 хувь, хөрөнгө оруулалтын орлого 65 хувь, цэвэр ашиг 67 хувийн тус тус өсөлттэй ажиллажээ.

Үзүүлэлт, тэрбум төгрөгөөр	2019	2019	Өсөлт
	IPO төсөөлөл	Гүйцэтгэл	
Мөнгөн хөрөнгө	21.7	28.5	<b>31%</b>
Хураамжийн орлого	28.3	28.9	<b>3%</b>
Хөрөнгө оруулалтын орлого	2.3	3.7	<b>65%</b>
Цэвэр ашиг	3.4	5.8	<b>67%</b>

## ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

Мандал даатгалын хувьцаа нь MNDL симболтойгоор МХБ-ийн I ангилалд арилжаалагдаж байна. Энэ ангилалд сүүлийн жилд 5 тэрбум төгрөгөөс доошгүй хэмжээний борлуулалтын орлоготой эсхүл 1 тэрбум төгрөгөөс доошгүй хэмжээний цэвэр ашигтай, нийт хувьцааны 25 - аас доошгүй хувийг олон нийтэд санал болгосон байх зэрэг чанарын үзүүлэлт хангасан 14 компани багтдаг.

MNDL хувьцаа

**Нийт арилжааны дүн**


2.1 тэрбум ₮

Өдрийн дундаж арилжаа	9.3 сая ₮
Өдрийн дундаж арилжааны ширхэг	181,665 ширхэг
52 долоо хоног өндөр ханш	56.45 ₮
52 долоо хоног бага ханш	45.45 ₮

Эх сурвалж: МХБ

МХБ-д бүртгэлтэй компаниудыг зах зээлийн үнэлгээ, арилжааны өдрийн дундаж гүйлгээ, арилжаанд орсон өдрийн тоо, төвлөрлийн байдал зэрэг үзүүлэлтүүдээр үнэлэн МХБ-ийн шилдэг 20 хувьцаат компаниар зах зээлийн жишиг болгон тооцдог ТОП-20 индекст 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс багтах болсон нь олон нийтээс тавьж буй сайн үнэлгээний илрэл болсон.

**2019 ОНЫ MNDL ХУВЬЦААНЫ ҮНЭ БА АРИЛЖААЛАГДСАН ШИРХЭГ**



Эх сурвалж: МХБ

MNDL хувьцаа

**Ногдол ашиг**

Мандал даатгал компанийн ТУЗ-ийн 2019 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн №19/001 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нийт 624.3 сая төгрөг буюу компанийн нэгж хувьцаанд 100 төгрөгийн ногдол ашгийг хуваариллаа.

**Компанийн хувьцааг 100 хуваалаа.**

Нэгж хувьцааны ханш өндөр байх нь арилжааны идэвх бага байх хандлагатай байдаг учир ерөнхийдөө хувьцааны арилжааны идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор хуваалт хийдэг. Хувьцааны хуваалт нь нэгж хувьцааны үнийг хувааж, хуваасан хэмжээгээр хувьцааны ширхгийг үржүүлснээр нийт зах зээлийн үнэлгээнд өөрчлөлт оруулдаггүй бүртгэлийн арга юм.

Компанийн хувьцааг 100 хуваах замаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтийг СЗХ хэлэлцэн 2019 оны 11 дүгээр сарын 28-ний өдрөөс үнэт цаасны арилжааг түр зогсоож 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдөр арилжааг ахин нээснээр компанийн хувьцааг 100 хуваалаа.

**Хувьцааны тоо**

**Хуваалт хийхийн өмнө**

**Хуваалт хийсний дараа**

6,243,016 ширхэг

624,301,600 ширхэг

**Хөрөнгө оруулагчдад чиглэсэн үйл ажиллагаа**

Мандал даатгал нь санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаа улирал бүр цаг алдалгүй олон нийт, хөрөнгө оруулагчдадаа танилцуулж, хувьцаат компаниудын дунд жишиг тогтоон ажиллаж байна.

Мөн хөрөнгийн зах зээлд оролцогчдын дунд Analyst call үйл ажиллагааг зохион байгуулж, институционал хөрөнгө оруулагчийн үүргээ гүйцэтгэн, хөрөнгө оруулагчидтайгаа уялдаа холбоотойгоор явуулж байна. Түүнчлэн, зах зээлд институционал хөрөнгө оруулагчийн ач холбогдлыг таниулах болон үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор тодорхой ажлууд хийгдэж байна.

**ХУВЬЦААНЫ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛЛАА**

Хөрөнгийн зах зээлд оролцогч нарын судалгаа шинжилгээний ур чадварыг хөгжүүлэх, хувьцааны хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор Мандал даатгалын зүгээс хувьцааны шинжилгээний уралдааныг амжилттай зохион байгууллаа.

Энэхүү уралдаан 2 үе шаттай зохион байгуулагдсан бөгөөд 30 гаруй судлаач шинжээчид, салбарын мэргэжилтэн, оюутан залуус, хөрөнгийн зах зээлийн сонирхогчид нээлттэй оролцож, ирүүлсэн материалуудаас нэгдүгээр шатанд хамгийн өндөр оноо авсан 8 оролцогчийн судалгааг хэлэлцүүлэгт оруулж шилдгийн шилдэг 3 бүтээлийг 9-р сарын 24-нд шалгаруулсан байна.





- ◆ Мандалын засаглал
- ◆ ТУЗ-ийн гишүүд
- ◆ Гүйцэтгэх удирдлага
- ◆ Удирдлагын баг

# 04

## МАНДАЛЫН ЗАСАГЛАЛ

# МАНДАЛЫН ЗАСАГЛАЛ

*Корпорацын сайн засаглалын тэргүүн туршлагауудыг бизнесийн байнгын үйл ажиллагаандаа тусгаж, сайн засаглалтай, сайн удирдлагатай компанийг цогцлоох нь Мандал даатгалын эрхэм зорилго, алсын харааг биелүүлэхэд чухал үүрэгтэй.*

Компанийн засаглал нь компанийн гүйцэтгэх удирдлага, ТУЗ, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын хоорондох цогц харилцаа бөгөөд компанийн зорилтыг тодорхойлох, тэдгээр зорилтод хүрэх арга зам, гүйцэтгэлийг хянах тогтолцоог бий болгодог хэрэгсэл юм. Корпорацын сайн засаглалын туршлагыг бизнесийн байнгын үйл ажиллагаандаа тусгаж, сайн засаглалтай, сайн удирдлагатай компанийг цогцлоох нь Мандалын эрхэм зорилго, алсын харааны салшгүй хэсэг билээ.

## Корпорацын сайн засаглал гэдэгт:

- Системтэй шийдвэр гаргах үйл явцтай байх,
- Хариуцлагын талаар ойлголт өгөх,
- Ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх,
- Дотоод хяналтыг сайжруулах,
- Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх,
- Ил тод байдлыг хангах зэрэг үйл ажиллагаа багтана.

Компанийн засаглалын тухайн хэсэгт Мандал даатгалын Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн эрх үүрэг, хариуцлага, санхүүгийн тайлагналтай холбоотой компанийн дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын талаар тусгалаа.

## ЭРХ МЭДЭЛ, ХАРИУЦЛАГЫН ХУВААРИЛАЛТ

Компанийн хяналт болон удирдлага нь хувьцаа эзэмшигчид (Хувьцаа эзэмшигчдийн хурлаар), ТУЗ, гүйцэтгэх захирал нарт гадаад зохицуулалт болон ТУЗ-өөс тогтоосон дотоод дүрэм, журмаар зохицуулагдан хуваарилагддаг.


## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Мандал даатгал компанийн эрх барих дээд байгууллага нь “Хувьцаа эзэмшигчдийн хурал” юм. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн үйл ажиллагааны талаар гаргаж буй чухал шийдвэрүүдийг хэлэлцэн шийдвэрлэх, ногдол ашгийн бодлого тодорхойлох, ТУЗ-ийн гишүүдийг сонгох, компани дээр хийгдэж буй хэлцлүүдийг хянах үүрэгтэй.

Мандал даатгал 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 4 сарын 29-ны өдөр Новотел зочид буудалд зарлан хуралдуулсан билээ. Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн баталсан байна. Үүнд:

1. Компанийн 2018 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг тайлагнах;
2. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
3. Компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулах;
4. Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;
5. Компанийн хувьцааг хуваах тухай асуудлыг хэлэлцэн батлах;
6. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэн батлах;

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Мандал даатгал компанийн ТУЗ нь компанийн урт хугацааны амжилтыг ахиулах, хувьцаа эзэмшигчдэд тогтвортой үнэ цэнийг бий болгох, ил тод нээлттэй байдал, эрүүл мэтгэлцээний соёлыг дэмжихийг зорьдог.

### Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц

Мандал даатгал компанийн дүрэмд тусгагдсанаар ТУЗ нь 9 гишүүнтэй байхаас 3 нь хараат

бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 3 жил байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуулснаар бүрэн эрх нь үргэлжилнэ.

Компанийн засаглалын кодексын дагуу ТУЗ-д аудит, нягтлан бодох бүртгэл, санхүү, хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн дадлага туршлага бүхий хүнийг гишүүнээр сонгон ажиллуулахыг зөвлөсөн байдаг. Түүнчлэн ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь компанийн үйл ажиллагаа, хөгжлийн үе шат болоод бусад нөхцөлтэй уялдсан байх шаардлагатай.

Мандал даатгал компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг тодорхойлоход, зөвлөлийн үр ашигтай байдлыг хадгалах, дээшлүүлэх явдлыг ихээхэн анхаардаг.

2018 оны 12 сарын 12-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын санал хураалтын үр дүнд үндэслэн, Мандал даатгал компанийн ТУЗ-ийн гишүүнээр дараах хүмүүсийг томилсон байна.

Ердийн гишүүнээр:

- Өлзийбаяр ГАНЗОРИГ
- Нямдаваа МОНСОР
- Очирпүрэв ГАНЖОЛОО
- Амартүвшин АМУНДРА
- Чулуун ВАНЧИН-ЭРДЭНЭ
- Батсайхан ЖАВХЛАН

ТУЗ-ийн хараат бус гишүүнээр:

- ЖЭЙМС Бернард Двайер
- Жамсрандорж ДЭЛГЭРСАЙХАН
- Нямандэлэг МАНДУУЛ

### Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх, үйл ажиллагаа

ТУЗ нь компанийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтэд хяналт тавин удирдан чиглүүлж ажилладаг. Жилийн төлөвлөгөө, стратегийн зорилтууд, үйл ажиллагааны хяналт, эрсдэлийн удирдлага, хөрөнгө оруулалт, гүйцэтгэх удирдлага томилох зэрэг асуудал нь ТУЗ-өөр хянагдан, батлагддаг.

ТУЗ нь санхүүгийн болон стратегийн бусад зорилт, бизнесийн гол сорилтууд, эрсдэл, бизнесийн хөгжил, хөрөнгө оруулагч, гадаад харилцааны гүйцэтгэлийн тайланг тогтмол хянах үүрэгтэй. Мөн компани нь ТУЗ-ийн гишүүдийг бүх түвшинд удирдлагуудтай чөлөөтэй, нээлттэй харилцах, холбогдох бүх мэдээлэлд хандах боломжоор ханган ажиллаж байна.

## ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Засаглалын кодексыг хангах, ТУЗ-ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ТУЗ-ийн дэргэд туслах ажлын хэсгүүдийг байгуулан ажилладаг. ТУЗ-ийн хороодын эрх үүрэг, үйл ажиллагааг тус бүрийн хороодын журмаар тодорхойлсон болно. Хороод нь улирал бүр тогтмол хуралдаж, үйл ажиллагаагаа ТУЗ-д тайлагнадаг.

### Аудит, эрсдэлийн хороо

Мандал даатгал компанийн үйл ажиллагаа нь бүхэлдээ эрсдэлийг хэмжих, үнэлэх, удирдахтай холбоотой байдаг. Иймд ТУЗ дэргэдээ эрсдэлийн удирдлагын тогтолцоог хөгжүүлэх, хянах үүрэгтэй “Аудит, эрсдэлийн хороо”-г ажиллуулж байна.

ТУЗ-ийн дэргэдэх Аудит, эрсдэлийн хороо нь компанийн дотоод журам, тушаалын хэрэгжилт, биелэлтэд хяналт тавих, хууль эрх зүйн гол эрсдэлүүдийг тодорхойлон хянах үүрэгтэй.

Мөн компанийн дотоод аудитын нэгж, хөндлөнгийн аудитын байгууллагын хоорондын харилцааг зохицуулах, санхүүгийн мэдээллийн үнэн зөв, ил тод, бүрэн бүтэн байдлыг шалгаж батлах, дотоод хяналтын системийг хянах, ТУЗ-д мэдэгдэх үүрэгтэй билээ.

Түүнчлэн компанийн нийт хүлээгдэж буй хариуцлага, түүнд харгалзах нөөцийн сан, эрсдэл даах чадварын шинжилгээтэй улирал бүр танилцаж, зохих заавар зөвлөмжийг гарган ажиллаж байна. Аудит, эрсдэлийн хороо нь 3 гишүүнтэй бөгөөд үүнээс 2 гишүүн нь хараат бус гишүүн байна. Аудит, эрсдэлийн хороог ТУЗ-ийн хараат бус гишүүн Жэймс Бернард Двайер даргалдаг.

### Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо

Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо нь зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг идэвхжүүлэх, компанийн болон гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлийг хянах, гүйцэтгэлд суурилсан цалин урамшууллын асуудлыг зохицуулах бодлогыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, ТУЗ-д нэр дэвшигчийг сонгон шалгаруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлэх үүрэгтэй.

Засаглалын кодексын дагуу хорооны гишүүд нь компани болон удирдлагын багаас хараат бус байхыг шаарддаг бөгөөд хорооны бүрэлдэхүүн нь энэхүү дүрэмтэй бүрэн нийцэлтэй болно. Мандал даатгалын Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд үүнээс 2 гишүүн нь хараат бус гишүүн байна.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



### Өлзийбаяр ГАНЗОРИГ | ТУЗ-ийн дарга

Ө.Ганзориг санхүүгийн зах зээл дээр 20 орчим жил ажилласан туршлагатай. Тэрбээр даатгал, банк, хөрөнгийн захаар дагнан мэргэшихдээ Монгол Улсын санхүүгийн зах зээлийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан мэргэжилтэн билээ.

Өнгөрсөн хугацаанд Голомт банк, Тэнгэр даатгал, Улаанбаатар хотын банк, Голомт капитал, Худалдаа Хөгжлийн банк, Хас банк, Капитрон банк зэрэг байгууллагуудад хариуцлагатай албан тушаал хашихаас гадна Монголбанкны мөнгөний бодлогын зөвлөлийн гишүүн, МХБ-ийн ТУЗ-ийн гишүүн, Татварын ерөнхий газрын бодлогын зөвлөлийн гишүүн, СЗХ-ны бодлогын зөвлөлийн гишүүн, Ерөнхий сайдын дэргэдэх эдийн засгийн зөвлөлийн гишүүн, Монголын даатгагчдын холбооны дэд ерөнхийлөгч, Монголын банкуудын холбооны ерөнхийлөгчөөр тус тус сонгогдон ажиллаж иржээ.

Ө.Ганзориг нь Мандал даатгалын үүсгэн байгуулагч бөгөөд ТУЗ-ийн дарга юм. Мөн Санхүүгийн зах зээлийн холбооны ерөнхийлөгчөөр ажиллаж байна.

Ө.Ганзориг нягтлан бодох бүртгэлийн бакалавр, санхүүгийн удирдлагын диплом, бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй. Мөн Олон улсын санхүүгийн зах зээлийн холбооны дилерийн сертификатыг эзэмшдэг.



### ЖЭЙМС БЕРНАРД ДВАЙЕР | ТУЗ-н хараат бус гишүүн

Жэймс Двайер нь Нью Йорк хотод хөрөнгө оруулалтын банкираар 30 гаруй жил ажилласан туршлагатай банкир юм. Тэрээр Shearson Loeb Rhoades болон UBS зэрэг дэлхийн томоохон хөрөнгө оруулалтын банкуудын M&A нэгжийг удирдан ажиллаж байжээ.

Двайер нь анх 2001 онд Худалдаа хөгжлийн банкны хувьчлалын асуудлаар Монголын Засгийн газрыг төлөөлөх хөрөнгө оруулалтын банкираар Монголд зочилж байсан бөгөөд Хаан банкны хувьчлалд хөрөнгө оруулалтын зөвлөхөөр мөн ажилласан байна. Тэрээр 2007-2016 онд Монголын Бизнесийн Зөвлөл /BCM/-ийг үүсгэн байгуулж, захирлын албан тушаалыг хашиж байв.

Жэймс Двайер Нотр Дамын Их Сургуулийн Бизнесийн удирдлагын бакалавр, Колумбын Их Сургуулийн Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй.



### Жамсрандорж ДЭЛГЭРСАЙХАН | ТУЗ-ийн хараат бус гишүүн

Ж.Дэлгэрсайхан нь Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн багш, дэд профессороор ажилладаг. Тэрээр 1996 оноос хойш СЭЗИС-д багшлахын сацуу, олон тооны судалгаа шинжилгээ, эрдмийн бүтээл туурвиж, Монгол Улсын санхүүгийн салбарт үнэтэй хувь нэмэр оруулсан эрхэм билээ.

Ж.Дэлгэрсайхан нь Санхүү банкны тэргүүний ажилтнаар тодорч байсан бөгөөд МХБ, Монголын банкуудын холбоо, СЗХ-нд зөвлөхөөр сонгогдон ажиллаж байсан туршлагатай.

Ж.Дэлгэрсайхан нь Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн эдийн засгийн бакалавр, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн эрх зүйн бакалавр, Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн Санхүүгийн удирдлагын магистрын зэрэгтэй.



### Нямандэлэг МАНДУУЛ | ТУЗ-ийн хараат бус гишүүн

Н.Мандуул нь “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Үнэт цаас бүртгэлийн хэлтсийн даргаар ажилладаг.

Тэрээр Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газарт зөвлөх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Төсвийн бодлогын санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн даргаар тус тус ажилласан туршлагатай. Мөн 2016 онд СЗХ-ны орон тооны бус гишүүнээр томилогдон ажиллаж байсан.

Н.Мандуул нь Болгар улсын Америкийн Их Сургуулийг эдийн засаг, бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй, АНУ-ын Брэндиз Их Сургуулийг бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй тус тус төгссөн байна.



### Чулуун ВАНЧИН-ЭРДЭНЭ | ТУЗ-ийн гишүүн

Ч.Ванчин-Эрдэнэ нь “Таван Богд Трейд” ХХК-ийн дэд захирлаар ажилладаг. Тэрээр, өмнө нь MCS Холдингид санхүүгийн шинжээч, “Скайтел” ХХК-д Санхүү төлөвлөлтийн хэлтэс хариуцсан захирлаар тус тус ажиллаж байсан туршлагатай.

Ч.Ванчин-Эрдэнэ нь Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуулийг Бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй төгсчээ.



### Очирпүрэв ГАНЖОЛОО | ТУЗ-ийн гишүүн

О.Ганжолоо нь “Голомт Файнэншил Групп”-ийн гүйцэтгэх захирлаар ажилладаг. Тэрээр дэлхийн хамгийн том аудитын компани болох Price water house Coopers-н Герман болон Монгол дахь салбаруудад ажиллаж ихээхэн туршлага хуримтлуулсан, туршлагатай мэргэжилтэн юм.

Мөн “Бодь Интернэшнл” ХХК-ийн санхүү эрхэлсэн захирал, Голомт банкны ТУЗ-ийн аудитын хорооны даргаар тус тус ажиллаж байв.

О.Ганжолоо нь ХБНГУ-ын Берлин хотын Чөлөөт их сургуулийн эдийн засгийн магистр зэрэгтэй.



### Амартүвшин АМУНДРА | ТУЗ-ийн гишүүн

А.Амундра нь хэвлэл мэдээллийн салбарын томоохон төлөөлөгчдийн нэг юм. Тэрээр эгнээндээ Eagle TV, Боловсрол ТВ зэрэг Монголын хамгийн олон үзэгчтэй телевизийн сувгуудыг багтаадаг Монгол Масс Медиа группийн гүйцэтгэх захирлаар 2010-2017 онуудад ажиллаж байв.

А.Амундра 2017 оноос эхлэн “Бодь Интернэшнл” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



### Нямдаваа МОНСОР | ТУЗ-ийн гишүүн

Н.Монсор нь хил дамнасан хөрөнгө оруулалт, үл хөдлөх хөрөнгийн чиглэлээр олон жилийн туршлага хуримтлуулсан туршлагатай санхүүч юм.

Тэрээр өнгөрсөн хугацаанд олон улсын томоохон хөрөнгө оруулалтын сангуудтай хамтран ажиллаж, Монгол Улсын үл хөдлөх хөрөнгө, санхүү, худалдааны салбаруудад олон арван тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татаж чаджээ. Н.Монсор МҮХАҮТанхимын даргын зөвлөх хийж байсан бөгөөд одоо Юу Эм Си Группийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Н.Монсор нь Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн компьютер техник, менежментийн сургуулийг программ хангамжийн бакалавр зэрэгтэй төгсчээ.

## ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Мандал даатгалын гүйцэтгэх захирал бизнесийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэгтэй. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн хурлуудыг үр дүнтэй зохион байгуулахад ТУЗ-ийн даргатай нягт хамтран ажилладаг.

Мөн гүйцэтгэх захирал нь компани доторх дотоод хяналтын үр ашигтай тогтолцоог боловсруулж, хадгалж байх үүрэгтэй бөгөөд үйл ажиллагаагаа ТУЗ-д тогтмол тайлагнадаг болно.

### Удирдлагын хороо

Удирдлагын хороо нь компанийн үйл ажиллагааг сар, улирлаар хянах, гүйцэтгэлийн үр дүнг хэлэлцэх, компанитай холбоотой томоохон шийдвэрүүдийг гаргах, дотоод дүрэм, журам, хэм хэмжээг тогтоох үүрэгтэй.

Удирдлагын хороо нь өөрийн удирдлагад нөхөн төлбөрийн, хөрөнгө оруулалтын, андеррайтингийн, байгууллагын соёл, ёс зүй дотоод хяналтын дэд хороодыг ажиллуулдаг.

### Нөхөн төлбөрийн дэд хороо

Нөхөн төлбөр шийдвэрлэх процессын дагуу нөхөн төлбөрийн шийдвэр гаргах, процесс болон гэрээний андеррайтингийн нөхцлүүдийг сайжруулахад чиглүүлэх, батлах зорилготой.

### Хөрөнгө оруулалтын дэд хороо

Компанийн мөнгөн хөрөнгийг үр ашигтай санхүүгийн хэрэгслүүдэд байршуулж, хөрөнгө оруулалтын өгөөжийг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтын хяналт хийх болон хөрөнгө оруулалтын зорилтуудыг батлах зорилготой.


### Андеррайтингийн дэд хороо

Даатгалын гэрээний стандартчилал болон түүнтэй холбоотой аливаа өөрчлөлтүүдийг батлах, даатгалын бүтээгдэхүүнүүдийн хүрээнд ашиглах эрсдэлийн болон хөрөнгө үнэлгээний аргачлалыг батлах, андеррайтингийн үйл ажиллагааг сайжруулах зорилготой.

### Байгууллагын соёл, ёс зүй, дотоод хяналтын дэд хороо

Байгууллагын соёлыг бүрдүүлэх, ёс зүйн дүрэм стандартыг хэвшүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны бодлого чиглэлийг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих, компанийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны процессын алдаа дутагдлыг засаж, сайжруулах арга хэмжээ авах зорилготой.

## УДИРДЛАГЫН БАГ



Н.Түмэндэмбэрэл  
Гүйцэтгэх захирлын орлогч

З.Одмаа  
Маркетинг, бизнес хөгжил  
хариуцсан захирал

Б.Жавхлан  
Гүйцэтгэх захирал

Ч.Даваадаш  
Ерөнхийлөгч

П.Оргодол  
Үйл ажиллагаа хариуцсан  
захирал

Ж.Гарваа  
Даатгалын бодлого  
хариуцсан захирал

Г.Халиунаа  
Санхүү хариуцсан  
захирал

Г.Ганзориг  
Хөрөнгө оруулалт  
хариуцсан захирал

**Батсайхан ЖАВХЛАН** | Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн

Б.Жавхлан Мандал даатгалын гүйцэтгэх захирал бөгөөд тус компанийн иргэдийн даатгалын газар, бизнес хөгжил болон эрсдэлийн удирдлагын газрыг хариуцан ажиллаж байсан, даатгалын салбарт 9 жил ажилласан туршлагатайгаас гадна мэдээлэл технологийн салбарт 2000 оноос хойш ажиллажээ. Мөн Япон Улсын Токио хотод мэдээлэл технологийн төслийн удирдагчаар 5 жил ажиллахдаа Японы зах зээлд хэд хэдэн амжилттай шийдэл нэвтрүүлсэн байна.

Б.Жавхлан нь Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийг компьютерын ухааны бакалавр зэрэгтэй дүүргэжээ.

**Чүлтэм ДАВААДАШ** | Ерөнхийлөгч

Ч. Даваадаш нь 2001 оноос эхлэн Монгол Улсын харилцаа холбоо, нефть хангамж, банк санхүү зэрэг салбаруудад ажиллаж ирсэн туршлагатайгаас гадна сүүлийн 10 гаруй жил ажиллаж буй компанийнхаа удирдлагын түвшинд ажилласан. 2008 оноос Ньюком, Мобиком группын Нютел компанийн Гүйцэтгэх Захирал, Петровис группын НИК компанийн дэд Захирал, Гүйцэтгэх Захирал, Скайтел компанийн Дэд захирал, Голомт банкны Газрын захирал, Гүйцэтгэх захирлын орлогчоор тус тус ажилласан туршлагатай.

Мандал даатгал компанийн Ерөнхийлөгчөөр 2019 оны 2-р хагасаас ажиллаж эхэлсэн тэрээр Эдийн засаг, Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй.

**Найдандорж ТҮМЭНДЭМБЭРЭЛ** | Гүйцэтгэх захирлын орлогч

Н.Түмэндэмбэрэл нь банк санхүүгийн салбарт сүүлийн 10 гаруй жил ажилласан туршлагатайгаас гадна Голомт банкны хэлтэс, газрын захирал, Хас банкны төслийн нэгжийн захирал, АНУ-ын Браунс Группд санхүү, зээлийн үйл ажиллагаа хариуцсан менежер зэрэг хариуцлагатай албан тушаалуудад ажиллажээ.

Тэрээр 2019 оноос эхлэн Мандал Даатгалын гүйцэтгэх захирлын орлогчоор томилогдон Байгууллага болон Иргэдийн даатгалын газрыг хариуцан ажиллаж байна.

Н.Түмэндэмбэрэл нь АНУ-ын Либерти Их Сургуулийн шинжлэх ухааны бакалавр зэргийг Санхүүч мэргэжлээр дүүргэснээс гадна, БНХАУ-ын Хонконг ГИФТ институтид төсөл, бүтээгдэхүүн, байгаль орчны судалгаа чиглэлээр мэргэжил дээшлүүлжээ.

**Зоригт ОДМАА** | Маркетинг, бизнес хөгжил хариуцсан захирал

З.Одмаа Мандал даатгалын Маркетинг, бизнес хөгжил хариуцсан захирал бөгөөд компанийн бизнес хөгжил, маркетинг, брэндинг, олон нийтийн харилцааг хариуцан ажиллаж байна. Тэрээр даатгалын салбарын маркетингийн чиглэлээр 10 гаруй жил ажилласан туршлагатай. Түүнчлэн маркетингийн зөвлөх үйлчилгээний компанид Ерөнхий менежерээр ажиллаж, томоохон брэндингийн компанид ажлуудыг амжилттай удирдан хэрэгжүүлж байв.

З.Одмаа нь Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй.

**Пүрэвдорж ОРГОДОЛ** | Үйл ажиллагаа хариуцсан захирал

П. Оргодол нь Мандал даатгалын Үйл ажиллагаа хариуцсан захирал бөгөөд тус компанийн захиргаа, хүний нөөцийн хэлтэс, мэдээллийн технологийн хэлтэс, бизнес процессийн хэлтсүүдийг тус тус хариуцан ажиллаж байна. Тэрээр даатгалын салбарт санхүүгийн төлөвлөлт, эрсдэлийн шинжилгээ, дотоод хяналтын чиглэлээр 5 жил ажилласан туршлагатай.

П.Оргодол нь Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн Сургуулийг эдийн засгийн бакалавр зэрэгтэй дүүргэжээ.

**Гантулга ХАЛИУНАА** | Санхүү хариуцсан захирал

Г.Халиунаа нь Мандал даатгал ХК Санхүү хариуцсан захирал бөгөөд компанийн санхүүгийн удирдлага, хөрөнгө оруулалтын удирдлагыг хариуцан ажиллаж байна. Тэрээр Голомт банк ХХК-д Удирдлагын мэдээллийн хэлтэсийн захирлаар ажиллаж байсан.

Г.Халиунаа нь Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн сургуулийн Санхүүгийн удирдлагын бакалавр зэрэгтэй.

**Жамсран ГАРВАА** | Даатгалын бодлого хариуцсан захирал

Ж.Гарваа нь Мандал даатгалын Даатгалын бодлого хариуцсан захирал бөгөөд даатгалын андеррайтинг, давхар даатгал, актуар тооцооллын бодлогыг хариуцан ажиллаж байна. Тэрээр өмнө нь тус компанийн Байгууллагын даатгал хариуцсан захирал байсан бөгөөд байгууллагын даатгалын бизнес хөгжил, борлуулалт, харилцагчийн халамжийн албуудыг тус тус хариуцан ажиллаж байсан.

Ж.Гарваа нь Бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй ба Мандал даатгалаас гадна М-Си-Эс Эй-Пи-Би ХХК болон Мон Сүү ХХК зэрэг компаниудад маркетингийн чиглэлээр ажиллаж байсан туршлагатай.

**Ганбат ГАНЗОРИГ** | Хөрөнгө оруулалт хариуцсан захирал

Г.Ганзориг нь Мандал даатгалын Хөрөнгө оруулалт хариуцсан захирал бөгөөд өмнө нь Голомт банкны ахлах эдийн засагч, Санхүүгийн зах зээлийн холбооны эдийн засагч, Юу Эм Си Альфа компанийн санхүүгийн шинжээч, Мандал даатгалын эрсдэлийн шинжээчээр ажиллаж байсан. Тэрээр Санхүү эдийн засгийн их сургуулийн санхүү удирдлагын бакалавр, Английн Лийдсийн их сургуулийн эдийн засгийн ухааны магистр зэрэгтэй.

Г.Ганзориг нь олон нийтийн санхүүгийн боловсролыг сайжруулах зорилгоор эдийн засгийн нийтлэлүүд, нэвтрүүлэг зэргийг тогтмол хүргэдэг.



# 05 АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**“ГРАНТ ТОРНТОН АУДИТ” ХХК**  
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний  
дэлхийн сүлжээний бие даасан фирм

## Хараат бус аудиторын дүгнэлт

“Мандал даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд:

### Дүгнэлт

Бид “Мандал даатгал” ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2019 оны 12 дугаар сарын 31 нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болоон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлан (цаашид “санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, “Мандал даатгал” ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн 2015 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 306/307 тоот тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жэгсаалт, санхүүгийн тайлангийн мангт, тодруулга, санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Үү стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлага энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

### Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно. Үүнд:

1. Даатгагчийн байгуулсан Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сангийн хэмжээ нь аудитын актүрчийн тооцоолсон гэнэтийн осол, эмчилгээний даатгалын хэлбэрийн хувьд 341,790 мянган төгрөг, хөрөнгийн даатгалын хэлбэрийн хувьд 24,179 мянган төгрөг, хариуцлагын даатгалын хэлбэрийн хувьд 167,677 мянган төгрөгөөр тус тус дутуу байгуулжээ.

Далай тазур, 9 давхар,  
ЮНЕСКО гудамж - 31,  
Сүхбаатар дүүрэг,  
1 хороо Улаанбаатар  
14230, Монгол улс  
Т + 976 70 110744  
+ 976 70 110799

Dalai Tower, 9 floor,  
UNESCO street - 31,  
Sukhbaatar District-1,  
Ulaanbaatar 14230,  
Mongolia  
Т + 976 70 110744  
+ 976 70 110799

Бусад даатгалын хэлбэрийн хувьд тус нөөц сан хүрэлцээтэй бөгөөд барилга угсралтын даатгалын хэлбэрийн хувьд 1,746,415 мянган төгрөгийн нөөц санг байгуулсан байна.

2. СЗХ-ны 2019 оны 02-р тогтоолоор батлагдсан “Даатгалын багц дүрэм”-ийн 3-р хавсралт “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын 2.6.6-д заасны дагуу давхар даатгагчид ногдох Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан 176,651 мянган төгрөгөөр дутуу байна.
3. Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц санд СЗХ-ны 2019 оны 02-р тогтоолоор батлагдсан “Даатгалын багц дүрэм”-ийн 3-р хавсралт “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын 2.3.4-т заасан шүүхийн шатанд маргаантай байгаа 269,128 мянган төгрөгийн нэхэмжлэлийн дүнгээр дутуу байгуулсан байна.

Даатгагчид ногдох нөхөн төлбөрийн нөөцийн сан зарим хэлбэрийн хувьд хүрэлцээгүй байгаа боловч нийт дүнгээрээ 1,8 тэрбум төгрөг байхаас 3 тэрбум төгрөгийн нөөц сан байгуулсан тул хангалттай хүрэлцээтэй гэж үзлээ. Нөөцийн сантай холбоотой хэсгийг тодруулга 16-аас дэлгэрэнгүй харна уу.

### Бусад асуудал

Удирдлага бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь Компанийн 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх жилийн тайланд багтсан мэдээллээс бүрдэх ба харин санхүүгийн тайлан болон манай аудиторын тайланг багтаахгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид аливаа хэлбэрээр баталгаажуулалтын дүгнэлт илэрхийлэхгүй.

### Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компаний удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн илэрхийлэх дүрэм, журмын дагуу гүйцэтгэх, үнэн зөв тооилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайланг нь бүхэлдээ анги эсэх талаарх үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.



АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчвар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үл үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн ивуулах чадмжид мэдэгдэхүйц эргэлтээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдлыг холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

#### Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаар

Монгол улсад даатгалын үйл ажиллагааг зохицуулах үндсэн хууль тогтоомж нь Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, СЗХ-ны тогтоолоор батлагдсан даатгалын багц дүрэм, журмууд байна.

Компани нь 2015 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 306/307 тоот тушаалаар батлагдаж, 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн даатгалын байгууллагууд дагаж мөрдөх үүрэгтэй "Нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга, санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-ыг баримталж санхүүгийн тайлангаа бэлтгэсэн.

Монгол улсын Компанийн тухай хуулийн 92, 94-р зүйлд заасны дагуу сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээ, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс тогтоосон бусад мэдээлэл, Компанийн дүрэмд заасан бусад мэдээллийг тайлагнах үүрэгтэй бөгөөд эдгээр зүйлстэй холбоотой ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

#### Төлбөрийн чадварын талаар

Компанийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төлбөрийн чадварын харьцаа 157.53% (2018: 150.62%) байгаа нь Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцоолох журмын 3.12-д заасан "Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 100 хувь буюу түүнээс илүү байвал зохино" гэсний дагуу зохистой байна.

#### Аудитын тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг "Компанийн тухай" хуулийн 94-р зүйлд заасны дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



Б. ООРЖИРАВ  
УДИРДАХ ПАРТНЕР  
Монгол улс, Улаанбаатар хот  
2020 оны 2 дугаар сарын 28

Н. ЭРДЭНЭЦӨГ  
ГЭРЭЭТ АЖЛЫН ПАРТНЕР

# САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

мянган төгрөгөөр	Тодруулга	2018	2019
<b>Хөрөнгө</b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4	3,082,303	<b>904,137</b>
Даатгалын авлага	5	4,816,979	<b>6,253,418</b>
Бусад санхүүгийн хөрөнгө	6	303,965	<b>618,472</b>
Бусад санхүүгийн бус хөрөнгө	7	1,233,157	<b>867,694</b>
Хөрөнгө оруулалт	8	19,837,291	<b>27,638,364</b>
Даатгалын хөрөнгө	9	3,888,840	<b>3,857,214</b>
Үндсэн хөрөнгө	10	351,967	<b>537,192</b>
Биет бус хөрөнгө	11	33,147	<b>69,519</b>
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	12	236,640	-
<b>Нийт хөрөнгө</b>		33,784,289	<b>40,746,010</b>
<b>Өр төлбөр ба эзэмшигчийн өмч</b>			
Өр төлбөр			
Даатгалын өглөг	13	1,065,374	<b>1,850,517</b>
Бусад санхүүгийн бус өр төлбөр	14	645,614	<b>738,085</b>
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	15	13,115,353	<b>12,834,046</b>
Нөхөн төлбөрийн нөөц сан	16	3,383,397	<b>4,594,113</b>
Нийт өр төлбөрийн дүн		18,209,738	<b>20,016,761</b>
Эздийн өмч			
Хувьцаат капитал		6,243,016	<b>6,243,016</b>
Нэмж төлөгдсөн капитал		4,441,896	<b>4,441,896</b>
Дахин үнэлгээний нэмэгдэл		20,490	<b>(71,097)</b>
Хуримтлагдсан ашиг		4,869,149	<b>10,115,434</b>
Нийт эздийн өмчийн дүн		15,574,551	<b>20,729,249</b>
<b>Нийт өмч ба өр төлбөр</b>		33,784,289	<b>40,746,010</b>

Энэхүү санхүү байдлын тайланг 87-аас 106 дугаар хуудсан дах тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

# ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

мянган төгрөгөөр	Тодруулга	2018	2019
Даатгалын хураамжийн нийт орлого	18	27,786,499	<b>28,927,212</b>
Даатгалын хураамжийн буцаалт	18	(1,529,982)	<b>(2,210,956)</b>
Давхар даатгалын хураамжийн зардал	18	(9,807,090)	<b>(10,842,392)</b>
Даатгалын хураамжийн цэвэр орлого		16,449,427	<b>15,873,864</b>
Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	18	(3,749,075)	<b>281,307</b>
Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт	18	(768,662)	<b>267,079</b>
Орлогод тооцсон хураамж		11,931,690	<b>16,422,250</b>
Нийт нөхөн төлбөрийн зардал	18	(4,324,094)	<b>(5,422,537)</b>
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	18	790,080	<b>674,283</b>
Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр	18	247,954	<b>384,427</b>
Нөхөн төлбөрийн цэвэр зардал		(3,286,060)	<b>(4,363,827)</b>
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	18	(424,881)	<b>(1,683,438)</b>
Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт	18	(166,407)	<b>(415,132)</b>
Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт	18	(47,858)	<b>472,722</b>
Зардалд тооцсон нөхөн төлбөр		(3,925,206)	<b>(5,989,675)</b>
Даатгалын гэрээний зардал	19	(1,315,776)	<b>(1,177,917)</b>
Давхар даатгалын шимтгэлийн орлого	20	438,772	<b>82,585</b>
Хөрөнгө оруулалтын орлого	21	2,248,376	<b>3,734,284</b>
Даатгалын үйл ажиллагааны ашиг		9,377,856	<b>13,071,527</b>
Хүү, эрхийн шимтгэлийн орлого		28,082	<b>26,127</b>
Бусад орлого		74,650	<b>51,451</b>

# ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

(үргэлжлэл)

мянган төгрөгөөр	Тодруулга	2018	2019
Ерөнхий ба удирдлагын зардал	22	(3,986,955)	<b>(5,611,432)</b>
Борлуулалт, маркетингийн зардал	23	(608,100)	<b>(1,014,256)</b>
Бусад зардал	24	(555,127)	<b>(3,104)</b>
Гадаад валютын ханшийн зөрүүний олз		81,781	<b>14,956</b>
Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны гарз		(38,566)	<b>366</b>
Бусад алдагдал		(5,004,235)	<b>(6,535,892)</b>
Татвар төлөхийн өмнөх ашиг (19+27)		4,373,621	<b>6,535,635</b>
Орлогын татварын зардал	25	(505,364)	<b>(665,047)</b>
Татварын дараах ашиг		3,868,257	<b>5,870,588</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>			
Үнэт цаасны дахин үнэлгээний нэмэгдэл		20,490	<b>(91,587)</b>
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого</b>		3,888,747	<b>5,779,001</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг</b>		0.623	<b>0.009*</b>

\* 2019 оны 4-р сарын 29-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 6,243,016 ширхэг энгийн хувьцааг 100 хувааж 624,301,600 ширхэг хувьцаа болгох шийдвэр гарсантай холбоотойгоор тайлант оны нэгж хувьцаанд ногдох суурь ашгийн үзүүлэлт юм.

Энэхүү орлогын дэлгэрэнгүй тайланг 87-аас 106 дугаар хуудсан дах тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

# ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

мянган төгрөгөөр	Хувьцаат капитал	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Үнэт цаасны дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг / (алдагдал)	Нийт
2018.01.01-ний байдлаар	6,243,016	(1,243,016)	-	-	1,000,892	<b>6,000,892</b>
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	3,868,257	<b>3,868,257</b>
Өмчид гарсан өөрчлөлт	-	1,243,016	4,441,896	-	-	<b>5,684,912</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	20,490	-	<b>20,490</b>
<b>2018.12.31-ний байдлаар</b>	6,243,016	-	4,441,896	20,490	4,869,149	<b>15,574,551</b>
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	5,870,588	<b>5,870,588</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	(91,587)	-	<b>(91,587)</b>
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	(624,302)	<b>(624,302)</b>
<b>2019.12.31-ний байдлаар</b>	6,243,016	-	4,441,896	(71,097)	10,115,434	<b>20,729,249</b>

Энэхүү өмчийн өөрчлөлтийн тайланг 87-аас 106 дугаар хуудсан дах тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

# МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

мянган төгрөгөөр

	2018	2019
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Даатгалын хураамжийн орлого	21,581,831	<b>24,985,154</b>
Давхар даатгалын нөхөн төлбөр	243,513	<b>731,903</b>
Бусад мөнгөн орлого	2,663,208	<b>1,088,609</b>
Ажиллагчдад төлсөн	(2,094,710)	<b>(2,494,071)</b>
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(465,100)	<b>(621,390)</b>
Бараа материал худалдан авахад төлсөн	(4,153)	-
Ашиглалтын зардалд төлсөн	-	<b>(12,701)</b>
Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж	(10,060,111)	<b>(10,039,789)</b>
Нөхөн төлбөрт төлсөн	(4,245,308)	<b>(5,335,014)</b>
Үүнээс: Сайн дурын даатгалын	(3,501,883)	<b>(5,069,365)</b>
Албан журмын даатгалын	(743,425)	<b>(265,649)</b>
Даатгалын төлөөлөгчийн шимтгэл	(96,165)	<b>(75,725)</b>
Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр	(496,281)	<b>(714,760)</b>
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(69,167)	<b>(39,782)</b>
Татварын байгууллагад төлсөн	(865,300)	<b>(989,476)</b>
Даатгалын төлбөрт төлсөн	(1,957)	<b>(2,834)</b>
Бусад мөнгөн зарлага	(3,036,745)	<b>(3,747,725)</b>
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,053,555	<b>2,732,399</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	31,365	<b>587</b>
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	6,181,039	<b>34,522,997</b>
Хүлээн авсан хүүний орлого	2,012,377	<b>3,367,923</b>
Хүлээн авсан ногдол ашиг	-	<b>30,391</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(115,761)	<b>(189,342)</b>
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	<b>(48,541)</b>
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	(15,862,327)	<b>(42,033,190)</b>
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(7,753,307)	<b>(4,349,175)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	5,976,848	-
Төлсөн ногдол ашиг	-	<b>(561,390)</b>
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,976,848	<b>(561,390)</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	1,277,096	<b>(2,178,166)</b>
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	1,805,207	<b>3,082,303</b>
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	3,082,303	<b>904,137</b>

Энэхүү мөнгөн гүйлгээний тайланг 87-аас 106 дугаар хуудсан дах тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

## 1. Үйл ажиллагааны онцлог, ерөнхий мэдээлэл

Компани нь 2011 оны 4 дүгээр сарын 26-нд “Мандал Женерал” ХХК нэртэйгээр Монгол улсад үүсгэн байгуулагдсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 146 дугаар тогтоолоор “Ердийн даатгалын үйл ажиллагаа” эрхлэх тусгай зөвшөөрлийг авсны дараа албан ёсны нэрээ “Мандал Женерал Даатгал” ХХК болгон өөрчилж, ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх болсон байна. 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр “Мандал даатгал” гэж нэрээ өөрчилсөн.

Компани нь 2018 онд нийт хувьцааныхаа 25 хувийг олон нийтэд санал болгон үнэт цаасны анхдагч зах зээл дээр арилжаалж, 2018 оны 9 дүгээр сарын 21-нд хувьцаат компанийн хэлбэрт шилжин Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн. Тодруулга 31.1-с хувьцаа эзэмшил, хяналтын харилцааны талаарх мэдээллийн дэлгэрэнгүйг харна уу.

Үйл ажиллагааны чиглэл: Ердийн даатгалын үйл ажиллагааны хүрээнд Гэнэтийн осол, эмчилгээний, Хөрөнгийн, Авто тээврийн хэрэгслийн, Барилга угсралтын, Ачааны, Агаарын хөлгийн, Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын, Жолоочийн хариуцлагын албан журмын, Газар тариалангийн, Мал амьтдын, Хариуцлагын, Санхүүгийн, Зээлийн, Итгэлцлийн, Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн, Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын, Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын зэрэг даатгалын төрөл байна.

Компанийн хүний нөөц: Компанийн ажилтнуудын дундаж тоо 2019 оны туршид 123 (2018 онд: 105) байсан.

Бүртгэгдсэн хаяг: Компани нь Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, “Паркплейс Оффис” барилгын 1, 3, 5 дугаар давхруудад байрлан үйл ажиллагаагаа явуулж байна.

Компани одоогоор 14 хэлбэрийн даатгалын үйл ажиллагаа эрхлэн, 3 салбартайгаар ажиллаж байна.

## 2. Санхүүгийн тайлан бэлтгэх суурь

### 2.1 Үндсэн зарчим

Эдгээр санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)–өөс баталсан Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт (“СТОУС”)–д нийцүүлэн 2015 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 306/307 тоот тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга, санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэв.

## 2.2 Хэмжилтийн суурь

Эдгээр санхүүгийн тайланг бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн тодорхой санхүүгийн хэрэглүүрээс бусдаар түүхэн өртгийн сууриар бэлтгэсэн.

## 2.3 Үйл ажиллагааны ба толилуулгын валют

Монгол улсын мөнгөн тэмдэгт Төгрөг нь Компанийн үндсэн үйл ажиллагаа болон ажил гүйлгээний эдийн засгийн бодит байдлыг хамгийн тохиромжтой илэрхийлж байгаа учраас төгрөг нь уг Компанийн үйл ажиллагааны валют юм.

Санхүүгийн тайлангуудын хэрэглэгчдэд хамгийн тохиромжтой гэж удирдлага үзэж байгаа учраас эдгээр санхүүгийн тайлангуудыг (өөрөөр заагаагүй бол) Монгол төгрөгөөр толилуулна. Монгол төгрөгөөр илэрхийлсэн санхүүгийн бүх мэдээлэл мянган төгрөгөөр бүхэлтгэн илэрхийлэгдсэн.

## 2.4 Тооцоолол ба үнэлэмжийн хэрэглээ

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь удирдлагаас санхүүгийн тайлангийн өдрөөр тайлагнасан хөрөнгө, өр төлбөрийн дүн болон тайлант хугацааны орлого, зарлагын тайлагнасан дүнд нөлөөлөх чухал таамаглал тооцоолол хийхийг шаарддаг.

Эдгээр тооцоолол нь тухайн үйл явдал, үйл ажиллагааны талаарх удирдлагын хамгийн сайн мэдлэг дээр суурилсан байдаг боловч, бодит үр дүн нь эцсийн дүндээ эдгээр тооцооллоос өөр байж болох бөгөөд анхны тооцоолол, түүний таамаглалыг тухайн нөхцөл байдал, тухайн жилд нь тохируулан өөрчлөж болно.

### Даатгалын нөөц сангийн тооцоолол

88 Компанийн актуарч нь Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмын дагуу даатгалын хураамжийн нөөц болон даатгалын нэхэмжлэлийн нөөц сангуудыг тооцоолдог.

Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийг (ОТХН) даатгагчийн даатгалын хариуцлага дуусаагүй байгаа даатгалын гэрээ бүрийн хувьд “хувь тэнцүүлсэн арга”-аар буюу тайлагналын өдрөөр даатгалын гэрээний хүчинтэй үлдэх хугацаанд хувь тэнцүүлэн тооцсон даатгалын хураамжийн хэсгүүдийн нийлбэрээр тодорхойлдог.

Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц санг (УБМХНС) даатгагч даатгалын хэлбэр тус бүрээр үнэн зөв бөгөөд бодитой статистикт тулгуурлан актуар аргачлалаар тооцоолсон даатгагчийн хамгийн сайн төсөөлөлд үндэслэн тооцно. Тухайн нөөцийг тайлант хугацааны эцсийн байдлаар учирсан боловч мэдэгдээгүй байгаа хохиролд зориулан байгуулна.

Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц санд (МБТХНС) тайлангийн хугацаанд даатгуулагч эсхүл даатгалын гэрээнд заагдсан холбогдох бусад этгээдээс даатгагчид тухайн гэрээнд заасан аливаа хэлбэрээр /бичгээр, утсаар, и-мэйлээр болон бусад/ мэдэгдсэн даатгалын тохиолдлоос үүсэх даатгагчийн урьдчилан тооцоолсон хариуцлагын хэмжээ болон тайлангийн хугацаанд төлөгдөөгүй үлдсэн нэхэмжлэлийн хэмжээ хамаарна.

Учирч болзошгүй хохирлын нөөц санг (УБХНС) даатгагчийн хүчин төгөлдөр даатгалын гэрээнүүдийн хувьд өмнөх тайлант хугацааны эцэс дэх учирч болох хохирол болон үйл ажиллагааны зардлын нийлбэр нь орлогод тооцоогүй хураамжийн нөөцөөс давсан тохиолдолд тухайн нэмэгдэл хариуцлагын хэмжээгээр тооцно.

## 3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

### 3.1 Гадаад валют

#### Гадаад валютаарх ажил гүйлгээ

Санхүүгийн тайланг бэлтгэхэд үйл ажиллагааны валютаас бусад валютаарх ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдөр Монгол банкнаас зарласан ханшаар бүртгэнэ. Тайлант хугацаа бүрийн эцэст гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийг Монгол банкнаас тайлагналын өдрөөр зарласан ханшийг ашиглан дахин хөрвүүлэх бөгөөд 2019 оны 12 дугаар сарын 31-нд төгрөгийн 1 ам.доллартай харьцах ханш 2,733.52 төгрөг (2018 оны 12 дугаар сарын 31-нд: 1 ам.доллар 2,642.92 төгрөг) байв. Мөнгөн бус зүйлсийг дахин хөрвүүлэхгүй бөгөөд бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар дахин хөрвүүлсэн гадаад валютаар илэрхийлэгдсэн бодит үнэ цэнээр бүртгэсэн мөнгөн бус зүйлсээс бусад мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн валютын ханшийг ашиглан хөрвүүлсэн түүхэн өртгөөр хэмжинэ.

Мөнгөн зүйлсийг дахин хөрвүүлэх болон төлбөр тооцоо хийхэд үүссэн ханшийн зөрүүг тухайн хугацааны ашиг, алдагдалд багтаана. Мөнгөн бус зүйлсийн хөрвүүлгээс үүссэн ханшийн зөрүүний олз, гарзыг шууд өмчид хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийн дахин хөрвүүлгээс үүссэн ханшийн зөрүүг тайлант хугацааны ашиг, алдагдалд багтаана.

### 3.2 Даатгалын хөрөнгө

Даатгалын нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийг тайлагналын өдөр УБМХНС болон МБТХНС-ийн тайлант хугацаанд давхар даатгагчид ногдох хэсгийг актуарчийн тооцоолсон дүнгээр бүртгэдэг.

89 Давхар даатгалын хойшлогдсон хураамж нь давхар даатгалын хураамжийн давхар даатгалын гэрээний хугацаатай уялдуулан хувь тэнцүүлэх аргаар тооцоолж тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрөөгүй хэсэг юм.

Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн үлдэгдлийг давхар даатгалын хариуцлага эхэлсэн бөгөөд тайлагналын өдрөөр давхар даатгагчийн даатгалын хариуцлага дуусаагүй байгаа давхар даатгалын гэрээ тус бүрийн хувьд гэрээний үлдэх хугацаанд хувь тэнцүүлэх аргаар тооцдог. Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал нь даатгалын гэрээг олж бэлтгэхтэй холбогдон гарсан зардлын тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрөөгүй хэсэг байдаг.

Тухайлбал зуучлагч болон төлөөлөгчийн даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал, даатгалын хураамжийн дүнтэй хамааралтай гарсан даатгалын гэрээний хойшлогдсон бусад зардлаас бүрддэг.

### 3.3 Даатгалын бүтээгдэхүүн

Компани нь ердийн даатгалын бүх нийтлэг хэлбэрийг хамарсан даатгалын бүтээгдэхүүнүүд санал болгодог. Компанийн үндсэн бүтээгдэхүүний хэлбэрүүд нь:

- Гэнэтийн осол, эмчилгээний даатгал,
- Хөрөнгийн даатгал,
- Барилга угсралтын даатгал,
- Ачааны даатгал,
- Агаарын хөлгийн даатгал,
- Авто тээврийн хэрэгслийн даатгал,
- Жолоочийн хариуцлагын даатгал,
- Хариуцлагын даатгал,
- Санхүүгийн даатгал,
- Зээлийн даатгал,

- Мал амьтдын даатгал,
- Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал,
- Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал гэх мэт байна.

### 3.4 Даатгалын нөөц сан

Нөөц сан нь Орлогод тооцоогүй хураамжийн нөөц (ОТХН), Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан (УБМХНС), Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС), Учирч болзошгүй хохирлын нөөц сан (УБХНС)-уудаас бүрдэнэ.

ОТХН-д даатгалын гэрээний хугацаатай уялдуулан хувь тэнцүүлэх аргаар тооцоолж тайлант хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрөөгүй байгаа даатгалын хураамжийн хэсэг ордог.

УБМХНС-г тайлагналын өдөр болон түүнээс өмнөх хугацаанд даатгалын тохиолдол нь болсон боловч даатгагчид мэдэгдээгүй байгаа даатгалын нөхөн төлбөрийг барагдуулахад шаардагдах дүнгээр хэмждэг.

УБХНС-г тайлангийн хугацаанд даатгалын нөхөн төлбөрийн бодит түвшин нь тооцоолсон нөхөн төлбөрөөс давсан тохиолдолд тухайн хэсгийг нөхөн төлөхөд зориулсан нөөц сангаар хэмждэг.

### 3.5 Үндсэн хөрөнгө

Ажил үйлчилгээний зорилгоор ашиглаж буй машин, тоног төхөөрөмж, компьютер, дагалдах хэрэгсэл, тавилга эд хогшил зэрэг хөрөнгүүдийг санхүүгийн тайланд дараа үеийн хуримтлагдсан элэгдэл болон хорогдуулгыг хассан дүнгээр тайлагнана.

Үндсэн хөрөнгийн данснаас хассан, ашиглалтаас гаргаснаас үүссэн олз, гарзыг тухайн хөрөнгийн борлуулалт болон дансны үнийн зөрүүгээр тодорхойлох ба олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Тусад нь бүртгэсэн үндсэн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгийг солих зардлыг уг данснаас хассан бүрэлдэхүүн хэсгийн дансны үнээр капиталжуулна. Бусад дараа үеийн зардал ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөхөөр бол капиталжуулна. Засвар үйлчилгээ гэх мэт бусад бүх зардлыг үүссэн дүнгээр нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Элэгдлийг хөрөнгө тус бүрийн ашиглах хугацаагаар шулуун шугамын аргаар тооцож, ашиг алдагдлаар тусгана. Хөрөнгийг ашиглах боломжтой болсон үед элэгдүүлж эхлэнэ. Хөрөнгийн ашиглах хугацааг дараах байдлаар тогтооно.

Автомашин	- 10 жил
Тавилга, эд хогшил	- 10 жил
Компьютер, дагалдах хэрэгсэл	- 3 жил
Бусад	- 10 жил

### 3.6 Биет бус хөрөнгө

Компани худалдан авсан хязгаарлагдмал ашиглах хугацаатай биет бус хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан хорогдлыг хассан дүнгээр тайлагнана.

Хорогдлыг биет бус хөрөнгийн ашиглах хугацаагаар шулуун шугамын аргаар тооцож, ашиг алдагдлаар тусгах ба биет бус хөрөнгийн ашиглах хугацаа 3 жил байна.

### 3.7 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

Түрээсийн орлого олох болон капиталын үнийг өсгөх зорилгоор эзэмшиж буй хөрөнгө буюу хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг тээврийн зардлыг багтаасан өртгөөр анх хүлээн зөвшөөрнө. Анх хүлээн зөвшөөрсний дараа бодит үнэ цэнээр хэмждэг.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг тухайн үүссэн үеийн ашиг алдагдалд хамруулна.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөөс олсон түрээсийн орлого болон үйл ажиллагааны зардлыг орлого, бусад зардлаар тус тус бүртгэнэ.

### 3.8 Санхүүгийн хэрэглүүр

Хүлээн зөвшөөрөлт, анхдагч хэмжилт ба үл хүлээн зөвшөөрөлт

Компани тухайн санхүүгийн хэрэглүүрийн гэрээний заалтуудын нэг хэсэг болсон үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөний урсгал дах гэрээний эрх дуусгавар болоход эсвэл санхүүгийн хөрөнгө ба бүх бодит эрсдэл, шагнал шилжихэд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн өр төлбөрийг барагдуулсан, чөлөөлсөн, хүчингүй болгосон эсвэл хугацаа дууссан үед нь үл хүлээн зөвшөөрнө.

Бодит үнэ цэнээр анхлан хэмжсэн бөгөөд ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр илэрхийлснээс бусад санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг анх бодит үнэ цэнэ дээр ажил гүйлгээний өртгийг нэмсэн дүнгээр хэмжинэ.

Санхүүгийн хөрөнгийн ангилал ба дараа үеийн хэмжилт

Дараа үеийн хэмжилтийн зорилгоор хейджийн хэрэглүүрээс бусад санхүүгийн хөрөнгө анхдагч хүлээн зөвшөөрөлтөөр дараах категорит хуваагдана.

- Зээл ба авлага
- Ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө
- Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө
- Гэрээний хугацаа дуустал эзэмших санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хөрөнгүүд хэрэглүүрийн шинж чанар, зорилгоос шалтгаалан анхдагч хүлээн зөвшөөрөлтөөр өөр өөр категорит ордог. Санхүүгийн хэрэглүүрийн категори нь түүний хэмжилт, санхүүгийн хэрэглүүрийн үр дүнд бий болсон орлого, зарлагыг ашиг, алдагдлаар эсвэл шууд бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөх эсэхэд чухал хамааралтай.

#### I. Зээл ба авлага

Зээл болон авлага нь идэвхтэй зах зээл дээр арилжаалагддаггүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй дериватив бус санхүүгийн хөрөнгө юм. Зээл, авлагад дансны ба бусад авлага, гар дээрх бэлэн мөнгө болон банкин дах мөнгө багтана.

Дансны ба бусад авлага

Эргэлтийн дансны авлагыг бодит үнэ цэнээр анхлан хүлээн зөвшөөрнө. Харин дараа үед хорогдсон өртгөөс үнэ цэнийн бууралтын нөөцийг хассан дүнгээр хэмжинэ. Зээлдэгчид учирсан санхүүгийн томоохон бэрхшээл, гэрээ үл биелүүлэх болон төлөлт удаашрах зэрэг нь уг дансны авлагын үнэ цэнэ буурсныг илтгэнэ.

Цуглуулах боломжгүй гэж үзсэн бүх дансны авлагыг данснаас хасна.

**Аудитлагдсан санхүүгийн тайлан**

**Даатгалын авлага**

Даатгалын авлага нь даатгалын бүтээгдэхүүн борлуулсан, үйлчилгээ үзүүлснээс үүссэн бусдаас авахаар хүлээн зөвшөөрөгдсөн нэхэмжлэх дүн байна.

Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 306/307 тоот тушаалаар батлагдсан даатгалын компанид мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн зааврын 3.2 Даатгалын авлага хэсэгт “Үнэ цэнийн бууралтыг тооцох СТОУС-д нийцэх аргачлалыг компани дотооддоо боловсруулж, мөрдөж болно” гэж заасны дагуу авлагын шууд аргыг ашигладаг. Өөрөөр хэлбэл авлага төлөгдөх найдваргүй гэдэг нь тогтоогдсон үед авлагыг данснаас хасдаг.

**Бэлэн мөнгө ба банкин дах үлдэгдэл**

Компанийн бэлэн мөнгө ба банкин дах үлдэгдэл нь гар дээрх бэлэн мөнгө, банкин дах дансад болон замд яваа бэлэн мөнгөөс бүрдэнэ.

**II. Ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр бүртгэсэн санхүүгийн хөрөнгө**

Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгийг худалдах зорилгоор эзэмшиж буй эсвэл анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараа бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг ашиг алдагдлаар тусгадаг гэж ангилна. Уг тодорхойлолтын дагуу хөйджийн бүртгэлийн шаардлагыг хангахгүй бүх дериватив санхүүгийн хэрэглүүр энэ категорит багтана.

Дериватив санхүүгийн хэрэглүүрээс үүсч буй аливаа олз, гарз нь бодит үнэ цэнийн өөрчлөлтөд суурилдаг. Уг бодит үнэ цэнийн өөрчлөлтийг идэвхитэй зах зээлийн ажил гүйлгээг, идэвхитэй зах зээл байхгүй бол үнэлгээний аргачлалд ашиглан тодорхойлно.

**III. Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө**

Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжих ба дараа үе дэх өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрнө. Борлуулах боломжтой гэж ангилсан санхүүгийн хөрөнгөөс үүссэн олз, гарзыг зөвхөн борлуулагдсан эсвэл тухайн хөрөнгө оруулалтын үнэ цэнэ буурсан үед ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнэ буурсан тохиолдолд өмнө нь бусад орлогод хүлээн зөвшөөрсөн аливаа алдагдлыг ашиг алдагдалд шилжүүлнэ.

Орлогын тайлангийн өмчийн хэрэглүүрт хүлээн зөвшөөрсөн алдагдлыг орлогын тайлангаар дамжуулж буцаахгүй харин өмчийг тохируулна. Дараах үеийн өсөлт нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын дараа үүсэх үйл явдалд бодитоор холбогдох боломжтой бол өрийн үнэт цаасны үнэ цэнийн бууралтын дүнд бий болсон өмнөх тайлант хугацааны орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн гарзыг орлогын тайлангаар дамжуулж буцаана.

**IV. Гэрээний хугацаа дуустал эзэмших санхүүгийн хөрөнгө**

Гэрээний хугацаа дуустал эзэмших санхүүгийн хөрөнгө нь тогтоосон эсвэл тодорхойлж болох төлбөртэй, тогтоосон дуусах хугацаатай дериватив бус санхүүгийн хөрөнгө бөгөөд арилжааны банкууд дах хадгаламж үүнд орно.

Санхүүгийн өр төлбөрийн ангилал ба дараа үеийн хэмжилт

Компанийн санхүүгийн өр төлбөрт зээл ба зээллэг, санхүүгийн түрээсийн өр төлбөрийг багтаасан Дансны ба бусад өглөг орно.

Санхүүгийн өр төлбөрийн ангилал ба дараа үеийн хэмжилт

Компанийн санхүүгийн өр төлбөрт зээл ба зээллэг, санхүүгийн түрээсийн өр төлбөрийг багтаасан Дансны ба бусад өглөг орно.

**I. Зээл ба зээллэг**

Зээл ба зээллэгийг зээллэгтэй холбоотой гаргалтын зардлын цэвэр дүн буюу бодит үнэ цэнээр анхлан хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнэ, нэрлэсэн үнэ хоорондын зөрүүг тухайн зээллэгийг эзэмшигчээс авснаас бусад тохиолдолд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Тийм тохиолдолд бодит үнэ цэнэ, нэрлэсэн үнэ хоорондын зөрүүг өмчид нэмэлт капиталаар хүлээн зөвшөөрнө. Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараагаар зээл ба зээллэг нь өртөг болон үр ашигт хүүгийн сууриарх зээллэгийн хугацааны турш ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн төлөх үеийн үнийн зөрүүний хамт хорогдлын өртгөөр илэрхийлэгдэнэ. Хөрөнгийн нэг хэсэг болгон капиталжуулсан бэлтгэл шаардлагатай хөрөнгийн худалдан авалт, барилга эсвэл үйлдвэрлэлд шууд холбоотой зээлийн өртгөөс бусад зээллэгтэй холбоотой үүссэн хүү болон бусад зардлыг санхүүгийн зардлын хэсгээр хүлээн зөвшөөрнө.

**II. Дансны ба бусад өглөг**

Дансны ба бусад өглөгийг бодит үнэ цэнээр, дараа үед хорогдуулсан өртгөөр илэрхийлнэ.

**3.9 Өмч**

Компанийн гаргасан өмчийн хэрэглүүрийг хүлээж авсан орлогоор бүртгэнэ. Хувьцаат капитал нь гаргасан хувьцааны нэрлэсэн үнийг илэрхийлнэ.

Нэмж төлөгдсөн капиталд хувьцаат капитал гаргаснаас хүлээж авсан аливаа урамшуулал орно.

Хуримтлагдсан ашигт тайлант болон өмнөх хугацааны бүх ашиг багтана. Ногдол ашгийг зарласан хугацаанд нь өр төлбөрөөр хүлээн зөвшөөрнө.

**3.10 Орлогын албан татвар**

Тайлант үеийн татвар гэдэг нь тайлант оны эцсээр хүчинтэй болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын хувь хэмжээг ашиглан тухайн оны татвар ногдох орлогод төлөх татварын өглөг болон өмнөх онуудтай холбоотой татварын өглөгийн залруулга юм.

**3.11 Орлогын хүлээн зөвшөөрөлт**

Орлого нь тайлант хугацаанд хөрөнгийн дотогшлох урсгал болон хөрөнгийн сайжруулалт, эсвэл хувь нийлүүлэгчдээс оруулсан хөрөнгөтэй холбоогүйгээр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, өр төлбөрийг бууруулах хэлбэрээр гарах эдийн засгийн үр өгөөжийн өсөлт юм.

Даатгалын орлогод даатгалын хураамжийн орлого, давхар даатгалын шимтгэлийн орлого, давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр, буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр, хөрөнгө оруулалтын орлого зэрэг хамаарна.

Даатгалын бус орлого, олзод түрээсийн орлого, үйл ажиллагааны бусад орлого, үйл ажиллагааны бус бусад олз, гарз багтана.

- Орлогыг дараах нөхцөл бүрдсэнээр хүлээн зөвшөөрнө.
- Орлогын дүнг бодитой тооцон гаргах боломжтой,
- Ажил гүйлгээний эцсийн өгөөжийг хүртэх магадлалтай байх

Орлогыг хүлээн авсан мөнгө эсвэл үүссэн авлагын бодит үнэ цэнээр үнэлнэ.

Даатгалын орлогод даатгалын хураамжийн орлого, давхар даатгалын шимтгэлийн орлого, давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр, буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр, хөрөнгө оруулалтын орлого зэрэг багтдаг.

Даатгалын гэрээний үндсэн дээр даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид

төлөх төлбөрийг Даатгалын хураамжийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Давхар даатгагчтай давхар даатгалын гэрээ байгуулсны төлөө давхар даатгагчаас төлөх шимтгэлийг Давхар даатгалын шимтгэлийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Давхар даатгалын гэрээний дагуу давхар даатгагчаас авсан буюу авахаар тохиролцсон даатгалын нөхөн төлбөрийг Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Даатгалын зүйлд даатгалын эрсдэл тохиолдож даатгагчаас нөхөн төлбөрийг даатгуулагчид төлсөн бөгөөд тухайн нөхөн төлбөрийн зарим хэсгийг эсвэл бүхэлд нь буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн хэмжээг Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөрөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Нөөц сангийн хөрөнгө, дүрмийн сангийн хөрөнгө болон тайлант үед хийх төлбөрийн хэмжээнээс давсан сул чөлөөтэй хөрөнгийг арвижуулах зорилгоор байршуулснаар олсон орлого, олзыг Хөрөнгө оруулалтын орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

### 3.12 Даатгалын зардал

Давхар даатгалын хураамж нь давхар даатгалын гэрээний үндсэн дээр даатгагч өөрийн даатгалын эрсдэлийг давхар даатгагчид шилжүүлсний төлөө төлөх төлбөр байна.

Даатгалын хураамжийн буцаалт нь даатгалын гэрээ цуцлагдахад гэрээний үлдэх хугацаанд ногдох хураамжаас гэрээнд заасны дагуу даатгуулагчид өгөх даатгалын хураамж байна.

Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт нь ОТХНөөцийг байгуулах болон зарцуулах зориулалт бүхий орлого, зардлын данс юм. ОТХНөөцийг нэмж байгуулах үед зардал, бууруулж байгуулах үед орлого утгатай байна.

94

Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт нь Давхар даатгалын хойшлогдсон хураамжийг байгуулах болон зарцуулах зориулалт бүхий орлого, зардлын данс юм. Давхар даатгалын хойшлогдсон хураамжийг нэмж байгуулах үед орлого, бууруулж байгуулах үед зардал утгатай байна.

Нөхөн төлбөрийн зардал гэж даатгалын зүйлд даатгалын гэрээнд заасан эрсдэл тохиолдож даатгагчаас хохирлыг барагдуулахаар олгож буй төлбөр байна.

Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт нь УБМХНС болон МБТХНСанг байгуулах болон зарцуулах зориулалт бүхий орлого, зардлын данс юм. УБМХНС болон МБТХНСанг нэмж байгуулах үед орлого, бууруулж байгуулах үед зардал утгатай байна.

Нөхөн төлбөрийн нөөцийн Давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт нь УБМХНС болон МБТХНСангийн давхар даатгагчид ногдох хэсгийг байгуулах болон зарцуулах зориулалт бүхий орлого, зардлын данс юм. Даатгалын нөөцийн Давхар даатгагчид ногдох УБМХНС болон МБТХНСанг нэмж байгуулах үед орлого, бууруулж байгуулах үед зардал утгатай байна.

Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт нь УБХНСанг байгуулахад зориулсан зардлын данс байна.

Даатгалын гэрээний зардал гэж даатгалын хураамжийн дүнтэй хамааралтай гарсан зардал байна.

### 3.13 Нэгж хувьцаанд ноогдох ашиг

Компани энгийн хувьцааны хувьд нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог. Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах цэвэр ашиг, алдагдлыг тайлант хугацааны туршид эргэлтэнд байсан энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоонд хуваах замаар нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог.

## 4. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

мянган төгрөгөөр	2018	2019
Бэлэн мөнгө	4,505	<b>3,519</b>
Банкан дахь харилцах данс	1,855,965	<b>900,618</b>
Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	1,221,833	-
Нийт	3,082,303	<b>904,137</b>

## 5. Даатгалын авлага

мянган төгрөгөөр	2018	2019
Даатгалын хураамжийн авлага	4,207,657	<b>5,308,773</b>
Буруутай этгээдээс авах авлага	215,791	<b>494,020</b>
Давхар даатгалаас авах авлага	393,531	<b>450,625</b>
Нийт	4,816,979	<b>6,253,418</b>

Эдгээр авлагын насжилтын шинжилгээг дор харуулав:

мянган төгрөгөөр	2018	2019
Хэвийн /30 хүртэл хоног/	4,734,520	<b>5,290,551</b>
Хугацаа хэтэрсэн /31-60 хоног/	43,420	<b>109,348</b>
Хэвийн бус /61-90 хоног/	7,090	<b>184,484</b>
Эргэлзээтэй /91-120 хоног/	4,825	<b>127,577</b>
Муу /121-ээс дээш хоног/	27,124	<b>541,458</b>
Нийт	4,816,979	<b>6,253,418</b>

95

“Мандал даатгал” ХК нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо эргэлзээтэй авлагыг найдваргүй нь тодорхой болсон үед авлагын данснаас шууд хасах бодлого баримталдаг ба тайлант хугацаанд 575 мянган төгрөгийн авлагыг данснаас хассан байна.

## 6. Бусад санхүүгийн хөрөнгө

мянган төгрөгөөр	2018	2019
Бусад байгууллагаас авах авлага	294,720	<b>618,472</b>
Холбоотой талаас авах авлага	9,245	-
Нийт	303,965	<b>618,472</b>



## 7. Бусад санхүүгийн бус хөрөнгө

мянган төгрөгөөр	2018	2019
Нийгмийн даатгалын шимтгэл болон бусад татварын авлага	46,171	2,367
ААНОАТ-ын авлага	-	51,964
Бараа материал	23,543	23,018
Урьдчилж төлсөн зардал	1,163,443	790,345
Нийт	1,233,157	867,694

\* Урьдчилж төлсөн зардал дансанд офиссын түрээсийн хугацаанд хувиарлагдах засварын зардал, харилцагчийн халамжтай холбоотой зардлууд багтаж байна.

## 8. Хөрөнгө оруулалт

мянган төгрөгөөр	2018	2019
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө оруулалт	15,859,210	17,462,825
Үнэт цаасаар оруулсан хөрөнгө оруулалт	3,978,081	10,175,539
Нийт	19,837,291	27,638,364

Үнэт цаасаарх хөрөнгө оруулалт нь компанийн бондууд болон хувьцаа байна.

## 9. Даатгалын хөрөнгө

мянган төгрөгөөр	2018	2019
Давхар даатгалын хойшлогдсон хураамж	2,857,095	3,124,174
Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг - УБМХНС*	225,454	21,724
Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг - МБТХНС**	322,767	111,365
Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал - Даатгалын зуучлагч	20,800	503,029
Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал - Даатгалын төлөөлөгч	462,724	96,922
Нийт	3,888,840	3,857,214

\*УБМХНС - Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөцийн сан

\*\*МБТХНС - Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөцийн сан

## 10. Үндсэн хөрөнгө

мянган төгрөгөөр	Машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, бусад хэрэгсэл	Бусад үндсэн хөрөнгө	Нийт дүн
<b>Өртөг</b>					
2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр	154,437	168,392	268,211	45,153	636,193
Нэмэгдсэн	78,585	65,272	66,702	11,674	222,233
Хасагдсан	(125,304)	(42,830)	(4,548)	(6,574)	(179,256)
2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр	107,718	190,834	330,365	50,253	679,170
Нэмэгдсэн	23,284	80,981	81,642	88,149	274,056
Хасагдсан	(70)	(523)	(1,609)	-	(2,202)
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	130,932	271,292	410,398	138,402	951,024
<b>Хуримтлагдсан элэгдэл</b>					
2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр	73,365	63,856	203,624	6,392	347,237
Байгуулсан элэгдэл	15,877	16,034	43,835	4,464	80,210
Данснаас хассан хөрөнгийн элэгдэл	(74,596)	(19,336)	(3,294)	(3,018)	(100,244)
2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр	14,646	60,554	244,165	7,838	327,203
Байгуулсан элэгдэл	11,200	20,617	49,844	6,948	88,609
Данснаас хассан хөрөнгийн элэгдэл	(45)	(326)	(1,609)	-	(1,980)
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	25,801	80,845	292,400	14,786	413,832
<b>Үлдэгдэл өртөг</b>					
Эхний үлдэгдэл	93,072	130,280	86,200	42,415	351,967
Эцсийн үлдэгдэл	105,131	190,447	117,998	123,616	537,192

Зээлийн барьцаанд тавьсан хөрөнгө байхгүй байна. 2019 онд 274,056 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

Элэгдлийн зардлыг Орлогын дэлгэрэнгүй тайлангийн Ерөнхий ба удирдлагын зардалд тусгадаг.

## 11. Биет бус хөрөнгө

мянган төгрөгөөр	Компьютерийн програм хангамж	Нийт
<b>Өртөг</b>		
2019 оны 1 дүгээр сарын 1-ээрх	192,250	<b>192,250</b>
Нэмэгдсэн	67,367	<b>67,367</b>
Хасагдсан	-	-
2019.12.31	259,617	<b>259,617</b>
<b>Хуримтлагдсан хорогдуулга</b>		
2019 оны 1 дүгээр сарын 1-ээрх	159,103	<b>159,103</b>
Байгуулсан хорогдуулга	30,995	<b>30,995</b>
Данснаас хасагдсан	-	-
2019.12.31	190,098	<b>190,098</b>
<b>Үлдэгдэл өртөг</b>		
Эхний үлдэгдэл	33,147	<b>33,147</b>
Эцсийн үлдэгдэл	69,519	<b>69,519</b>

Хорогдуулгын зардлыг Ерөнхий ба удирдлагын зардалд тусгадаг.

## 12. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

мянган төгрөгөөр	2018	2019
<b>Бодит үнэ цэнэ</b>		
Эхний үлдэгдэл	236,640	-
Эцсийн үлдэгдэл	236,640	-

Хөрөнгө оруулалтын зориулалтаар худалдаж авсан Хан-уул дүүрэгт байршилтай орон сууцыг тайлант онд борлуулсан байна.

## 13. Даатгалын өглөг

мянган төгрөгөөр	2018	2019
Даатгалын хураамжийн буцаалтын өглөг	6,104	<b>30,798</b>
Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг	106,194	<b>36,118</b>
Давхар даатгагчид өгөх өглөг	953,076	<b>1,783,601</b>
Нийт	1,065,374	<b>1,850,517</b>

## 14. Бусад санхүүгийн бус өр төлбөр

мянган төгрөгөөр	2018	2019
Цалингийн өглөг	215,388	<b>115,703</b>
Бусад өглөг	178,861	<b>469,462</b>
НДШ-ийн өглөг	8,514	<b>17</b>
Урьдчилж орсон орлого	242,851	<b>152,903</b>
Нийт	645,614	<b>738,085</b>

## 15. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц

мянган төгрөгөөр	2018	2019
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	5,930,927	<b>5,555,818</b>
Хөрөнгийн даатгал	1,591,912	<b>1,593,673</b>
Авто тээврийн хэрэгслийн даатгал	2,455,450	<b>3,289,162</b>
Ачааны даатгал	4,580	<b>7,156</b>
Барилга угсралтын даатгал	254,436	<b>17,846</b>
Мал амьтдын даатгал	-	<b>1,025</b>
Агаарын хөлгийн даатгал	261,402	<b>366,794</b>
Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	82,173	<b>28,125</b>
Хариуцлагын даатгал	1,866,107	<b>1,218,809</b>
Санхүүгийн даатгал	178,601	<b>189,704</b>
Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	3,659	<b>3,583</b>
Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	265,510	<b>327,762</b>
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	220,596	<b>234,589</b>
Нийт	13,115,353	<b>12,834,046</b>

Актуарчийн нөөц сангийн тооцооллын тайланд Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

Орлогод тооцоогүй хураамжийн нөөц санг 2019 оны 12 дугаар 31-ний өдрийн байдлаар бүх хүчинтэй даатгалын гэрээний хураамжийн орлого, эхлэх дуусах огноо, буцаалтын мэдээг ашиглан хувь тэнцүүлэх замаар тооцоолсон. Хүчинтэй даатгалын гэрээнд үндэслэн тооцоолол хийхэд нийт 12,834,046 мянган төгрөгийн нөөц сан байгуулсан байна.

## 16. Нөхөн төлбөрийн нөөц сан

мянган төгрөгөөр	2018	2019
Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан	740,952	<b>2,325,582</b>
Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан	720,484	<b>819,291</b>
Учирч болзошгүй хохирлын нөөц сан	665,671	<b>192,950</b>
Тусгай нөөц сан	1,256,290	<b>1,256,290</b>
Нийт	3,383,397	<b>4,594,113</b>

Актурчийн нөөц сангийн тооцооллын тайланд Нөхөн төлбөрийн нөөц санг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц санг 44,211 мөр Raw data-аас нөхөн төлбөрийн сүүлийн 20 улирлын өгөгдлийг ашиглан даатгалын тохиолдол болсон огноо болон материал бүрдүүлсэн огноогоор боловсруулалт хийж Chain-Ledder арга ашиглан даатгалын хэлбэр тус бүрийн хувьд тооцооллоо. Даатгагчийн байгуулсан нөөцийн хэмжээ аудитын байгууллагын актурчийн байгуулахаар тооцсон нөөцийн хэмжээнээс зарим хэлбэрийн хувьд дутуу, зарим хэлбэрийн хувьд илүү тооцоологдсон боловч нийт дүнгээр нөөцийн санг хангалттай байгуулсан байх тул хангалттай хүрэлцээтэй гэж үзлээ.

Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц санг тооцохдоо тайлангийн хугацаанд төлөгдөөгүй үлдсэн нэхэмжлэлийн хариуцлагын дүнгээр байгууллаа. Өгөгдлийг тус компанийн Heaven Pro программын холбогдох тайлан болон даатгалын менежерүүдийн бүртгэлийн мэдээллийг ашиглан тооцоолсон болно. Нийт 819,291 мянган төгрөгийн нөөц байгуулагдсан байна.

Учирч болзошгүй хохирлын нөөц санг даатгагчийн хүчин төгөлдөр даатгалын гэрээнүүдийн хувьд өмнөх тайлант хугацааны эцэс дэх учирч болох хохирол болон үйл ажиллагааны зардлын нийлбэр нь орлогод тооцоогүй хураамжийн нөөцөөс давсан тохиолдолд тухайн нэмэгдэл хариуцлагын хэмжээгээр тооцооллоо. Үйл ажиллагааны зардлыг тус журмын 2.5.2-т заасны дагуу ОТХ-д харьцуулсан хувийн жинг ашиглан задалж хэлбэр тус бүрийн хувьд тооцоолсон. Нийт 192,950 мянган төгрөгийн нөөц байгуулагдсан байна.

## 17. Эздийн өмч

### 17.1 Хувьцаат капитал

мянган төгрөгөөр	2018	2019
Хувьцааны дүн /мянган төгрөгөөр/	6,243,016	<b>6,243,016</b>
Нэмж төлөгдсөн капитал	4,441,896	<b>4,441,896</b>
Дахин үнэлгээний нэмэгдэл	20,490	<b>(71,096)</b>
Хуримтлагдсан ашиг	4,869,149	<b>10,115,434</b>
Нийт өөрийн хөрөнгийн дүн	15,574,551	<b>20,729,249</b>

Компани нь тогтмол орлогын эрхгүй энгийн хувьцааны нэг л ангилалтай.

## 18. Даатгалын үйл ажиллагааны орлого, зардал

Гэгдлийн осол, Эмчлэгээний зардал	2019											
	Даатгалын хуралжийн цааз орлого	Даатгалын хуралжийн цааз орлого	Орлогод тооцогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	Хойшуулсан дахтар даатгалын хураамжийн өөрчлөлт	Орлогод тооцсон хураамж	Нийт нөхөн төлбөрийн зардал	Нөхөн төлбөрийн цааз зардал	Нөхөн төлбөрийн нөөцийн сангийн өөрчлөлт	Нөхөн төлбөрийн нөөцийн дахтар даатгалчид ногдох хэсгийн өөрчлөлт	Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт	Зардал тооцсон нөхөн төлбөр	Даатгалын гэрээний зардал
Эмчлэгээний зардал	8,165,410	424,643	87,671	7,653,096	(375,109)	(199,631)	7,828,574	2,275,176	2,069,863	76,709	60,390	315,066
Хөрөнгийн даатгал	3,711,482	21,218	1,317,936	2,372,328	1,761	60,787	2,431,354	273,376	180,021	247,892	7,175	403,265
Автозөврийн хэрэгслийн даатгал	6,095,129	516,707	1,192,101	4,386,321	833,712	796,510	4,349,119	1,929,851	1,632,900	64,498	7,917	404,815
Ачааны даатгал	347,929	266,927	7,691	73,311	2,575	(319)	70,417	9,505	9,505	35,030	2,804	3,735
Барилга усралтын даатгал	6,377,268	15,452	6,287,764	74,052	(236,590)	(240,082)	70,560	99,628	1,991	1,585,168	124,160	268
Мал амьтдын даатгал	22,000	-	-	22,000	1,025	-	20,975	-	-	1,107	-	-
Агаарын холигын даатгал	1,085,192	188,387	806,950	89,855	105,392	87,464	71,927	-	-	(1,296)	-	-
Автозөврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	48,303	37,352	-	10,951	(54,047)	-	64,988	-	-	(1,888)	-	-
Хариуцлагын даатгал	1,234,057	463,460	177,628	592,969	(647,298)	(321,889)	918,378	580,784	195,240	(305,678)	204,389	26,838
Санхүүгийн даатгал	284,555	-	167,918	116,637	11,103	18,254	123,788	-	-	7,110	-	-
Зээлийн даатгал	3,764	-	-	3,764	-	-	3,764	-	-	(14,444)	6,291	(8,153)
Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	60,302	-	12,575	37,727	(76)	(19)	37,784	-	-	(1,636)	-	-
Агаарын холигийг амьдрах, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	1,011,722	221,687	784,180	5,855	62,252	66,004	9,607	-	-	(1,309)	-	-
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	490,099	551,123	(22)	434,988	13,993	-	421,005	274,617	274,317	2,175	2,026	23,920
<b>2019 оны нийт дүн</b>	<b>28,927,212</b>	<b>2,210,956</b>	<b>10,842,392</b>	<b>15,873,864</b>	<b>(281,307)</b>	<b>267,079</b>	<b>16,422,250</b>	<b>5,422,637</b>	<b>4,383,827</b>	<b>1,683,438</b>	<b>415,132</b>	<b>5,989,675</b>
												<b>1,177,917</b>

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 6/1739 тоот, 2020 оны 6/608 тоот албан бичгээр ирүүлсэн "Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны 306/307 тоот хамтарсан тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн зааврын 6.2.В (Cut Through Clause) буюу давхар даатгагч даатгалын нөхөн төлбөрийг даатгуулагчид шууд олгохоор зааж Даатгалын компанийн нөхөн төлбөрийн үүргээс бүрэн чөлөөлж, түүний үүргийг давхар даатгагч өөртөө шилжүүлэн авсан бол даатгалын хураамжийн зардлыг зардлаар хүлээн зөвшөөрч, орлого үр дүнгийн тайланд тусгахгүй гэх заалтыг даатгагч даатгалын нөхөн төлбөр олгохтой холбоотой бүхий л үүргээс чөлөөлөгдсөн нөхцөлийг ойлгоно. Иймд даатгагч даатгуулагчид даатгалын нөхөн төлбөр олгохтой холбоотой тодорхой үүргийг давхар даатгалын гэрээгээр хүлээсэн нөхцөлд дээрх заалт хамаарахгүй болно" гэсний дагуу даатгалын гэрээний орлого болон давхар даатгалын зардлыг бүртгэсэн байна.

18. Даатгалын үйл ажиллагааны орлого, зардал (үргэлжлэл)

Мянган төгрөгөөр	2018											Даатгалын гэрээний зардал		
	Даатгалын хураамжийн нийт орлого	Даатгалын хураамжийн буцаалт	Давхар даатгалын хураамжийн зардал	Даатгалын хураамжийн цэвэр орлого	Орлогд тооцогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	Хойшуулсан давхар даатгалын хураамжийн өөрчлөлт	Орлогд тооцсон хураамж	Нийт нөхөн төлбөрийн зардал	Нөхөн төлбөрийн цэвэр зардал	Нөхөн төлбөрийн нөөцийн сангийн өөрчлөлт	Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгалчид ногдох хэсгийн өөрчлөлт		Учирч болзошгүй хохирлын нөөц саагийн өөрчлөлт	Зардал тооцсон нөхөн төлбөр
Гэнэтийн осол, Эмнэлгээний зардлын даатгал	8,593,829	289,173	490,485	7,814,170	3,438,623	(144,543)	4,231,005	1,387,903	1,017,639	205,127	(8,465)	-	1,214,300	327,176
Харонгийн даатгал	4,124,849	524,325	1,486,956	2,113,568	(215,883)	(273,727)	2,055,724	175,074	85,366	20,417	(43,789)	(986,520)	(334,535)	387,124
Автозаврийн хэрэгслийн даатгал	4,670,190	573,181	(52,159)	4,149,167	459,247	(169,285)	3,620,635	1,961,435	1,639,986	122,934	23,799	116,283	1,903,003	346,108
Ачааны даатгал	112,188	888	16,450	94,850	(24,264)	(2,731)	116,382	33,425	8,826	106,149	(23,075)	1,519	93,419	721
Барилга усралтын даатгал	5,842,060	613	5,834,530	6,917	(336,209)	(327,827)	15,500	-	-	143,206	(106,299)	471,079	507,985	5,681
Агаарын холгийн даатгал	610,158	-	564,568	45,591	261,402	242,039	26,227	-	-	1,296	-	-	1,296	-
Автозаврийн хэрэгслийн жолоочийн харьцалгын даатгал	121,515	665	-	120,850	46,014	(3,237)	71,599	-	-	1,165	418	(6,006)	(4,423)	112,543
Харилцааны даатгал	2,231,006	44,237	732,069	1,454,700	46,936	(239,459)	1,168,304	161,039	32,102	(178,489)	297,903	-	151,517	120,178
Санхүүгийн даатгал	269,269	-	140,729	127,539	3,665	(9,823)	114,031	100,704	83,738	46,457	277	-	130,472	26,827
Зэвэгийн даатгал	-	-	-	-	-	-	-	-	-	(17)	-	(36,259)	(36,276)	-
Итгэлцлийн даатгал	-	-	-	-	(410)	-	410	-	-	-	-	-	-	-
Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	51,371	-	12,843	38,528	3,659	915	35,784	-	-	1,636	-	-	1,636	-
Төмөр замын асуул усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, ашиглах, ахуйн ажиллагаатай холбоотой харууллагын даатгал	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	3,272
Агаарын холгийг өмчлөх, ашиглах, ахуйн ажиллагаатай холбоотой харууллагын даатгал	616,469	-	601,751	14,719	265,510	259,287	8,496	-	-	1,309	-	-	1,309	6,146
Жолоочийн харууллагын албан журмын даатгал	544,595	96,900	(21,132)	468,828	(199,235)	(100,471)	567,593	504,514	418,403	(46,314)	25,647	(102,238)	295,498	-
<b>2018 оны нийт дүн</b>	<b>27,786,499</b>	<b>1,529,982</b>	<b>9,807,090</b>	<b>16,449,427</b>	<b>3,749,075</b>	<b>(788,662)</b>	<b>11,831,690</b>	<b>4,324,094</b>	<b>3,286,060</b>	<b>424,881</b>	<b>166,407</b>	<b>47,858</b>	<b>3,925,206</b>	<b>1,315,776</b>

19. Даатгалын гэрээний зардал

мянган төгрөгөөр	2018	2019
Даатгалын зуучлагчийн шимтгэл	1,254,476	<b>1,104,091</b>
Даатгалын төлөөлөгчийн шимтгэл	61,300	<b>73,826</b>
Нийт	1,315,776	<b>1,177,917</b>

20. Давхар даатгалын шимтгэлийн орлого

мянган төгрөгөөр	2018	2019
Факультатив давхар даатгал	247,482	<b>82,585</b>
Гэрээт давхар даатгал	191,290	-
Нийт	438,772	<b>82,585</b>

21. Хөрөнгө оруулалтын орлого

мянган төгрөгөөр	2018	2019
<b>Хөрөнгө оруулалтын орлого</b>		
Банкинд байршуулсан хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын орлого	1,623,255	<b>2,413,045</b>
ББСБ-д байршуулсан итгэлцлийн хөрөнгө	89,232	<b>262,274</b>
Үнэт цаасны хүүний орлого болон бусад	535,789	<b>1,058,965</b>
Нийт	2,248,376	<b>3,734,284</b>

22. Ерөнхий ба удирдлагын зардал

мянган төгрөгөөр	2018	2019
Ажиллагчдын цалингийн зардал	2,439,496	<b>2,829,859</b>
Аж ахуйн нэгжээс төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	294,804	<b>303,906</b>
Автомашины зардал	46,420	<b>52,376</b>
Ашиглалтын зардал	3,915	<b>14,191</b>
Бичиг хэрэг, хангамжийн зардал	69,079	<b>120,223</b>
Даатгалын зардал	3,833	<b>3,784</b>
Албан татвар, төлбөр хураамжийн зардал	795	<b>5,000</b>

Засвар, үйлчилгээний зардал	19,977	<b>79,638</b>
Мэргэжлийн үйлчилгээний зардал	341,008	<b>1,138,263</b>
Сургалтын зардал	15,078	<b>61,302</b>
Томилолтын зардал	15,785	<b>67,301</b>
Түрээсийн зардал	188,099	<b>375,536</b>
Уулзалт, арга хэмжээний зардал	249,368	<b>289,419</b>
Шуудан холбооны зардал	157,910	<b>151,029</b>
Элэгдлийн зардал	141,388	<b>119,605</b>
Нийт	3,986,955	<b>5,611,432</b>

## 23. Борлуулалт маркетингийн зардал

мянган төгрөгөөр	2018	2019
Бизнес уулзалтын зардал	20,881	<b>23,574</b>
Борлуулалтын үеийн идэвхижүүлэлт	65,119	<b>84,919</b>
Маркетинг, сурталчилгааны зардал	396,536	<b>493,591</b>
Харилцагчийн халамжийн зардал	125,564	<b>412,172</b>
Нийт	608,100	<b>1,014,256</b>

## 24. Бусад зардал

мянган төгрөгөөр	2018	2019
Найдваргүй авлагын зардал	544,702	<b>575</b>
Алданги, торгууль	6,151	<b>1,029</b>
Хандив	4,274	<b>1,500</b>
Нийт	555,127	<b>3,104</b>

Тайлант онд Компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар 575 мянган төгрөгийн (2018 онд: 544,702 мянган төгрөг) авлагыг найдваргүйд тооцож, бусад зардлаар бүртгэсэн.

## 25. Орлогын татварын зардал

мянган төгрөгөөр	2018	2019
Тайлант жилийн татвар	505,364	<b>665,047</b>
Нийт	505,364	<b>665,047</b>

Хүчин төгөлдөр татварын хувь хэмжээний нэгтгэл нь дараах байдалтай байна:

мянган төгрөгөөр	2018	Хүчин төгөлдөр татварын хувь хэмжээ (%)	2019	Хүчин төгөлдөр татварын хувь хэмжээ (%)
Татварын өмнөх ашиг (СТОУС-ын дагуу)	4,373,621		<b>6,535,635</b>	
10%-аар татварын хувь хэмжээг тооцсон татвар (2018: 10%)	437,362	10%	<b>653,563</b>	<b>10%</b>
Татвар тооцохгүй хэсэг, цэвэр	(136,016)	-3%	<b>(372,772)</b>	<b>-6%</b>
Хойшлогдсон татварын хөрөнгөөр хүлээн зөвшөөрөөгүй түр зөрүү	(2,961)	0%	<b>(1,702)</b>	<b>0%</b>
Тусгайлсан хувь хэмжээгээр тооцсон татвар (2018: 10%)	206,979	5%	<b>385,958</b>	<b>6%</b>
Орлогын татварын зардал	505,364	12%	<b>665,047</b>	<b>10%</b>

## 26. Балансын дараах үйл явдал

Мандал даатгал ХК нь 2019 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 4 төгрөг буюу нийт 2,497,206 мянган төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

## 27. Мэргэжлийн шийдэл бүхий нягтлан бодох бүртгэлийн тооцоолол ба үнэлэмж

Тооцоолол болон үнэлэмжийг байнга хийдэг бөгөөд тухайн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзсэн ирээдүйн үйл явдлын таамаглал, түүхэн туршлага, бусад хүчин зүйлст үндэслэдэг.

### 27.1 Мэргэжлийн шийдэл шаардагдах бүртгэлийн тооцоолол

Компани нь ирээдүйн талаарх тооцоолол, таамаглалыг хийдэг.

#### Нөөц сангийн тооцоолол

“Мандал Даатгал” ХК нь нөөц сан, хохирол нөхөлтийн харьцааг тодорхойлж, учирч болзошгүй эрсдэлээс зайлсхийх зорилгоор СЗХ-ноос зөвшөөрөгдсөн даатгалын нөөц сан байгуулах ангилал болон аргачлалыг ашиглан даатгалын нөөц сангийн хэмжээг тооцдог. Даатгалын нөхөн төлбөрийн нөөц санг Учирч болзошгүй хохирлын нөөц сан (УБНХНС), Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС), Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц (УБНХНС) гэж ангилна.

Аудитын явцад нөөц сангийн тооцооллыг хөндлөнгийн шинжээч-актуарч давтан тооцоолж, шалгасан.

## 28. Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Компани нь санхүүгийн хэрэгслүүдийг ашиглах явцад зарим эрсдэлүүдтэй тулгарч байна. Үүнд зах зээлийн эрсдэл, зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл зэрэг байна.

Компани нь арилжааны зорилгоор санхүүгийн хөрөнгийг мөн опцион худалдаалдаггүй байна.

## 29. Капиталын эрсдэлийн удирдлага

Компани нь цаашид тасралтгүй ажиллах боломжийг хангахын тулд өөрийн хөрөнгөө удирддаг.

Компанийн капиталын бүтэц нь гаргасан капитал, нөөц, хуримтлагдсан ашгийг багтаасан эздийн өмчөөс бүрдэнэ.

## 30. Үүрэг

## 30.1 Капиталаас хүлээх үүрэг

Компани нь 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ямар нэгэн томоохон шүүхийн нэхэмжлэл, маргаангүй байна. Тийм учир компани нь холбоотой талтай холбоотой ирээдүйн капиталын зарцуулалтаас хүлээх үүрэг байхгүй

## 31. Холбоотой тал

Доор тайлбарласанчлан Компанийн холбоотой талуудад толгой компани, хамтын хяналт, удирдлагатай аж ахуйн нэгжүүд орно.

## 31.2 Хяналтын харилцаа

Компанийн 40.85%-ийг “Голомт Файнаншил Групп” ХХК, 36.51%-ийг “Юу Эм Си Капитал” ХХК, 22.64%-ийг олон нийт эзэмшиж, хянаж байна.

“Голомт Файнэншил Групп” ХХК нь 2014 онд үүсгэн байгуулагдсан, санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг хөрөнгө оруулалтын компани юм. Ноён Д. Баясгалан нь тус группийн ихэнх хувийг эзэмшдэг бөгөөд “Мандал даатгал” ХК-д хамгийн дээд хяналт тавигч хувь хүн юм.

## 31.3 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

Тайлант хугацаанд Компани нь дараах ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн байна.

Холбоотой талуудын нэр, мянган төгрөгөөр	Ажил гүйлгээний төрөл	2018	2019
Юу Эм Си Капитал ХХК	Хувьцаа борлуулсан	1,515,741	-
Юу Эм Си Капитал ХХК	Ногдол ашиг олгов.	-	204,138
Голомт файнэншил групп ХХК	Даатгал борлуулав	-	6,899
Голомт файнэншил групп ХХК	Нөхөн төлбөр олгов	-	300
Голомт файнэншил групп ХХК	Ногдол ашиг олгов.	-	229,500
Голомт банк ХХК	Зуучлан борлуулалтын дүн	6,434,128	4,478,921
Голомт банк ХХК	Зуучлагчийн шимтгэлийн дүн	873,156	749,126
Голомт банк ХХК	Даатгал борлуулав	-	595,346
Голомт банк ХХК	Даатгалын хураамжийн буцаалт хийв	-	17,867
Голомт банк ХХК	Нөхөн төлбөр олгов	-	71,398
Голомт банк ХХК	Кастодианы үйлчилгээ авав	-	16,000

Мандал лайф ХХК	Тэтгэврийн сан - авлага	-	20,605
Мандал лайф ХХК	Тэтгэврийн сан - өглөг	-	7,766
Нийт		8,823,025	6,397,866

## 31.3 Төлбөрийн чадвар

Компанийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төлбөрийн чадварын харьцаа 157.63% (2018: 150.62%) байгаа нь Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцоолох журмын 3.12-д заасан “Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 100 хувь буюу түүнээс илүү байвал зохино” гэсний дагуу зохистой байна.

Үзүүлэлт	Дүн	Тооцох хувь	Тооцсон дүн
1	2	3	4
1. Зайлшгүй байх хөрөнгө /1=max(1.1, 1.2, 1.3)/			5,320,808,860.64
1.1 Даатгалын хураамжид үндэслэх /Тухайн тайлант хугацааны нийт орлогод тооцсон хураамж (1.1.1 (4)+1.1.2(4))			5,320,808,860.64
1.1.1 Агаарын хөлөг, авто тээврийн хэрэгсэл, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн орлогод тооцсон хураамж		40%	4,072,717,893.33
1.1.2 Бусад хэлбэрийн орлогод тооцсон хураамж		20%	1,248,090,967.31
1.2 Даатгалын нэхэмжлэлд үндэслэх /Сүүлийн 3 жилийн дунджид үндэслэн/ (1.2.1 (4)+1.2.2(4))			2,093,099,208.01
1.2.1 Агаарын хөлөг, авто тээврийн хэрэгсэл, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн нэхэмжилсэн хохирлын дундаж дүн		50%	1,680,986,410.58
1.2.2 Бусад хэлбэрийн нэхэмжилсэн дүрмийн сангийн доод хэмжээ		20%	412,112,797.43
1.3 Хорооноос тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээ			5,000,000,000.00
2. Нийт хөрөнгө			37,488,747,958.97
3. Зөвшөөрөгдөхгүй хөрөнгө			4,422,165,768.77
4. Зөвшөөрөгдөх хөрөнгө /4=(2)-(3)			33,066,582,190.20
5. Өр төлбөр / 5=Нийт өр төлбөр-ОТХН*10%/			15,788,511,536.02
<b>6. Төлбөрийн чадварын зохистой харьцаа 6=4/(1+5) ≥100%</b>			<b>156.64%</b>

## Мандал Даатгал ХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 14241, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө - 24, Паркплэйс Оффис, 1, 3 давхар  
Шуудангийн хаяг: Ш/х-2772/2292, Улаанбаатар 15160


Утас: (976) 7577 3000

Мэдээлэл, лавлагааны төв: (976) 7575 2000

И-мэйл: info@mandal.mn

Вэб хуудас: www.mandal.mn

 facebook.com/mandaldaatgal

 twitter.com/MandalDaatgal

[www.mandal.mn](http://www.mandal.mn)

